



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-85
<hr/>	
<i>1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/</i>	8-80
<i>2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	80-83
<i>3.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	83-85

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 78.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 27 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, П.Анужин, Ё.Баатарбилэг, Х.Ганхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ц.Сэргэлэн;

Хоцорсон: Х.Болорчулуун -3 цаг 26 минут, Б.Дэлгэрсайхан -24 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1-д “Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт /76/ гишүүний дөрөвний гурав /57/-аас доошгүйн ирцтэй бол түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ” гэж заасныг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танилцуулж, чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын нийт гишүүнээс 59 гишүүн ирсэн байгааг хэлж, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл”-ийн нэг дэх хэлэлцүүлгийг эхлүүлэв.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс ирүүлсэн саналыг танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Д.Ганбат, Ш.Адъяаа, Т.Доржханд, Д.Өнөрболор, Э.Бат-Амгалан, С.Одонтуяа, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, Ц.Туваан, О.Цогтгэрэл, Ж.Чинбүрэн, Б.Баттөмөр, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Б.Жаргалмаа, Д.Сарангэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 14 цаг 45 минутаас 15 цаг 09 минутад хуралдааныг даргалав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар үг хэлэв.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэснийг “зөвшөөрье” гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 2

Бүгд: 61

96.7 хувийн буюу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Хууль зүйн

үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 2

Бүгд: 61

96.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдах болсон тул хуралдаан 17 цаг 28 минутаас 17 цаг 53 минутад түр завсарлав.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:55/

2.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:55/

3.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:55/

4.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:55/

5.“Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:56/

Гурав. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 11
Бүгд: 49
77.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:03/

Уг асуудлыг 18 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Баянхонгор аймгийн Баацагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Г.Тэмүүлэн нарын урилгаар Архангай аймгийн Төвшрүүлэх сумын ахмадууд, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Х.Баделхан нарын урилгаар Хилчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад оролцож буй

Хилийн цэргийн 0165 дугаар ангийн алба хаагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Нийслэлийн Налайх дүүргийн бөхчүүд, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нарын урилгаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Т.Доржханд, Д.Сарангэрэл нарын урилгаар Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын урилгаар Монгол Улсын Их сургуулийн харьяа “Байгаль эх” ахлах сургуулийн 10Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 11 минут үргэлжилж, 73 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 87.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
12 цаг 27 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Ирц 57 гишүүн оролцож, 78.1 хувьтай бүрдсэн байна. Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт оруулах өөрчлөлтийн төсөл, Засгийн газраас 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг.

2-т, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх асуудлуудыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн тогтсон асуудлыг хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал нэмэх, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг уншиж танилцуулъя. 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотой үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Үндсэн хуулийн өөрчлөлт ирж байхад юун дараалал вэ

гэж бодож байж магадгүй. Тэгэхээр энэ Улсын Их Хурлаар хуулийн дагуу хугацаатай хэлэлцэх асуудлууд байдаг. Өөрөөр хэлбэл төрийн төрөөс ирэх оны төсвийн хүрээний мэдэгдлийн асуудлыг 6 сарын 1-ний дотор ярилцах ёстой. Тэрнийг яаж хэлэлцэх юм бэ?

2 дугаарт нь яамнууд Эдийн засгийн яам тэтгэвэрт цалин нэмэх тухай асуудлыг хөндөж байгаа. Энэ асуудлыг яаж хэлэлцэх юм бэ гэдгийг асуумаар байна.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 3 жилийн хугацаанд Монгол Ардын нам 3 удаа хийж байна. Тэгээд энэ хийх болгондоо өөрсдөдөө эрх мэдлийг авч байна. Ялангуяа 2022 оны 8 сард хийгдсэн Үндсэн хуулийн өөрчлөлтөөр давхар дээлийг өөрсдөө авсан. Өнөөдөр гишүүдийн тоог нэмэх замаар асуудалд холбогдсон ЖДҮ, концесс, тендер, Хөгжлийн банк, төмөр замын хулгай, нүүрсний хулгайд холбогдсон энэ нөхөд жагсаалтын ард, дээрээс нь гишүүдийн тоон нэмэх замаар орж ирэх ийм боломжийг өөртөө нээж байна. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг нэмэх болгондоо өөрсдөдөө давуу эрхийг бий болгож байна.

Энэ 2020 оны Их Хурлын гишүүд бол 24 онд очиход бол маш их асуудалтай болсон ялангуяа Монгол ардын намын гишүүд. Тийм учраас энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийж байгаа. Одоо нэг дэх өдрөөс эхлээд Их Хурлын гишүүд тойрогтоо ажиллана. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг яагаад хийж байгаа талаар тайлбарлана. Тэгэхээр нэгэнт ард түмэн энэ гишүүд кнопоороо асуудал шийдэх учраас та нарын саналыг авсан болоод 152-оосоо нэг жоохон хассан болоод энэ асуудлаа шийдэх байх.

Тийм учраас зүгээр нэг зүлгэн дээр гэр бариулахгүй. Ард түмэн очиход нь энэ хүмүүсээс 7 биш 5 жилийн 5 жилээр тэтгэврээ тогтоо гэдэг энэ хуулийг явуулахыг шаард. Дээрээс нь хүүхдийн

мөнгийг 100 хувь болго гэдгийг шаард. 3 дугаарт нь цалин тэтгэврээ нэмж байж Үндсэн хуулийн өөрчлөлтөөр та нар өөрсдөө эрх мэдлээ ав гэж шаард. Энэ гуравхан цаас бариад сууцгаа. Жоохон зардал гарна балаар биччих болохгүй бол. Болохгүй бол манай Ардчилан намын гишүүд тэр хуралд очсон хүмүүст энэ Их Хурлын гишүүдийн хуралд очсон хүмүүст энэ цаасыг нь бэлтгээд өг. Тэгж байж энэ өөрсдөө энэ өөрсдөдөө давуу эрхээ авч байгаа энэ тохиолдолд ард түмэнд бас боломжийг олгоно шүү. Цалин тэтгэврийг нэмнэ шүү, хүүхдийн мөнгийг нь 100 хувь олгоно шүү. Дээрээс нь тэр тэтгэвэр нэмэх тэр боломжийг нь гаргаж өгнө шүү. Тэгж байж энэ Үндсэн хуулийг өөрчлөлтийг явуулъя цөмөөрөө ард түмэн. Энэ дээр бүгдээрээ нэг байр суурьтай байгаарай. Эд нараар нэг зүгээр нэг зүлгэн дээр нь гэр бариулахгүй шүү.

Г.Занданшатар: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд зааснаар хуулиар хугацааг нь заасан асуудлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлэлцэж байх үеэр хэлэлцэж болно. Хойшлуулишгүй асуудлыг. Төсвийн хүрээний мэдэгдэл бол 5 сарын 1-ний дотор өргөн баригдаж 6 сарын 1-ний дотор хэлэлцэн батлах хуулийн хугацаатай учраас энэ хэлэлцүүлэг хооронд хэлэлцэн батлах бололцоотой. Ийм ч учраас Улсын Их Хурал, Засгийн газар бол цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэх асуудлыг судалж, энэ Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгахаар оролцож байгаа. Ийм учраас Пүрэвдорж гишүүн бол үүнд идэвхтэй хамтран ажиллаарай. Одоо харин үндсэн асуудлаа хэлэлцье.

Ингээд Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний буюу 76 гишүүний $\frac{3}{4}$ -аас дээшгүй доошгүйн ирцтэй бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ гэж заасан. Ингээд ирц 59 гишүүн оролцож байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна. Ажлын хэсгийн гишүүд нь ороод ирсэн. Ер нь бол Хууль зүй, дотоод хэргийн сайд л даа ажлын хэсгийн дарга нь. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Барсүрэнгийн Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хяналтыг хэрэгжүүлэх газрын дарга. Энэ маань нөгөө хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ бас давхар хийж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ тийм ээ. Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үүрцайхын Амарбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хууль зүйн Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чойжилсүрэнгийн Ариунхур Засгийн газрын Хяналтыг хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх, Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Нинжбатын Ууганбаатар Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор, Дагва-Очирын Бумдарь Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор, доктор. Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Аубакир гишүүн зочдоо яасан бэ? Сайд нар орж ирье. Монгол Улсын

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийг хэвлэж тараасан байгаа. Пүрэвдорж гишүүн бас аль нэг нам, эвслийн бүлгийн санаачилга, хүсэл зоригоор хийгдсэн ажил биш. Энэ бол 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өөрчлөлтийн үед Ардчилсан намын бүлгийн саналаар бас хэлэлцэж эхлээд, тухайн үед Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн санал агуулгын дагуу Улсын Их Хурлаас Сонгуулийн хуульд ээлжит сонгуулиас нэг жилийн өмнө шинэчилсэн найруулга болон нэмэлт, өөрчлөлт Сонгуулийн хуулийн талаар батлахыг хориглосон учраас энэ асуудал агуулгын хувьд зөрчилдөж байна гэж үзээд дараа хэлэлцэхээр хойшлуулсан юм, хойшлуулсан, дутуу орхигдсон асуудлыг гүйцээж байгаа гэж ойлговол зохино.

Энэ бол тухайн үеийн Ардчилсан намын бүлгийн Ардчилсан намын санал бол явж байгаа. Тухайн үеийн Зөвшилцлийн ажлын хэсгийн бас санал гэж явж байгаа гэдгийг ойлговол зохих нь. Энэ ингээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тараасан. Энэ дээр Журмын тухай хуулийг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу бол бүрдүүлбэр хангачихсан байгаа. Энийг Улсын Их Хурлын дарга энэ Цэцийн дүгнэлтийг бол уншиж танилцуулах, Цэцийн саналыг уншиж танилцуулах ёстой. Ингээд Үндсэн хуулийн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн албан бичгийг уншиж та танилцуулъя. Цэцээс бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэхэд саналаа ирүүлнэ гэж бас заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 1/218 тоот албан бичиг ирүүлсэн. Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтаар бол Үндсэн хуулийн цэцийн хяналтыг хийсэн байгаа. Энийг уншиж танилцуулъя.

Хариу хүргүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар Танаа. Хариу хүргүүлэх тухай. Таны 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Улсын Их Хурал 01/3965 дугаар албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон холбогдох баримт бичгийг хүлээн авч, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нийт гишүүдээрээ зөвлөлдөөд дараах хариуг хүргүүлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2022 онд холбогдох шийдвэрийг гаргасан болно. Энэ асуудлаар. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь, үзэл баримтлалын агуулгад бүрнээ нийцсэн байвал зохино. Хүндэтгэсэн Дарга Чинбат гэсэн байна. Ингээд Үндсэн хуулийн талаас бол ийм Цэцийн бичиг ирснийг танилцууллаа.

Дараа нь бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн үзэл санааг танилцуулъя. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн журмын тухай хуулиар нэг дэх хэлэлцүүлгийг 30 хоногийн дотор явуулна өргөн баригдсанаас хойш. Ингээд 30 хоногийн дотор явуулахдаа нэг дэх хэлэлцүүлэг дээр гишүүд бол 8 минутаас доошгүй хугацаанд асуулт асууна. 10 минутын хугацаанд үг хэлэх ийм зохицуулалттай. Тэгэхээр энийг бол та бүхэн бас заавал цагийн тултал ашиглаж хэрэггүй. Одоо бол нэг дэх хэлэлцүүлгийн дараа бол иргэд сонгогчдын саналыг авч, иргэд сонгогчдынхоо саналыг авч тойрогтоо 7-гоос доошгүй хоногийн хугацаанд ажиллана. Ажлын долоогоос доошгүй хоног хугацаанд ажиллана. Тэгэхээр энэ хагассайн өдрөөс авхуулаад Улсын Их Хурлаас удирдамж гаргаж, материалаар хангаж явуулна. Энэ хагассайн өдрөөс эхлээд ажлын долоо хоног тойрогтоо ажиллаж, иргэд сонгогчдын саналыг сонсох ажиллагаа явуулагдана. Ард түмнийхээ бүрэн эрхт байдал, оролцоог хангана.

Ингээд долоо хоног, ажлын долоо хоног ажиллаж ирээд хоёр дахь хэлэлцүүлгийг хийнэ. Энэ дээр энэ товчхон заалттай асуудлаар бол асуудлаа сайтар нягтлаад, ард иргэдийнхээ санал дээр үндэслээд хоёр дахь хэлэлцүүлгээ хийнэ. Хоёр дахь хэлэлцүүлгийг хийсний дараа ахиад долоо хоногийн, ажлын долоо хоногийн хугацаанд тойрогтоо ажиллаж ирээд сонгогчидтой ер нь зөвхөн тойрогтой төдийгүй мэргэжил сонирхлын бүлгүүдтэйд, төрийн албан хаагчидтай, хуульчидтай, улс төрийн намуудтай, иргэний нийгмийн байгууллагуудтай уулзалт хийж болно, саналыг нь сонсоно. Энэний дараа гурав дахь хэлэлцүүлгийг явуулна. Нэмэлт, өөрчлөлтийн журмын тухай хуулийг товчхон танилцууллаа.

Зочид танилцуулъя. Баянхонгор аймгийн Баацагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Говь хангайн цэнхэр нутаг Баянхонгор аймгийн Баацагаан сум Бөөн цагаан нуур Цагаан ижий гэдэг энэ сайхан нутгаас хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт хурлын төлөөлөгчид та бүхэндээ эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөж, ажилд нь, амьдралд нь аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөе.

Яг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж байхад манай уугуул нутгийн, төрсөн нутгийн маань хурлын төлөөлөгчид оролцон гэсэн байна. Мэдээгүй байсан. Их бэлгэшилтэй юм байна. Та бүхэндээ сайн сайхныг хүсэн ерөөе.

Ингээд хууль санаачлагчийн илтгэлийг Монгол улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монголчууд аа, Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголчууд бид ардчилсан Үндсэн хуулиа баталж, зах зээлийн эдийн засагт шилжиж, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилтыг тунхагласнаас хойш 30 жилийн хугацаа өнгөрлөө.

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ хэмээн заасан байдаг. Ард түмэн энэхүү эрхээ бодитой эдэлж байна уу, ард түмний төлөөлөл иргэдийг үнэхээр төлөөлж байна уу, хүмүүнлэг иргэн төвтэй нийгэм цогцлоох чиг хандлага маань зөв явж байна уу, эдийн засгийн өсөлт иргэдэд хүртээмжтэй байж чадаж байна уу гэсэн асуултыг 30 жилийн заагт ард иргэд маань асууж байна.

Эдгээр асуултын хариулт болсон суурь өөрчлөлтүүдийг цаг алдалгүй хийж чадахгүй бол ард түмэн ардчилсан парламентын засаглалд итгэл алдрах эрсдэл бас байна. Тэгш бус байдал баян, ядуугийн эрс ялгаа, авлигал хээл хахууль, мөнгөнөөс хэт хамааралтай сонгуулийн тогтолцоо, тогтворгүй засаглал, аливаа асуудлыг гал унтраах байдлаар аргацааж, бодит үнэнээс зугтаж ирсэн улс төрийн соёл зэрэг нь төлөөлөлгүй төлөөлөл хэмээх ойлголтыг гүнзгийрүүлж, сонгосон төлөөллөөс өөр төлөөлөл нийгмийг удирдан чиглүүлэх шинэ үзэгдэл үүсэж болзошгүй байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал хүчин зүйлс ч улс орнуудын тэр дундаа хөгжиж буй улс орнуудын засаглал, хөгжлийн чиг хандлага, аюулгүй байдалд томоохон сорилтыг учруулж байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үндэслэл гадаад, дотоод нөхцөл байдлын талаар 3 зүйлийг товч дурдъя.

1 дүгээрт, геополитикийн өөрчлөлт буюу олон туйлт дэлхий. Эх дэлхийн нөөц хомсдож, хүн төрөлхтөнд хүнсний хомсдол, байгаль цаг уурын дулаарал, цар тахал, байгалийн гамшигт үзэгдлийн олон сорилт тулгарсаар байна. Судлаачид дэлхий ертөнц цар тахлын өмнөх үедээ улс төр, нийгэм, соёл, амьдралын хэв маягийн хувьд дахин очих боломжгүй ч байж болохыг онцолсоор байна. Дэлхийн улс орнууд үнэт зүйлийн хувьд хуваагдаж, шинэ хүйтэн дайн үүсэх бодит эрсдэл бий боллоо. Дэлхий дахин зэрэгцэн өөр, өөр үнэт зүйл хүчний харьцаанд хуваагдаж, олон туйлт дэлхий, шинэ дэг журам үйлчлэх сорилттой нүүр тулж байна. Геополитикийн энэхүү нөхцөл байдал багадаа 10-15 жил, цаашилаад 50 болон түүнээс дээш жил үргэлжлэх төлөвтэй байгааг судлаачид анхааруулж байна.

Далайн шуурга дэгдэхэд далай хад 2 мөргөлдөж байна гэж харагддаг боловч шуурга намдахад аль аль нь хэвээр байдаг. Харин далайн амьтад л хад мөргөж эрсэдсэн байдаг. Их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөнд хөгжиж буй улс орнууд л хамгийн их хохирол амсдаг хэмээн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешийн үгийг бид сайтар тунгаах учиртай. Дэлхийн 2 том гүрний дунд оршдог ардчилсан парламентын засаглалтай манай улсын хувьд тусгаар тогтнол, ардчилал, эрх чөлөө, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж, хөрвөх чадвартайгаар хөгжиж чадах эсэх нь энэ цаг үеийн та биднээс ихээхэн ур ухаан, улс төрийн манлайлал, мөн хөрвөх чадварыг шаардаж байна.

Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэдэгчлэн Улсын Их Хурлын төлөөллийн чадамжийг сайжруулж, нийгэм, улс орны тулгамдсан асуудлыг илүү олуулаа хэлэлцэн шийдвэрлэх нь Үндэсний аюулгүй байдалд туйлын чухал алхам болно хэмээн үзэж байна.

2.Нутаг дэвсгэрийн болон нийгмийн төлөөллийг тэгш хангах

зарчмын тухай. 1992 онд Ардын Их Хурлаар шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүний тоо 75-аас 200 хүртэл байх хувилбар яригдаж, эрх мэдлийн төвлөрөл төлөөлөх чадамжийн тухай ярилцаж байсан түүхэн баримтууд протоколд үлджээ. Нэг үгээр хэлбэл иргэдийг төлөөлөх парламентын тооны мэтгэлцээн бол шинэ зүйл биш юм.

1992 онд шинэ Үндсэн хууль батлахдаа Улсын Их Хурлын гишүүдийн тоог тухайн үеийн нийт хүн амын тоонд үндэслэж, нэг гишүүн дунджаар 27 мянган иргэнийг төлөөлөхөөр тооцож, 76 гишүүнтэй байхаар хуульчилсан билээ. Өнөөдөр хүн амын тоо 1992 оноос 1 саяар нэмэгдэж, Улсын Их Хурлын гишүүн дунджаар 45 мянган иргэнийг төлөөлж байна. Улсын Их Хурлын гишүүд нутаг дэвсгэрийн нэгжээс сонгогдож ирснээр улсын төсвийг тойргийн эрх ашигтаа нийцүүлэн батлуулах, сонгуулийн ажилд дэмжлэг үзүүлсэн боловсон хүчнийг төрийн албанд байршуулах, нутгархах үзэл хавтгайрах, сонгуульд мөнгөний хүчин зүйл нөлөөлөх, намын хатуу гишүүнчлэл нэмэгдэх үзэгдлүүд өнгөрсөн хугацаанд давамгайлсаар ирснийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Энэхүү төслийн хувилбарт нутаг дэвсгэрийн болон нийгмийн төлөөллийг тэгш хангах зарчмыг тусгалаа. Эргэх ертөнц арга билигт оршдог. Эргэтэй, эмэгтэй хүйс тэгш байж, нийгмийн тэнцвэр хангагддаг шиг нутаг дэвсгэрийн төлөөлөл, нийгмийн сонирхлын төлөөлөл тэнцвэртэй байж төрийн бодлого зөв бөгөөд бодитоор тодорхойлогдоно. Улс төрийн хүчин Монгол ардын намын хувьд бусад улс төрийн намуудыг төрийн бодлогод оролцуулах боломжийг нээж байгаа нь олон намын тогтоцоо бүхий ардчилсан парламентын засаглалын хөгжилд оруулж буй эрхэм үүрэг хэмээн бид үзэж байна. Бид ганцаар хурдан явахаас илүүтэйгээр олуулаа хол явахыг, дотоод өрсөлдөөнөөс илүү дэлхийн улс

орнуудтай Монгол Улс хөгжлөөрөө өрсөлдөхийг илүүд үзнэ.

3.Эдийн засгийн их үсрэлтийн тухай. Өнгөрсөн хугацаанд бид эхлүүлсэн төсөл олон ч дуусгаж чадсан нь цөөхөн. Дэлхийн их гүрнүүд эх өгөгдөлд тулгуурлаж хиймэл оюун ухааны бодолтойгоор хөгжлийн бодлого, хөгжлийн загвараа урт хугацаанд тодорхойлж байна. Бид шатрын их мастеруудтай пионер мадын нүүдлээр өрсөлдөж чадахгүй нь ойлгомжтой. Тойрог бүрд гишүүн бүхэн төлөвлөлт хийх гэж хичээж, техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зургийн оронд сонгуулийн амлалт, сэтгэл хөдлөлөөр асуудалд хандаж, гоёмсог танилцуулгаар бие биеэ хуурсаар 30 жилийг үдлээ.

Нийслэл хотод 2016 оноос өнөөдрийг хүртэл Улаанбаатар хотыг 2 бүтэн тойрох хэмжээний урттай 1200 орчим километр зам баригдсан боловч дүүрэг дүүрэгт тавигдсан хоорондоо холбогдоогүй мухар замууд бий болжээ. Тойрог тойргийн эрх ашиг улсын хөгжилд хэрхэн сөргөөр нөлөөлдгийн энгийн нэг жишээ бол энэ юм. Монгол Улсын иргэдийн амьдралын чанар эрүүл мэнд, боловсрол, нийгмийн даатгал, цалин, тэтгэврийн нэгдсэн бодлого болон боомт, тээвэр, логистик, аж үйлдвэржилт, эрчим хүч, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэр зэрэг эдийн засгийн томоохон төслүүдийн хэрэгжилтэд хязгаарлах хүчин зүйл болсныг хүлээн зөвшөөрөх ёстой. Хувийн хэвшлийнхэн, хөрөнгө оруулагчид, бодлого нь тодорхойгүй, залгамж чанаргүй, нэгдсэн төлөвлөлтгүй төрийн бодлогоос шалтгаалж хэчнээн хэмжээний боломжийг алдсаныг, ямар хэмжээний сорилттой нүүр тулсныг тоочоод баршгүй.

Өнөөдөр миний бие өнгөрснийг зөвхөн шүүхийг хүсэхгүй байна. Харин өчигдрөөс илүү маргаашийн төлөө энэхүү тогтолцооны өөрчлөлтийг хийх нь зүйтэй хэмээн үзэж байна. Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжиж, уул

уурхайн далд эдийн засаг ил болж эхэлснээр Монгол Улсын эдийн засгийн өсөлт цар тахлын оргил үед -4.6 хувь хүртэл агшсан бол 2023 оны 1 дүгээр улирлын урьдчилсан тооцооллоор 7.6 хувийн өсөлтөд хүрлээ. Экспортын орлого 9.2 тэрбумаас 12.5 тэрбум ам.долларт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүн 43.5 их наядаас 52.9 их наяд төгрөгт хүрлээ. Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн анх удаа энэ оны эцэс гэхэд 5 мянган ам.долларт хүрэхээр төлөвлөж байна.

Улс орнуудын эрчимтэй хөгжлийн гараа нь урагшлан хөгжсөн, уруудан доройтсон улс орнуудын түүхийг судалбал нэг хүнд ноогдох ДНБ 10 мянган ам.долларт хүрснээр хөгжлийн замнал эхэлж, иргэдийн амьдралын чанар бодитоор сайжирч, ардчиллын үнэт зүйлс жинхэнэ утгаараа бэхэждэгийг Азийн бар улсууд мөн хөгжсөн улс орнуудын түүх бэлээхнээ нотолж байна. Энэ өөрчлөлт нь эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн гараа байх боломжтой гэж үзэж байна. Улсын төсвийг тэгишгэн хувааж, гал унтраах байдлаар асуудлыг аргацааж, сонгуулиас сонгууль дамжсан амлалтад тамирдсан тойрогт шүтсэн тогтолцоогоо халж, улс орны хөгжлийг тодорхойлох стратегийн ач холбогдолтой эдийн засгийн томоохон төслүүдээ тогтвортой хэрэгжүүлэх нь ирээдүйн Монголын хувь заяанд нэн чухал юм.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлын гишүүнийг 76-г тойргоос, 76-г хувь тэнцүүлж сонгох Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьж байна. Энэхүү төслийг боловсруулахдаа 2000, 2011, 2015, 2017 онуудад өргөн барьсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийх саналуудад тусгасан хүн амын өсөлтөд нийцүүлэн Улсын Их Хурлын гишүүний тоог тэнцүүлэх төслүүд, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 72

дугаар тогтоолоор батлагдсан Ажлын хэсгээс зохион байгуулсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлэг, Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хяналт тэнцлийг хангах тухай Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 1, 2 дугаар тогтоол, Улсын Их Хурлын гишүүдийн тоог шинэчлэн тодорхойлох, Улсын Их Хурлын гишүүний дэвшилт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан Монгол Улсын Их Хурлын 2022 оны 54 дүгээр тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтийн саналыг судлах сэдвийн хүрээг тодорхойлж, үүнд сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, сонгогчдын төлөөлөх мандатын тоог нэмэгдүүлэх асуудлыг тусгасан Улсын Их Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолоор батлагдан зохион байгуулсан “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний Зөвлөлдөх санал асуулга, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хүрээнд сонгуулийн холимог систем бүхий олон намын тогтолцоотой зөвшилцлийн ардчилалд шилжих, сонгогчдын төлөөлөх мандатыг нэмж Улсын Их Хурлын нэг гишүүний төлөөлөл нөлөөллийн эрх мэдлийг багасгах тухай улс төрийн 21 нам хамтарсан уриалга, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын зөвшилцөлд тулгуурласныг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн энэхүү төсөл батлагдсанаар иргэдийн төлөөлөх эрх 2 дахин нэмэгдэж, Улсын Их Хурлын гишүүнд ноогдох эрх мэдлийн төвлөрөл 2 дахин багасна. Нутгархах, тойрогжих хандлага 2 дахин буурч, улсын төсвийн хөрөнгө оруулалт нийгмийн суурь

асуудлуудыг шийдвэрлэхэд илүүтэй төвлөрөх болно. Сонгодог парламентын мэтгэлцээний соёлд шилжиж, хууль хэлэлцэн батлагдах чанар 2 дахин сайжирна. Парламентын дархлаа 2 дахин нэмэгдэж, аливаа нөлөөлөл өртөх эрсдэл 2 дахин буурна. Улс төрийн намуудын хатуу гишүүнчлэлийн чиг хандлага өөрчлөгдөж бодлогын нам болж төлөвших эхлэл тавигдана. Нийгмийн бүлгүүдийн дуу хоолой 2 дахин нэмэгдэж, хилийн чанадад ажиллаж, амьдарч буй Монголчуудын санал өгөх эрх нээгдэнэ.

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын хяналт, тэнцлийн зарчим хангагдана. Жендерийн эрх тэгш байдлын төлөөлөл, нийгмийн сонирхлын бүлгүүд, багш, эмч, инженер, техникийн ажилтнууд, сэхээтнүүд, малчин, тариаланчид, оюутан залуучууд, ахмад, дунд, залуу үеийнхний алтан хэлхээ бүрдэх мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлдвэрчний эвлэл болон ажилчдын төлөөлөл, нийгмийн цөөнхийн болон бусад төлөөлөл төрийн бодлого тодорхойлоход оролцох чадамж 2 дахин нэмэгдэнэ.

Улсын Их Хурлын дарга Эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн өөрчлөлтийн энэхүү төсөл Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан хувилбараар батлагдвал өмнөх 30 жилийн алдаа оноог залруулж, ирэх 30 жилийг шинээр эхлүүлэх түүхэн реформуудын нэг байх болно.

Монгол Улсын Засгийн газар улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагуудын зөвшилцөл, судлаач эрдэмтдийн олон жилийн зөвлөмжид нийцүүлж, түүхэн цаг хугацааны өмнө эс үйлдэл хийхийг хүсээгүй учраас Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийг ийнхүү өргөн барьж байна.

Гэвч Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, эцэслэн батлах эрх

гагцхүү Улсын Их Хурал түмнээ төлөөлсөн эрхэм түшээд та бүхний гарт байгаа. Та бүхний ирээдүйг харсан мэргэн ухаанд найдаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг түрүүн танилцуулчихсан байгаа. Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Энэ нэг дүгээр хэлэлцүүлэг дээр, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэх журам бол тусгай дэгээр буюу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар зохицуулагдаж байгаа. Тэгээд нэг дэх хэлэлцүүлэг бол хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт хариулт өрнөнө. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Тогтохсүрэн гишүүн өмнө нь байна. Ингээд Сайнхүүгийн Ганбаатар гишүүн. Асуулт, хариулт 8 минутаар явна.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр бид маш чухал асуудлаар ярилцаж байна. Бид ард түмний эрх мэдлийг булааж хулгайлж болохгүй гэдэг байр суурийг илэрхийлье. Үндсэн хууль гэдэг бол гаднаас импортлож оруулж ирсэн санаа байж болно. Анх Джон Локк хэлэхдээ Эзэн хаан хэн нэгэн эрх мэдэлтэй эрх баригчдын юу хэлэх вэ гэдгийг ард түмэн дагаж мөрдөнө гэсэн санаа биш шүү. Нийт ард иргэд хоорондоо зөвшилцөж, ард түмний нийгмийн гэрээ байх ёстой гэдэг л энэ бол Үндсэн хуулийн санаа.

2 дугаарт би та нарт нэг зүйл сануулахыг хүсэж байна. Улсын Их Хурал 840 хууль баталсан. Бүгд Монголын ард түмэнд зориулж. Эрүүгийн, захиргааны энэ олон хуулиуд бол бүгд ард түмэнд зориулсан. Харин ганцхан Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан ард түмний мэдэлд байдаг ганцхан хууль нь Үндсэн хууль. Өнөөдөр энэ рүүгээ бид гар дүрж болохгүй. Энийг 1 дүгээр миний хэлэх гэж

байгаа зүйл гэвэл Журмын тухай хуулийн Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл журам гэж 3 дугаар зүйлээр бид хэлэлцүүлэхийг хүсэж байгаа.

Та нар зүгээр ярьж байна, санал авна, сонсоно, ард түмэндээ сонсоно л гэж яриад байна. Үндсэндээ тэдний юу хүсэж, юу зорьж байгаа хамаагүй болно. Зүгээр л сонсох төдий, санал авах төдий байдлаар асуудалд хандах гээд байна гэж би санаа зовж байна. Хэлэлцүүлэг хийнэ гэж байна. Хэлэлцүүлэг хийсэн дүртэйгээр энэ 76 ард түмний мэдэлд, ард түмний эрх ашигт ноцтойгоор нөлөөлөх гээд байна.

2 дугаарт миний хэлэх санаа. Улсын Их Хурлын 76 гишүүн өөрөө өөрсдөдөө зориулж хууль баталж болохгүй. Журмын тухай хуульд ч гэсэн ийм утга санаа байгаа. Хэрэв бид өөрөө өөрсдөдөө хууль баталж, өөрөө өөрсдийгөө яаж дахин баталгаатайгаар гаргаж ирэх вэ гэдэг дээр санаа зовж хуульд өөрчлөлт оруулах юм бол нийт 76-даа би уриалга гаргаж байна. Та бүхэн энэ өөрсдийнхөө баталсан энэ Үндсэн хуулийг өөрчлөлт оруулж байгаад, 76 дээрээ 76 нэмж та нарын дахин сонгогдох баталгаа нэмэгдсэнээрээ энэ хуулиар өөрсдөө энэ сонгуульд оролцож эрхгүй болчихно шүү. Оролцохгүй байхыг би уриалж байна. Яагаад гэвэл ямар ч тохиолдолд өөрөө өөртөө хууль баталж болохгүй. Нэгэнт өөрөө өөрийнхөө тухай хууль батлах гэж байгаа бол ард нийтийн санал асуулгаар явуулаач.

Ард нийтийн санал асуулга гэдэг бол улсын тусгаар тогтнолтой тэнцүү хэмжээний асуудлыг шийддэг чухал асуудал шүү. Одоо ингээд хэлэлцүүлэг хийх гээд байна. Ард нийтийн санал асуулга байгаасай гэж би хүсэж байгаагаа илэрхийлж байна. Ингээд Джон Локк Эзэн хаанаас, эрх баригчдаас ард түмнээ хамгаалж Үндсэн хуулийн тухай үзэл санаагаа гаргаж байсан бол Америкийн Үндсэн хууль нийт ард иргэд бид гэж эхэлдэг. Нийт ард иргэдийн

шийдвэр гаргах, биднийг сонгодог, бидэнд хариуцлага тооцдог эрх мэдэл рүү Улсын Их Хурал халдаж болохгүй гэдэг ийм байр суурьтайгаар би энийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлж байна.

Миний асуулт ойлгомжтой. Нийт ард иргэдийн санал асуулгаар яагаад, асуулт маань ойлгомжтой шүү. Нийт ард иргэдийн санал асуулгаар шийдэх энэ хуулийн заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаа вэ? Журмын тухай хуулийн 3 дугаар бүлэг 17.1-ээр. Энийг яагаад баримтлаагүй вэ? Баримталж байгаа бол ямар дүрэм журмаар яаж явах вэ?

Г.Занданшатар: Хишигээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн 60, 65 дугаар бүлэг 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 66 дугаар зүйл, 67, 68 Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар бүлэг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг хуульчлан журамлан зохицуулсан байгаа. Энэ журамд зааснаар Монгол Улсын Их Хурлын гишүүдийн $\frac{3}{4}$ -аас доошгүйн саналаар Монгол Улсын Үндсэн хууль түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурал 2 удаа авч хэлэлцэхэд ийнхүү гишүүний $\frac{3}{4}$ -аас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Их Хурлын гишүүд шинэ бүрэлдэхүүн эхэлтэл дахиж авч хэлэлцэхгүй гэсэн дэгтэй.

Өөрөөр хэлбэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 2 үндсэн арга хэрэгсэл байгаа Ганбаатар гишүүнээ. 1 дүгээрт саяын миний хэлж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлд заасан нийт гишүүдийн $\frac{3}{4}$ -аас доошгүйн саналаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг авч хэлэлцэх дэгтэй нэг журамтай.

Нөгөө байгаа бидэнд байгаа боломж бол ард нийтийн санал асуулга

явуулах. Ард нийтийн санал асуулгын дүнг Улсын Их Хурал ёсчлон батлах гэсэн ийм 2 үндсэн арга хэрэгсэл байгаа.

Өнөөдрийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа энэ харилцаа хэдийд үүссэн бэ гэхээр 22 оны Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 01, 02 дугаар тогтоолууд гарсан. 01, 02 дугаар тогтоолуудыг үндэслэж, Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолыг та бид бүхэн хамтдаа баталчихсан. 54 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, сонгуулийн дэвшилтэт тогтолцоог бий болгосон Үндсэн хуулийн төсөл боловсруулж ирэхийг Улсын Их Хурал, Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурлаас даалгасан 54 дүгээр тогтоолын хүрээнд энд сууж байгаа ажлын хэсэг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, өнөөдөр та бүхэнд танилцуулж байна. Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт нэг ийм зохицуулалт байдаг. Энэ нь юу гэхээр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно гэсэн ийм Үндсэн хуулийн зохицуулалттай. Энэ зохицуулалтын дагуу 22 оны 01, 02 дугаар тогтоолууд гарсан. 01, 02 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх хүрээнд саяын миний дурдаж байгаа Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол 22 онд гарч, тэр 52 дугаар тогтоолын хүрээнд өнөөдөр бидний өргөн бариад байгаа Улсын Их Хурлын гишүүдийн тоог 76-г мажоритар, 76-г пропорциональ тогтолцооноос сонгогдож бүрдэнэ гэсэн энэ Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт оруулж байгаа нэмэлтийн төслийг та бүхэнд танилцуулж байгаа. Саяын таны хэлж байгаачлан ард нийтийн санал асуулга явуулах, Үндсэн хуулийн реформ хийх энэ асуудал бол нээлттэй байгаа.

Гэхдээ эрх баригч улс төрийн хүчин юу гэж үзсэн бэ гэхээр нэг нам дийлэнх олонхыг бүрдүүлж байгаа парламентын тогтолцооны үед Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн олон реформуудыг хийх нь таны хэлж байгаагчлан нийгмийн зөвшилцлөөс ангид зүйл болох учраас Цэцийн шийдвэр, Улсын Их Хурлын тогтоолын дагуу энэхүү тогтоолыг оруулж ирж, өргөн бүрэлдэхүүнтэй парламенттай болох уу, үгүй юу гэдгийг Их Хурлын гишүүдээрээ шийдүүлэе.

Дараагийн бүрэлдэх парламент нь өргөн бүрэлдэхүүнтэй парламент цаашид нийгмийн зөвшилцөл, нийгмийн гэрээгээ өөрчлөх үү, үгүй юу гэдгээ шийдэх эрх нь шинэ парламентад үлдэх ёстой гэдэг ийм агуулгаар өнөөдрийн төслийг өргөн барьж байгаа.

Г.Занданшатар: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар энэ асуудал хоёр дугаар хэлэлцүүлэг дээр яригддаг юм. Гурав дугаар хэлэлцүүлэг дээр бас яригдаж болдог. Улсын Их Хурлын гишүүдээр батлах уу, Ард нийтийн санал асуулгаар. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Ингээд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр ингээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг эрх барьж байгаа нам буюу Монгол Улс Монголын Ардын Намын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд оруулж ирж байна. Тэгээд Засгийн газраас бол чиглэл өгсөн, Засгийн газарт чиглэл өгсөн Улсын Их Хурлаас. Энэ дагуу ажиллаад энэ тоог, энэ тогтолцоог оруулж ирлээ гэж ойлголоо.

Энэ 152 гэдэг тоо хаанаас юунаас гарч ирсэн тоо вэ, хэр үндэслэлтэй юм бэ? 76, 76 байх нь Монгол Улсын хөгжилд, Монголын ард түмний төлөөлөх энэ юманд хэр зэрэг нийцэж байгаа вэ? Яагаад 76, 76, яагаад 152 гэсэн тоо байна гэж асууж байгаа.

Нөгөө талаар бол энэ Үндсэн хууль бол Монголын ард түмэнтэй байгуулсан гэрээ. Алганд багтсан эх орон гээд л ингээд ярьдаг л даа. Тэгээд өмнө нь хийсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 2022 оны 8 сарын 29-нд хийсэн байгаа байх. Энэ хуулийн өөрчлөлт маань яг хууль номынхоо дагуу явж чадсан уу? Баахан улсууд давхар дээлтэй болоод, давжаа парламентад ийм том засгаа Засгийн газартай болсон. Энэ алдаагаа засахын тулд энэ төслийг оруулж ирж байна л гэж ойлгож байна. Нэлээд олон л юм яриад байна л даа. Гол юм нь. Ер нь Ванга шиг хэлчихье. Ванга шиг хэлчихье гэдгийг би л хэлж байсан юм л даа. Энэ өөрчлөлтөө хийхдээ та нар хэр зэрэг тийм итгэл үнэмшилтэй байна вэ гэсэн ийм асуулт байгаа.

Нөгөө талаар бол 2024 оны сонгууль явагдана. Хэрэв энэ өөрчлөлт чинь явж чадахгүй бол хуучнаараа үлдвэл та бүхэн маань хариуцлага хүлээнэ. Юун 2008 оны 7 сарын 1. Магадгүй тэрнээс долоон дор юм болж мэднэ. Энэ 8 жил та бүхэн маань 62, 65 суудалтай явсан. Тэр ард түмний хүсээд байсан амьдралыг Монгол Улсыг хөгжүүлж чадсангүй. Энэ 8 жил гэдэг бол бүхэл бүтэн 25 жил нэг үе гэж ярьдаг. Энэний бараг 50 хувь нь өнгөрчихлөө.

Өнөөдөр бүтэж байгаа болж байгаа юм юу байна. Баахан л хулгайчтай, дээрэмчидтэй ингэж ноцолдсон ийм л юм явж байна. Би энийг бол зөв гэж бодож байгаа. Энийг бол дэмжиж байна. Хулгай хийж, луйвардаж, ард түмнийг нэг хохирооно. Тэр хулгай хийж луйвардсан хүмүүстэй хуулийн хариуцлага тооцохгүй байж нэг хохирооно. Ингэж 2 дахиж ард түмнийг хохироодог байхгүй юу. Энэ дээр ажиллаж байгааг бол дэмжиж байна би та бүхнийг.

Нөгөө талаар бол цаашидаа энэ улс орны хөгжил маань хаашаа явах юм бэ, ямар байх юм бэ? Дараагийн 30 жилийг тодорхойлж байна гэж ярьж байна. Энэ өнгөрсөн 8 жил бол ер нь бараг Азийн

гөлөг улс болж байгаа тиймэрхүү л юм руугаа явж байсан. Энэ өөрчлөлтөөр Азийнхаа хөлөг улс руу явах энэ юм чинь боломжтой байж чадах уу, үгүй юү? Өнөөдөр Үндсэн хууль маань цагаан цаасан дээр бичсэн тунхаг маягтай л байна шүү дээ. Бид нар Үндсэн хууль дээр бол дайныг эсэргүүцнэ гээд биччихсэн байгаа. Түрэмгийлэгчдийг бол. Гэтэл яаж байна вэ өнөөдөр. Дайныг эсэргүүцээд жагссан залуучуудыг амыг нь хааж байна шүү дээ. Энэ цагдаа хуулийн байгууллага чинь ард түмний талд үйлчилдэг юм уу эсвэл тэр дайныг дэмждэг талд үйлчилдэг юм уу? Татвар төлөгчдийн мөнгөөр цалинжчихаад, Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх хэрэгтэй шүү дээ. Үүрэгтэй шүү дээ. Гэтэл тэр дайныг Үндсэн хуульд заасан эрхээ эдлээд, үгээ хэлээд, үзэл бодлоо илэрхийлээд дайныг эсэргүүцэж байгаа хүмүүсийг яагаад барьж хориод байдаг юм бэ? Дайныг дэмжээд байдаг улсуудыг барьж хорихын оронд. Яагаад ийм юм хийгээд байдаг юм. Хуулийн дагуу л байна.

Манай гадаад бодлого нэг цонхоор байх ёстой гэж байгаа. Дандаа л түдгэлзсэн санал өгдөг байсан. Харин сүүлийн нэг санал дээр Оросын Холбооны Улсыг түрэмгийлэгч мөн гээд та бүхэн дэмжиж санал өгөв үү? Өмнө нь яагаад тэгээд байдаг байсан юм, одоо яагаад ингэж байгаа юм бэ? Аль нь Үндсэн хуультайгаа нийцэж байгаа юм гэсэн ийм асуултуудыг би тодруулъя гэж бодож байна.

Ер нь бол цаашидаа нүүрсний хулгайчид, Хөгжлийн банкны хулгайчид, энэ төмөр зам чинь хэзээ орох юм бэ? Хэзээ хил холболтын цэг нь холбогдох юм бэ? Энэ ард түмний амьдрал чинь хэзээ дээшлэх юм бэ? Мухар зам, мухар төмөр замтай ингээд суугаад байх юм уу, яах юм бэ?

Би бол Үндсэн хуулийн энэ нэмэлт, өөрчлөлтийг бол ер нь бол агуулгаар нь бол 2015 оноос удаа дараа манай Ардчилсан нам дэмжиж ингэж явж

байсан. Ер нь бол тоо тогтолцоо, тэр хувь дээрээ л ярих ёстойгоос биш дэмжиж байна. Та нарыг бол аргагүйн эрхэд ороод л энэ өөрчлөлтийг оруулж ирж байна л гэж ойлгож байна. Харин ч 8 жил болоход энэ өөрчлөлтөө эртхэн хийж байх ёстой байсан. Тэгээд хариултаа авчхаад, асуугаад хариулаад явчихъя.

Г.Занданшатар: Зочид эхлээд танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Ёндонпэрэнлэйн Баатарбилиг нарын урилгаар Архангай аймгийн Төвширүүлэх сумын ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төвширүүлэхийн сангийн аж ахуй гэж түмэндээ нэртэй хүндтэй, төрдөө үнэлэгдсэн том сайхан сангийн аж ахуй, атрын сангийн аж ахуй байсан. Тэгээд тэнд зүтгэж байсан энэ ахмадууд та бүхэнд Архангай аймгийн гишүүд, Архангайгаас гаралтай манай Дамбын Батлутаас авхуулаад олон гишүүд байна. Ингээд нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. Асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Бид нар эхлээд нэг ийм зарчмын хувьд нөгөө яг ийм бодитой байдлаа үнэнээр яриад, тэгээд илүү тийм үнэн байж сурах бас нэг ийм шаардлага байна. Өрөөнд уулзахаараа ингээд өөр энэ маань зөв шүү дээ л гээд байдаг. Тэгээд энд орж ирээд ярихаараа ер нь буруу ч юм биш үү гээд л. Тэгээд бид нар хиймээр байна л гээд байдаг. Тэгээд тэгье гээд тэгэхээр үгүй яагаад хийгээд байгаа юм бэ л гээд ингээд байдаг. Тэгээд би хэлсэн шүү дээ. Тэгээд ер нь олон намыг парламентад оруулж ирэх нь энэ геополитикийн үед бол бас зөв байна.

Нөгөө талаараа энэ том мажоритар тогтолцоогоор байхаар бас бусад улс төрийн намуудад хүндрэлтэй ийм нөхцөл байдлууд бас байна. Тийм учраас энэ сонгуулийн тогтолцоог

нээгээч, илүү хаалгыг нээж өгөөч бас боломжийг бүрдүүлж өгөөч л гэдэг ийм саналыг л манай улс төрийн намууд тавьж, бүгдээрээ л шийдвэрээ гаргаад л, бид нар оруулж ирээд л хэлэлцэж байгаа шүү дээ. Тэгэхээр хэдүүлээ энэ дээрээ тал талдаа л үнэхээр шаардлагатай байвал үнэнээ хэлээд л, иргэддээ очиж тайлбарлаад л, яагаад чухал юм, яагаад Ардчилсан нам өмнө нь олон удаа оруулж ирсэн юм, яагаад 5, 6 удаа энэ талаар хэлэлцсэн юм гэдгээ яриад л явмаар байгаа юм.

Тэгэхгүй тэгээд ингээд нэг ийм дотроо хүсээд байдаг, гаднаа нөгөө хүсээж байгаагаасаа ичээд, нөгөөдхөө ингээд үгүй шүү дээ би уул нь үгүй гээд ингээд нэг тайлбарлаад нөгөө хүний гараар могой бариулах гэдэг шиг нэг ийм агуулга руу ингээд яваад байхаар том өөрчлөлт хийгдэхгүй л дээ. Гэхдээ иргэд сонгогчид маань их хэрсүүжиж байгаа даа. Хэн нь худлаа яриад байна, юу болоод байна бүгдийг нь л анхаарч хардаг, ойлгодог болчихсон.

76, 76 гэдэг энэ үндэслэлийг тайлбарлая. Ер нь бол энэ бол бодлого илүү тойрог талаасаа бид нар чинь ингээд 76 гишүүд маань шууд тойргоос сонгогдож байгаа юм. Ингэхээр тойрог талаасаа харах магадлал илүү өндөр байгаа юм. Тойрог талаасаа харах магадлал илүү өндөр. Нийгмийн төлөөлөл буюу нийгмийн төлөөллийн дуу хоолой болохоор тойргуудад хуваагдчихаж байгаа юм. Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудал гэхэд тойрог, тойрог дээр байгаа тухай тухайн асуудлыг л илүү үзнэ гэсэн үг. Үндэсний хэмжээнд гаргаж ирэх энэ сегментийн дуу хоолой тойрогт хуваагдаад багасчхаж байгаа юм.

Тэгэхээрээ энэ маань тэр төлөөллөөр дамжуулж, тэр төлөөллийг бид нар парламентад оруулж ирэх ийм бодлогын мэтгэлцээний өрсөлдөөн л гэсэн үг. Тэрнээс биш дарга нар нь заавал орж ирж жагсаад байдаг зүйл бас биш. Энэ нөгөө хувь тэнцүүлэх. Ингэснээрээ

санал гээгдэхгүй, ингэснээрээ бүх иргэд санал өгч байгаа төлөөлөл нь толины тусгал мэт парламентад харагдаж байж, парламентын төлөөллийн чадавх сайжирна гэсэн үг. Энэ агуулгаараа тойргийн өнөөдрийн байгаа тогтолцоо дээр нэмээд 2 дахин буюу яг адилхан тэнцүү тоогоор нэмээд төлөөллийг нь 50, 50 болгочихъя.

Жендер ч гэсэн би боддог. Энэ эмэгтэйчүүдийг улс төрд оруулах гээд байгаа юм биш. Зүгээр л энэ гарч байгаа бодлого нь тэнцвэртэй байх энэ боломжийг л хангах гээд байгаа юм. Аль нэг хүйс тэнцвэртэй байж л одоо айл гэр нэг дүүрэн байдаг шиг парламентад ч гэсэн хүйсийн тэнцвэртэй байдал хангагдаж байж л энэ маань өөрөө илүү тийм бодитой болно. Магадгүй жендерийн тэгш байдал хангагдаж ирсэн бол өнөөдөр хүүхдийн тоглоомын талбай дээр байшин бариад л, 3 дугаар эмнэлгийн нүүрийг хаатал газар олголт хийгдэхгүй ч байсан байж магадгүй. Энэ бол бас ингээд тэгш бус байдал бий болсны нэг бүрэлдэхүүн байж болно.

Түүнтэй адилхан зөвхөн тойргоор биш, тойргоо төлөөлж байгаа, хувь тэнцүүлж төлөөлж байгаа төлөөлөл 50, 50 хувь байх нь зөв юм л гэдэг энэ л агуулга. Энэ тохиолдолд бол бодлогын тийм нэлээн тийм том хэмжээний өөрчлөлт гарна. Энийг бол та өөрөө бас их сайн мэдэж байгаа.

Ардчилсан нам энэ саналыг дэвшүүлсээр ирсэнд би хувьдаа бол талархдаг. Та хэдийн 14, 5 жилийн хугацааны нөр их хөдөлмөр дээр тулгуурлаж, өнөөдөр бид нар энэ асуудлыг ярьж байна. Тэгэхээр одоо бол та үнэн байх ёстой. Үнэхээр л Ардчилсан нам дэмжсээр ирсэн юм бол дэмжээд л явах ёстой. Тэгэхгүй Ардчилсан нам оруулж ирэхээр зөв, Ардын нам оруулаад ирэхээр буцаад буруу болчихдог ийм байдлаар ингээд улс төр хийгээд байхаар дахиад л бид нар ингээд нөгөө нэг тийм харамсалтай 30 жилийнхээ чөтгөрийн

тойрог дотроо үлдчихэж бас магадгүй юм гэдэг энэ агуулгаар хэлье.

Мэдээж улс оронд геополитикийн сорилтууд байна. Энэ дээр манай улсын хувьд бас их бодолтой, нухацтай хандах ёстой. Манай гадаад бодлого. Энэ агуулгаараа л бидний хувьд хандаж байгаа юм.

Харин ч одоо энэ өнгөрсөн цаг хугацаанд манай төрийн бодлого ийм нэгдмэл биш байсан бол магадгүй тан шиг ингэж үсчсэн ийм шийдвэр гаргасан бол манай улсын гадаад бодлого, геополитикт нэн эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхийг бол бас үгүйсгэх аргагүй шүү. Тэгэхээр бид нарын хувьд аливаа асуудалд нэг тийм сэтгэл хөдлөлөөр хандахаас илүүтэйгээр илүү нухацтай, аливаа асуудлыг их тийм олон талаас нь хараад, их тийм тогтвортой бодлоготой л явахгүй бол болохгүй байна. Би сая үгэндээ хэлсэн. Манай урд хөршөөс эхлээд дэлхийн томоохон улс орнууд хиймэл оюун ухаан дээр шийдэл гаргадаг болчихжээ. Ийм эх өгөгдөлд тулгуурлаад.

Гэтэл бид нар ингээд л нөгөө нэг ярьж байгаа, шийдвэр гаргаж байгаа маань ер нь нэг ингэвэл яасан юм гээд л, нэг хүнтэй уулзахаараа ингэвэл яасан юм гээд л. 2 хүнтэй уулзахаараа амьдрал онцгүй байгаа ч юм шиг, 3 хүнтэй уулзвал амьдрал сайн байгаа ч юм шиг нэг ийм сэтгэл хөдлөлөөр явсаар байтал бид нар нэг тийм шатрын их мастеруудтай пионер мадын нүүдлээр өрсөлдөөд байгаа нэг ийм гэнэн нэг ийм нөхцөл байдал руу орчихоод байна. Тэгэхээрээ бидний хувьд бодлого илүү тогтвортой, хамтдаа тэр авлигын хэрэг гээд яривал олон зүйл нь их төвөгтэй нөхцөл байдалтай л тулна. Тийм ээ, та тэрийг сайн мэдэж байгаа. Танайхантай илүү холбоотой. 17 хувийн өсөлттэй байсныг аваачаад үрэн таран хийчихсэн энэ 10 хэдэн жилийн алдааг засах гэж ийм л хугацаа орж байна. Хөгжлийн банкнаас авхуулаад энэ олон асуудлууд.

Гэхдээ би энийг нэг их ярьдаггүй шүү дээ. Яагаад гэхээр өнгөрснийг хараар будлаа гээд өнөөдөрт нэг их тийм үр дүн гарахгүй. Өнөөдөр дээрээ бид нар дүгнэлт хийгээд, ирээдүй л зөв байх ёстой. Бид нар хамтдаа дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянган ам.доллар байх энэ зүйлийг л урд талдаа тавиад л, хэдүүлээ хамтдаа дайрмаар байгаа юм. Том төслүүдээ хэрэгжүүлээд. Тэрнээс биш хэн нь аль нам байна вэ, аль намын яасан байна вэ гээд л ингээд л доороо эргээд байвал, доороо эргээд л байна. Ийм агуулгаар та бас хандаасай туршилагатай парламентач хүний хувьд бас танкчин хүний хувьд бас жоохон эх оронч байгаад, тэгээд нэг тийм аливаа асуудалд нэг тийм хөөрөөд байлгүй, жоохон ул суурьтай хандаад, цэгцтэй мэргэн байхын өлзийтэй сайхан ерөөлийг өргөн дэвшүүлье эрхэм ахад.

Г.Занданшатар: *Дашидондогийн Ганбат гишүүн.*

Д.Ганбат: *Ингээд Ерөнхий сайд бид 2 ингээд халиад явчихдаг юм бас. Намайг танкчин гээд дуудаад. Би тэгэхээр бас та сумын төвд жижүүр хийж байгаад л бас Ерөнхий сайд болно гэдэг чинь бас л мундаг шүү дээ л гэж хэлмээр байгаа юм. Тийм. Бас хугацаа бага юм чинь. Юу яая Ерөнхий сайдаа. Та энэ өргөж барьж байгаа, та юу шүү дээ 200, 300 намын дарга. 65, 62 суудалтай намын дарга, Ерөнхий сайд хүн. Өнөөдрийн оруулж ирсэн энэ төсөлдөө итгэл төгс байна уу?*

Тэгээд энэ чинь хэрэв яг энэ маягаараа батлагдаж чадахгүй тоо тогтолцоо нь жоохон нааш цаашаа боллоо гэхэд дараа нь бас нөгөө юмаа ярих уу? Энэнээс болоод л бид нар болсонгүй шүү дээ. Та нар ингээд энүүгээр нь баталж өгөхгүй байсаар байгаад л бид нар чинь аймаар их судалгаа хийгээд аймаар их юм уншаад их олон хүн ажиллуулж байж гарцаагүй юм оруулж ирсэн. Гэтэл та нар ийм болгочихлоо. Үгүй ээ та нар 62 кноп байгаа шүү дээ. Юу дуртайгаа л хийх

ёстой шүү дээ. Тэгээд дараа нь хариуцлагаа үүрэх ёстой шүү дээ. Би тэгж ойлгоод байна.

Үнэхээр улс орныг тэр 30 жилээр нь харж байгаа юм өнгөрсөн юу билээ. Та нар чинь улс төрийн ууган хүчин. Азийн анхны нам мам гээд л яриад байдаг биз дээ? Тэгээд нэг өнгөрсөн 30 жилээ ирээдүйнхээ 30 жилийг харчих юм байгаа биз дээ? Би харж байна.

Хэрэв наад өөрчлөлтөө энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж чадаагүй чадахгүй 2024 оны сонгуулийн дараа дараа Монгол Ардын нам арчигдана байхгүй болно. Би бараг тэрэнд эргэлзэхгүй байна. Та бас ярьж байхдаа Ардчилсан нам гээд л оруулаад л ярьчих юм. Уул нь Үндсэн хууль ярьж байхад. Тэгээд би бас аргагүй л ярилаа. Арга ч үгүй байх даа манай 2 нам л энэ Монгол Улсын 2 тулгуур багана хариуцлага хүлээх хүмүүс. Тэгээд арай л бид нар карманы нам болчихоогүй л явж байна. Бусад намууд шиг. Болохгүйн төлөө л ингэж ярьж байна. Тийм энэ улс эх орны эрх ашгийн төлөө. Тэгэхээр тантай бас санал нэг байна аа. Танкчин нь.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна аа.

Л.Оюун-Эрдэнэ: Хоёулаа скаутуудын хажууд маргалдаад яах вэ. Тэгэхээр Үндсэн хууль өөрөө зөвшилцлийн баримт бичиг гэж та хэлсэн. Бид нар ямар нэгэн байдлаар Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг ялангуяа парламентын төлөөлөлтэй холбоотой асуудлыг нэг нам дангаар шийдэж батлахгүй ээ. Энэ дээр Ардчилсан нам болон бусад намууд эсрэг байвал бид нар төслөө аль ч хэлэлцүүлгээс татаж авч болно.

Тэгэхээр энэ агуулгаараа ч Засгийн газраас өргөн барьсан. Яагаад гэхээр ийм боломж нээлттэй байгаа учраас. Энийг бид нар 40 гаран хоногийн хугацаанд

хамтдаа ярилцана, шүүн хэлэлцэнэ. Энэ маань зөв гэдэг ийм нийгмийн дэмжлэгийн тэнцвэр дээр очвол бид нар батлаад явна. Үгүй бол өнөөдрийн хэлэлцүүлэг магадгүй дараагийн хийх парламентад судалгааны баримт болоод бас үлдэж бас болно. Энэ дээр бид нарын хувьд нээлттэй байгаа гэдгээ танд бас хэлье. Зөв гэж үзэж байгаа бол та ч гэсэн бас хоёрдмол салаа утгагүйгээр зөв гэдэг талдаа үндэслэлээ тайлбарлаад ингээд явах нь чухал болов уу гэсэн ийм бодолтой байна.

Би бас сая үгэндээ хэлсэн Монгол Ардын намын хувьд ганцаараа хурдан явахаас илүү олуулаа хол явахыг илүүд үзнэ гээд. Тэгэхээрээ бид нар урьд нь бас бид нар ч гэсэн ийм хуваагдлын хүндрэлтэй зүйл болж байсан. Шүүх дээр нөлөөлөөд тухайн үед Ерөнхийлөгч байсан хүн манай намыг 2 хуваачхаж байсан. 12 жилийн хугацаа болсон. Институцийн хувьд асар их хэмжээний хохирол учирсан. Та нар тэр хуваасан намтайгаа зөвшилцөх гэж явж байгаад Алтанхуяг даргын Засгийн газрыг унагаасан. Тэрнээсээ болж сонгуульд маш хүндрэлтэй нөхцөл байдалд орсон 17 хувийн эдийн засаг 0 хувь руу орж байсан.

Бид энэ алдааг давтахыг хүсээгүй.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяагийн урилгаар Скаутын холбооны багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт скаутчууд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлага спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Ахиад байхгүй 2 минутаар та асуучихсан.

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж байна. Монгол Улс ардчилсан парламентын засаглалд шилжээд 30 гаруй жилийн түүхийг бид хамтдаа үзэж байна. Энэ 30 гаруй жилийн түүхэнд олон улс орны улс төрийн амьдралтай холбоотой, улс төрийн тогтолцооны асуудалтай холбоотой шийдвэрүүдийг Улсын Их Хурал хэд хэдэн удаа гаргаж байсан. Түүний нэг нь өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тогтолцооны асуудлыг бид өнөөдөр хэлэлцэх гэж байгаа юм.

Үндсэн хууль гэдэг энэ бичиг баримт бол үндэсний зөвшилцлийн бичиг баримт байдаг гэж Үндсэн хууль судлаачид ярьдаг. Ийм ойлголттой явж байгаа. Монгол Улсын Засгийн газар Үндсэн хуулийн өөрчлөлтийг оруулж ирэхдээ энэ 30 жилийн алдаа оноо түүний дотор Монголын улс төрийн амьдралд болж байгаа Монголын нийгэм, эдийн засаг ард түмний амьдралд болж байгаа энэ асуудлуудад бас дүгнэлт хийхийг хичээж засаж залруулахыг хичээхийг оролдсон учраас өнөөдөр энэ асуудлыг Улсын Их Хурал дээр оруулж ирж хэлэлцүүлж байгаа гэж ойлгож байна.

Энд 2 үндсэн зарчмыг миний хувьд нэлээн сайн хэлэлцэх ёстой гэж бодож байгаа. Энэ асуудал хэн нэгэн намын улс төрийн шийдвэрээр шийддэг биш хэн нэгэн намын улс төрийн бодлогоор биш, энэ ард иргэдтэйгээ, ард түмэнтэйгээ бас энэ бодлогоо танилцуулж шийдэх ийм шийдлийг олох ёстой гэж ойлгож байгаа.

Энд шүүмжлээд байвал олон асуудал байна. Бид энийг ард иргэдтэйгээ хэлэлцэж, улс төрийн намууд, ард түмний төлөөлөл бид сайн ярилцаж байж энэ тогтолцоонд болсон гажгийг л бид арилгая гэж явж байгаа гэж ойлгож байгаа.

Энэ засгийн эрх мэдэл авах ард түмний төлөөллийн асуудал ямар байх, улс орны ирээдүйд Монголын Улс төрийн төлөвшлийн асуудал ямар байх тухай асуудлыг бид өнөөдөр ярих ёстой. Тэгэхдээ би энэ асуудлаар санал нийлэх ч асуудал байна, санал нийлэхгүй ч асуудал байна.

Санал нийлэх гол асуудал өнөөдөр энэ геополитик, дэлхий нийтийн улс төрийн нөхцөл байдал, энэ их гүрнүүдийн бодлого, эдийн засагтай холбоотой үүсэх ирээдүйн Монгол Улсын тусгаар тогтнолын асуудалтай холбоотой энэ өөрчлөлийг хийх нь зайлиггүй гэж бодож байгаа. Бид парламентын гишүүдийн тоог 152 гэдэг энэ асуудлыг ярихаас илүү энэ пропорциональ тогтолцоо, мажоритар тогтолцооны харьцааг бид бас ярих ёстой.

Би бол тэр 152 гэдэг тоог бол дэмжихгүй байгаа. Гэхдээ өнөөдөр энэ парламентын пропорциональ тогтолцоог зайлиггүй орж ирэх ёстой гэдэг дээр санал нэг байгаа. Их Хурлын гишүүдийн өнөөдрийн энэ тоог яагаад нэмэх гэж байгаа юм гэхээр Монгол Улсын тусгаар тогтнолын асуудалтай холбогдуулан нэмэх гэж байгааг ойлгож байгаа. Үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбогдуулж олон нам, олон ургалч үзлийн зөвшилцөл дээр шийдвэр гаргадаг энэ тогтолцоог шийдэхийн тулд өнөөдрийн Үндсэн хуулийн өөрчлөлтийг оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа. Ийм учраас энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн явцад ард иргэдийнхээ санал бодол тэдгээрийг тулгуурлаж энэ улс төрийн намууд түүнчлэн парламент суудалтай улс төрийн хүчнүүд энэ дээр нэн хариуцлагатай ярьж энэ асуудлыг нэг тийш болгох ёстой. Бид гацаанд орсон. Улс төрийн төлөвшлийн хувьд гацаанд орсон. Эрх мэдлийн төлөвшлийн хувьд гацаанд орсон. Энэ гацааг гаргах ёстой. Энийг ард түмэндээ бид ойлгуулах ёстой. Тэрнээс биш бид өнөөдөр энэ эрх баригч намын оруулж ирсэн энийг үг

дуугүй гар дуугүй гар өргөнө гэдэг асуудал биш ээ.

Бид энийг шийдэхгүйгээр, энийг сайн хэлэлцэхгүйгээр хаашаа явах юм. Гацаанд орсон шүү дээ. Төрийн ордондоо ч гацаанд орсон. Нийгмийн төлөөлөл дотроо ч гацаанд орсон. Гудамжиндаа ч гацаанд орсон. Ард түмний амьдралдаа ч гацаанд орсон. Иргэд маань өнөөдөр төрд итгэх итгэл алдарсан. Энийг бид шийдэх ёстой, ярих ёстой. 2. 3 дахь хэлэлцүүлгийн явцад энэ нэг шийдэл гарах ёстой байх аа. Надад энэ асуудалтай холбоо асуулт байхгүй.

Би зүгээр үг хэлж байгаа юм. Энэ асуудлыг бид улс төржиж хэн нэгэн хүний суудлыг буцааж энэ Их Хуралд сонгогдохын төлөө ийм хуулийн өөрчлөлтийг хийнэ гэж байгаа гэдэг энэ нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх гэдэг асуудал дээр бодитой, баримттай шийдлийг ард иргэдэд сонголт өгөх ёстой шүү өгөх ёстой шүү. Ийм байдлаар бид нар ингээд ийм шийдлийг өгөхгүйгээр энэ Доржхандын хэлээд байгаа шиг энэ сонгогчдын тоо 3 сая болчихлоо. Тэгээд л энийг нэмэх зайлшгүй шаардлагатай гэдэг шиг, тэр Энэтхэг гээд 1 тэрбум 400 сая хүн амтай газар Английн парламент гэдэг энэ парламентын засаглалын ноён оргил болсон энэний залгамж халаа болсон Энэтхэг чинь 2 танхимтай 150 парламентын гишүүнтэй байдаг юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр энэ нөхцөл байдал дээр энэ шийдэл дээр бодит үнэнийг бид ард түмэндээ ярьж байж шийдэлд хүрч байвал ард түмэн дэмжинэ гэж бодож байгаа. Би энэ шийдлийг гаргахын тулд өнөөдрийн энэ улс төрийн хүнд байдалд орсон, төрийн тогтолцооны гацаанд орсон, энэ нийгмийн төлөөллүүдийн эрх ашгийг улс төрийн намуудын төлөөллийг энд оруулж ирж байж Монгол Улсын тэр тусгаар тогтнолын асуудал Үндэсний аюулгүй байдлын баталгааны үүднээс энэ өөрчлөлтийг хийх ёстой гэж ойлгож байгаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Би нэг зүйлтэй бол 100 хувь санал нийлж байгаа. Тэгээд би энэ одоогийн эрх барьж байгаа намын дарга Оюун-Эрдэнэд баяр хүргэсэн юм юу вэ гээд. Тэгэхлээр 2 зүйл дээр бид нар намын даргын хувьд тохирсон байдаг юм.

Нэгдүгээрт энэ өмнөх 30 жилийг дуусгавар болгоод үр хүүхдэдээ өөр 30 жилийг өгч чадах юм уу, үгүй юм уу. Эр зоригтойгоор энэнийхээ ард гарч чадах юм уу үгүй юм уу? Тийм бол тогтолцооныхоо өөрчлөлтийг хий.

Хоёрдугаарт энэ авлига хээл хахуультайгаа тэмцэж чадах юм уу, чадахгүй юм уу? Тийм бол энэ тэмцлээ зоригтой хийнэ ээ гэвэл парламент дээр шүгэл үлээнэ ээ бүхэл бүтэн намаараа бид нар дэмжинэ гэсэн үнэн. Энэ 2 асуудал дээр тохироод явж байгаа юм, дэмжээд явж байгаа юм. Энийгээ би бүүр хатуу чанга хэлмээр санагдаж байгаа юм.

Парламентад сөрөг хүчин гээд тэгэхлээр бүх зүйлийг буруутгадаг байж болохгүй ээ. Зөв зүйл дээрээ бид нар хамтарч ажилладаг байх ёстой. Улс орныхоо эрх ашиг дээр нэгддэг байх ёстой. Тийм болохоор Улсын Их Хурлын гишүүн болсныхоо дараа энэ соёлыг парламентад бий болгоё гээд ажиллаж байгаа юм. Тэрний төлөө хэн нэгэн намын өмнөөс гүйдэг, энэ намын нөлөөний нам ч гэдэг юм уу ийм зүйл бол болно оо. Энэ 30 дахь асуудал юм. Харин улс орон маань ялдаг үр хүүхэд маань эрүүл нийгэмд орших тэр л үр дүнд хүрч байвал бид бол ялна гэсэн үг. Ийм болохлоороо өнөөдөр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирж байгаад сайн байна, маш сайн байна, баяр хүргэмээр байна. Энэнийхээ ард харин бүгдээрээ гарах хэрэгтэй, нэг.

Надад бол асуулт байхгүй. Тэгэхдээ Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнээс бол асуулт байгаа. Асуултаасаа өмнө би бас тодорхой зүйлийг бас хэлчихмээр байна аа. Энэ асуудлыг яагаад гаргаж ирсэн юм бэ гэдэг дээр бас бодитой л байх хэрэгтэй байх. Хоёр нүүртэй баймааргүй байна, нэг нүүртэй баймаар байна. Улс төр цаашаа тийм байгаасай гэж хүсэж байна. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт яагаад өнөөдөр орж ирсэн юм бэ гээд тэгэхээр Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол гарсан юм. Тодорхой 2 чиглэлээр үүрэг өгсөн юм Улсын Их Хурлаас. Энд сууж байгаа Ардчилсан намынхан, Ардын намынхан, ХҮН намынхан нийлж байгаад санал нэгтэйгээр чиглэл өгсөн юм. Энэ юу вэ гээд тэгэхээр тогтолцооны болон тооны өөрчлөлтийнхөө асуудлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгаад саналаа оруулж ир ээ гэсэн тодорхой чиглэл юм. Энэний хүрээнд өнөөдөр энэ хэлэлцэгдэж байна, нэг.

Хоёр дугаарт энэ асуудал яагаад гарсан юм бэ гээд тэгэхээр Үндсэн хуулийн 01, 02 дугаар тогтоолыг үндэслэсэн юм аа. Нэг нь болохоор тогтолцооны асуудлыг шийдэх, нөгөөдөх нь давхар дээлээ та нар өмсөхөөр бол тооныхоо асуудлыг зохистой түвшинд нь байлгах ёстой юм. Олон улсын парламентын чиг хандлагыг та нар авч ашиглах нь зүйтэй гэдэг ийм зөвлөмжтэйгөөр 2 тогтоол гарсан байдаг юм.

Энэ дээр үндэслээд Одонтуяа гишүүн бид хоёр нэлээд парламент дээр ярьсны үндсэн дээр энэ 54 дүгээр тогтоол гарсан юм. 01, 02 дугаар тогтоол яагаад гарсан юм бэ гэхээр хуульч Үүрцайхын хамт би иргэний хувиар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан юм, 2 асуудлаар үнэн.

Энэ бол хэн нэгэн хүмүүсийн эрх ашиг хэн нэгэн намын эрх ашиг огт төлөөлөөгүй юм аа. ХҮН нам анх байгуулагдаад 2016 ондоо л яг тоо

тогтолцооны асуудлыг бид нар сөхөж гаргаж ирж байсан юм. Яагаад гэвэл бид маш олон судлаачидтай юм. Энэ улсын төлөө гэсэн зүрх сэтгэлтэй маш олон сэхээтнүүд мэргэжилтнүүд байдаг юм. Энэ хүмүүсийн уйгагүй хөдөлмөр судлаачдын дүгнэлт дээр үндэслэж бид нар энэ саналуудаа тавьдаг, шаардлагуудаа тавьж ирсэн байдаг юм. Өнөөдөр хүртэл энэ дээрээ тууштай байгаа. Энэ дээр харин парламент дээр суудалтай намууд нь нэгдээд яах юм бол энэ Монголын хувь заяа Монгол Улсад эсвэл дараагийн 30 жилд маш том өөрчлөлтийг авчирч чадна гэдэг дээр судлаачид батлаад гаргаж байгаа юм. Бид батлаад гаргаж байгаа юм, чадна гэдэг дээр. Энэ бол олон улсын бас түүх харуулж байгаа юм. Ийм болохоор энэ дээр эргэлзэхгүй байх шаардлагатай. Тэгээд түүх ийм байдлаар явсан байдаг гэж.

Одоо 2 асуудал гарч ирж байгаа. Түүн дээр ямар асуудал байна гээд тэгэхээр эдийн засгийн асуудал байгаа юм. Монгол Улсын эдийн засаг сүүлийн 10 жилд ердөө 10 гаруй тэрбум доллар дээр гацчихсан. Доллар дээр шүү дээ. Гэтэл АНУ-д доллар чинь өөрөө уначхаад байгаа шүү дээ. 5 жилийн өмнө 100 доллароор 3 уут хүнс авдаг байсан бол одоо ганцхан уутыг авч байгаа. Тэгээд та нар төсөөлөөд үзээрэй. Монголын эдийн засаг ямар их агшичихсан юм бэ гээд. Өнөөдөр он гарснаас хойш 2 дахь удаагаа бүх аймаг орон нутгаар явлаа. Маш олон хүмүүс болохлоор ард түмэн дургүйцэж байна гээд байна. Үгүй ээ, бүх аймгуудаар явлаа. 1.2 сая иргэдтэй нүүр тулж уулзлаа, ярилцлаа. Иргэд мэдээлэлгүй болохлоороо дургүйцэж байна. Мэдээлээ авсны дараа дэмжиж байна аа. Хөгжлийн банкны асуудал, нүүрсний асуудал энэ бүгдийг санаачилсан Их Хурал дээр бас энэ асуудал дээр шүгэл үлээсэн гишүүний хувьд иргэддээ хэлж байгаа. Үнэхээр хулгайтай тэмцье гэх юм олон улсын парламентад 120 хүртэл парламентын гишүүдтэй байх юм бол хулгай хуйвалдаан тасардаггүй юм байна аа.

Монгол энэ зовлонг давтаж яваад байна аа. Ийм болохлоороо олон улсад парламент гэдэг чинь 120-800-гийн хооронд байдаг юм байна.

120-оос доошоо хулгай болчихдог 800-аас дээшээ шийдвэр гардаггүй. Стадион дүүрэн хүмүүсийг ингээд цуглуулаад шийдвэр гаргах юм бол шийдвэр гарах боломжгүй юм аа. Ийм болохлоор их олон гишүүдийн яриад байгаа Хятад, Энэтхэгийн жишээ байна. Энэтхэг гэхэд 1.3 тэрбум хүнтэй. Гэтэл Энэтхэгийн парламент 2 танхимтай. Энэ парламентын гишүүдийн тоо 788 юм. Яагаад 10 мянга биш юм, яагаад 20 мянга биш юм. Яагаад вэ гэхлээр 800-аас дээшээ үр дүн гардаггүй байхгүй юу. Эсрэгээрээ яагаад Монгол Улс өнөөдөр 3.4-хөн сая хүнтэй байж байж 152 байх ёстой юм бэ гэдэг асуудал гарч ирээд байгаа юм. Үгүй ээ Монгол Улс 152 гэдэг чинь судлаачдын тоо юм аа. Энэтхэг, Хятадтай харьцуулах юм арав, хорьхон хүнтэй болгоо гээд ийм зүйл яриад байгаа юм. Ардчилсан парламентын улсууд ийм байдаггүй юм. Харин Монгол Улсын хувьд зохимжтой тоо юу вэ гэдгийг судлаачид гаргаж ирж ярих юм.

Эсрэг тоо гаргаж ирж байгаа бол та нар судалгаагаа гаргаж ирж байгаад бүгдээрээ сайхан мэтгэлцье л дээ. Түүнээс бурхны тоо 108 гоё тоо 99 гээд ингээд уянгалаад явах юм бол энэ өмнөх парламентын алдаануудаа давтана шүү. Одоо бүгдээрээ шинжлэх ухаанчаар хандъя, судалгаан дээрээ ярилцдаг байя. Ингэж байж нийтээрээ нэг том алхалт хийе ээ гэж хүсэж байгаа юм.

Хоёр дахь зүйл нь эдийн засгийн асуудал нь юу байна гээд тэгэхээр Монгол Улс сүүлийн 30 жилийн хугацаанд хөгжсөн үү, хөгжссөн. Эдийн засаг 14 дахин өссөн. Хамгийн эмгэнэлтэй тоо нь дагаад төрийн зардал 55 дахин өсөөд Монгол Улсын өр 70 дахин өсчихсөн шүү. Байнгын өртэй зовлонтой. Энэ Африкийн 40-өөд улсын 60-аад хувийнх нь түүх юм аа. Өмнөд Америкийн улсуудын түүх юм.

Хөгжихгүй байгаа 100-аад улсуудын түүх юм. Дандаа зээл авч санхүүжилтээ хийдэг, тэтгэврээ тавьдаг, цалингаа тавьдаг, зээл авч тэнд байшин барьдаг. Үр дүнд нь энэ төсөв чинь хөрөнгө оруулалт хийх орон зайгүй болох юм аа. Яагаад вэ гэхлээр ирээдүйн 10, 20 жилийн хөгжлийн санхүүжилт юу байх юм бэ гэхлээр боломж байхгүй бодлого ярьдаг парламент байхгүй болчихсон байхгүй юу, байхгүй. Ядаж энэ дотроо 50 хувь нь бодлого ярья л даа. Ирээдүй ярья л даа. Өнгөрснөө жаахан мартъя л даа. Үр хүүхдэдээ боломж олгоё л доо, хөгжлөөрөө мэтгэлцье л дээ бүгдээрээ. Хөгжлөө санхүүжүүлдэг байя л даа.

Хөгжлийн төлөө кноп дардаг байя л даа. Ийм болохлоороо парламентад бодлого ярьдаг бодлогын улс төрчдийг оруулж ирье ээ гэдэг ийм ийм агуулгаар бид ярьж байгаа юм аа. Үнэн, өөрсдөө ялахын төлөө биш шүү. Зарим хүмүүс айгаад байх шиг байна. Тийм юм байхгүй ээ.

Г.Занданшатар: Асуулт биш саналаа л хэлчихлээ.

Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир, Хавдисламын Баделхан нарын урилгаар хилчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад оролцож байгаа Хилийн цэргийн 0165 дугаар ангийн албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Манай Баян-Өлгий аймагт байрладаг Цэргийн гавьяаны одонт 0165 дугаар ангийн энэ хилчин бүсгүйчүүддээ бас энэ хилийн цэрэгт эх орноо батлан хамгаалах, дархан хилээ хамгаалах энэ дархан босоо хилийнхээ баганатай хамт ингээд босоо хийморьтой энэ эмэгтэйчүүд голдуу энэ хүнд хүчир албанд бас цаг наргүй зүтгэдэг энэ эмэгтэйчүүддээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг

хүсэн ерөөе. Хилийн заставын хилчин бүсгүйчүүддээ бас аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөе.

Тэгээд Шекара тыныш, еламан болсын. Асуултад Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Доржханд гишүүний хэлж байгаа зүйлүүд бодитой Улсын Их Хурлын тогтоолыг Засгийн газар биелүүлэх үүрэгтэй. Тийм учраас Засгийн газар, Улсын Их Хурлын 2022 оны 54 дүгээр тогтоолын дагуу Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой энэ асуудлыг яг хугацаанд нь оруулж ирж хэлэлцүүлж байгаа. Хэлэлцэж эцэслэн батлах эрх гагцхүү Монгол Улсын Их Хуралд хадгалагдаж байгаа.

Тийм учраас парламентын гишүүд маань хэрхэн сонгогчдоо, иргэддээ ойлгуулж, ярилцаж, дэмжлэг авах эсэх нь гагцхүү парламентын гишүүд та бүхний хуулиар хүлээгдсэн онцгой бүрэн эрхийн асуудал аа.

Улс төрийн намуудтай олон талаас зөвшилцсөн. Иргэний нийгмийн байгууллагуудтай хэд хэдэн удаагийн хурлууд бас болсон. Энэ дээр бүгд дээр нь Засгийн газрын тэргүүний хувьд мөн эрх баригч намын даргын хувьд туйлын хүндэтгэлтэй бидний хувьд хандаж, хамтран ярилцсан. Ер нь бид нар ардчилсан тогтолцоог илүү зөвшилцлийн бас илүү хүртээмжтэй, нийт иргэдийнхээ санал дээр үндэслэдэг. Тэгээд гаргасан шийдвэр нь хэрэгждэг ийм байх зөвшилцөл рүү л явуулах учиртай. Энийг л парламентын засаглал гэж бидний хувьд нэрлэж байгаа олуулаа хэлэлцдэг. Тэгэхээрээ энэ асуудлаар Засгийн газар оруулж ирж байгаа нь бодитой. Мэдээж геополитикийн нөхцөл байдал яагаад энэ 50, 50 байх вэ яагаад 50, 50 байж болохгүй вэ? Яагаад гишүүдийн тоо нэмэгдээд байна гээд ийм асуудлууд яригдаж байна. Энэ хамгийн сонгодог хэлбэрээрээ л орж ирж байна гэсэн үг. Хүйс ч гэсэн 50, 50 байх ёстой л гэж үздэг. Тийм ээ тэрэнтэй адилхан

тэгээд л тэр зүйл рүү бидний хувьд хамтдаа алхдаг 20 хувь, 25 хувь, 30 хувь гээд л жендер ахлаад явж байгаатай адилхан 50 хувьд хүрч чадвал энэ маш том дэвшил болно. Үүнтэй яг адилхан тойргоос төлөөлсөн төлөөллийн мандат, хувь тэнцүүлж буюу нийгмийн төлөөллийг хангаж байгаа энэ мандат хоёр тэнцүү байх нь л хамгийн зөв. Тэгэхээр энэ тэнцвэр хэлэлцүүлгийн үед 30 хувь дээрээ очиж зогсох нь уу 40 хувь болох нь уу 50 тавиараа батлагдаж чадах нь уу. Энэ бол хэлэлцүүлгийн явцад Их Хурлын гишүүд та бүхний онцгой бүрэн эрхэд л хамаарах асуудал.

Өнөөдөр ингээд л бид нар өргөн барьсан хувилбараараа эхэлж байна л гэсэн ийм агуулгаар. Нэг үгээр хэлбэл Засгийн газрын зүгээс хэлэлцүүлэгт оруулж байна л гэсэн үг. Мэдээж иргэдтэй бид нар энэ мэдээллийг олон талаас нь бас ярилцах ёстой. Бусад улсуудын жишээ баримтаас авхуулаад мажоритар пропорциональ тогтолцооны давуу болон сул тал энэ бүх асуудлуудыг тайлбарлах хэрэгтэй. Би одоо бас эндээ байгаа улс төрийн намын удирдлагууд байна. Өмнө нь нэг удаа яагаад энэ хувь тэнцүүлсэн зарчим дээр иргэд итгэл алдарчихсан бэ гэхээр энэ жагсаалтын ард нэр хүндгүй мөн авлигал албан тушаалын хэрэгт холбогдохсон ийм хүмүүсийг оруулж ирэх, энэ нь миний сонгосон төлөөлөл биш байна гэдэг энэ агуулга дээр л нэлээн тийм судалгаагаар хийгээд үзэхэд бухимдалтай байна.

Уг нь бол энийг улс төрийн намууд зөвшилцөөд энэ бол заавал дарга нарын жагсаалтаар харахгүй юу энэ бол өөрөө намууд нэг нэг төлөөллийг хэрхэн оролцуулах байгаа вэ гэдэг бодлогын өрсөлдөөн байх ёстой. Социал демократ намууд нь багш эмч нараа үйлдвэрчнээ илүү оролцуулж байгаа бодлогоороо илэрхийлэх ч юм уу. Либерал үзэлтэй улс төрийн намууд нь хувийн хэвшил болон хөрөнгө оруулагчдын төлөөллийг илүү түлхүү оруулж ирэх гэдэг бодлогын мэтгэлцээн ч юм уу, жендер болон насны төлөөлөл дээр бид нар хэрхэн харж

байна гэдгээ бодлогынхоо хувьд эрэмбэлж байгаа. Малчдынхаа бодлогын асуудлыг бид нар хэрхэн тавьж байгаа вэ жагсаалтын хэдэд эрэмбэлж байгаа вэ гэдгээ тухайн улс төрийн нам өөрөө эрэмбэлж байгаа ийм л бодлогын мэтгэлцээн.

Харамсалтай нь одоо энийг өмнө нь одоо хийж чадаагүйгээс шалтгаалаад маш том хэмжээний реформ бол бас одоо нурах ийм одоо нөхцөл байдал руу бол тухайн үедээ шилжсэн.

Тэгэхээр одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой. Энэ удаа бол бид нар Улс төрийн намын тухай хуулийг хэлэлцэнэ. Сонгуулийн хуулийг давхар хэлэлцэнэ. Тэгэхээр аль аль талд нь энэ ёс зүйн хувьд бас нэлээн шүүлтүүр тавих иргэдийн болгоомжлоод байгаа тэр асуудал дээр энэ одоо холимог тогтолцоо төлөвших хүртэлх хугацаанд бид нар эрх мэдлийн шуналаасаа татгалзах энэ дээр улс төрийн намууд нэгдсэн байдлаар зөвшилцөх энэ агуулга руу бидний хувьд орж чадвал илүү тийм одоо бодлогын тэнцвэртэй парламентын төлөөллийг бүрдүүлж илүү бодлого тогтвортой байх энэ боломжийг бол бас үгүйсгэх юм. Нөгөө талаараа энэ одоо хувь тэнцүүлсэн тогтолцоо хэрвээ батлагдвал эмэгтэй эрэгтэй хүйсийн төлөөлөл бол нэгийг харьцах нэг байна гэдэг байдлаар оруулж ирж байгаа. Энэ бол өөрөө урьд нь бол бас тэгсэн шүү дээ жагсаалт гэхлээр бүүр хойно нь ингээд жагсаалтын хойно аваачаад одоо эмэгтэйчүүдээ ингээд бүгдийг нь оруулчихсан. Сонгогдох магадлал дээрээ одоо эрэгтэй улс төрчид нь орчихсон ийм одоо байдалтай байгаад байдаг.

Тэгэхээр энийг бидний хувьд бас ишийдвэрлэхийн тулд зайлиггүй энэ холимог тогтолцоо бол зайлиггүй шаардлагатай. Бусад улсад бол одоо бүүр зөвхөн нэг хүйс хоорондоо өрсөлддөг ийм одоо төлөөллийн мандатын тойргийг хүртэл гаргаж байсан ийм тохиолдлууд бол бас байдаг. Энийг өөрөө

би дахиад хэлье. Эмэгтэй улс төрчдийг олноор нь улс төрд оруулж ирэх гээд байгаа сэдэл нь биш. Нийгмийн бодлогыг илүү тэнцвэртэй харах гэдэг энэ агуулгаараа л энэ зөв. Дахин хэлэхэд энэ 152 гэдэг тоондоо биш. Гагцхүү тойргоос сонгогдож байгаа төлөөлөл хувь тэнцүүлж нийгмийн сегментийг төлөөлж байгаа төлөөлөл 2 тэнцвэртэй байж байж бодлого илүү тогтвортой тэнцвэртэй болно гэдэг л агуулга. Олон намын тогтолцоотой гэххэд бид нар 2 нам давамгайлаад яваад байдаг. Энэ дээр парламент одоо хамгийн багадаа нэг 4-5 намтай болж, энэ дээр улс төрийн намууд төлөвших процессын эхлэл. Тойргоос сонгогдоод байхаар илүү одоо хатуу гишүүнчлэл нэмэгдээд л байна. Энэ нь өөрөө талцал хуваагдлыг авчраад байдаг. Тэгэхээр энэ нь өөрөө хатуу гишүүнчлэлээс илүү бодлогын нам байх. Одоо тэр мэтгэлцээний одоо соёл. Сая бас Доржханд даргын хэлснээр парламентын дэг өөрчлөгдөнө парламентын дэг илүү мэтгэлцээний хэлбэрт орно. Мэтгэлцээний хэлбэрт илүү унишж судалж хоорондоо мэтгэлцэх нэг нь одоо хамгаалагч нэг нь няцаагч тал болж мэтгэлцдэг гэсэн үг. Энэ дундаас иргэд илүү их ойлголтыг илүү их мэдээллийг авах боломжтой. Зөвхөн 5 минутаар үг хэлэх биш магадгүй 30, 30 минутаар мэтгэлцэх ийм боломжууд гарна. Тэр нь өөрөө Улсын Их Хурлаар батлагдаж байгаа хууль, тогтоомж нийгмээс илүү их дэмжлэг авах илүү легитим буюу хүлээн зөвшөөрөлтийг хадгалах тал дээр энэ маань өөрөө парламентын цоо шинэ соёлыг бол бас төлөвшүүлнэ.

Нөгөө талаараа нийслэл Улаанбаатар хотын төлөөлөл үлэмж хэмжээгээр нэмэгдэнэ. Одоо бол бас ингээд яг тойрог нутаг дэвсгэр гэхлээр хүн амын 50 хувь нь бас төлөөлөл тааруу байдаг. Гэхдээ бид нар нутаг дэвсгэрээ төлөөлүүлэхээс өөр аргагүй. Энэ тогтолцоо болохлоор илүү нийгмийн сегментээр тулгуурлаж байгаа учраас хүн ам илүү төвлөрч байгаа газартаа энэ мэтгэлцээний болон одоо дуу хоолой илүү

өргөн байх ийм боломж үүснэ. Нөгөө талаараа бид нар гадаадад байгаа одоо Монголчууд хилийн чанадад байгаа Монголчууд маань маш идэвхтэй одоо цахимаар байр сууриа илэрхийлдэг мөртөө парламентын сонгууль дээр бол оролцож чаддаггүй. Энэ боломж одоо энэ хувь тэнцүүлсэн систем дээр нээгдэнэ.

Энэ нь өөрөө бид нар цөөхөн монголчууд илүү одоо дэлхий даяар байгаа монголчуудынхаа оюун санааг ашиглах хөгжлийн бодлогод оролцох.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн нэмэлт асуулт нэг минут

Т.Доржханд: Баярлалаа. Санал бол нийлж байна аа. Тэгэхдээ нэг зүйлийг би бүүр Ерөнхий сайдаас өөрөөр нь хэлүүлмээр байгаа юм. Яагаад вэ гээд тэгэхлээр маш олон хүн хүмүүс тодорхой бас гишүүд үгүй тэр 2012-2016 оны жагсаалтад чинь болж бүтэхгүй улс төрчид ороод ирчихсэн юм аа. Намын даргынхаа ойрхон байдаг хүмүүс эсвэл мөнгөтэй нөхдүүд цүнхтэй мөнгөө барьж орж ирээд тэгээд лист рүү орчихсон юмаа гээд байдаг юм. Яг тэдгээр нь ямар хүмүүс байдаг юм бэ гээд тэгэхлээр хэлдэггүй юм. Гэхдээ одоо та Монгол Улсын одоо бас эрх барьж байгаа намын даргын хувьд бас өөрөө энэ төслөө оруулж ирж байгаа албан тушаалтны хувьд нэг үгээ хэлчхээч ээ.

2024 онд хэрвээ лист буюу энэ жагсаалт одоо орж ирэх боломжтой болж батлагдсан тохиолдолд намынхаа жагсаалтад тэр худлаа хийсэн, худлаа ярьсан, тэгээд нэр төргүй болчихсон хүмүүсийг биш харин илүү нийгмийн төлөөллүүдийг, эмэгтэйчүүдийн төлөөллүүдийг, залуучуудын төлөөллүүдийг, мэдлэгтэй, боловсролтой, туршлагатай, ёс зүйтэй ийм улс төрчдийг бид жагсаах энэ ажлыг бол хийнэ гэдгээ мэдээж та шийдэхгүй би шийдэхгүй. Тэгээд намын хамт олон удирдах түвшнийх нь

байгууллага бол шийдэх нь ойлгомжтой. Гэхдээ нэгэнт улс төрийн намыг төлөөлдөг албан тушаалтныхаа хувьд бол энэ нэг коммитмент буюу энэ нэг баталгааг өгчихмөөр байгаа юм. Үгүй бол иргэдийн тархийг их угаагаад байна. 2012-2016 оны муу жишээ гээд л яриад байна. Иргэд бас тэрэнд нь одоо итгээд зарим нь бас буруу ойлголттой байгаад байна. Ийм болохлоор ХҮН намын даргын хувьд бас энийг уриалж байгаа юм. АН-ын дарга Лу.Гантөмөрт би бас энийг уриалж байгаа юм. Энийг бас манлайлаад эхлүүлээд явъя. Улсын Их Хуралд суудалтай намуудын удирдлагуудын хувьд ийм байдлаар энэ.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Эхлээд за Улсын Их Хурлын өнөөдрийн хуралдаанд Баян-Өлгий аймаг дахь Цэргийн гавьяаны одонт Дамдины Намнаны нэрэмжит 0165 дугаар ангийн хилчин бүсгүйчүүд оролцож байна аа.

Улсын Их Хурлын гишүүн Аубакир, Баделхан нарын урилгаар өнөөдрийн та бүхэн маань хилчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад оролцоод ингээд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байгаа юм. Тэгээд та бүхэндээ эх орныхоо халдашгүй дархан байдлыг хангахад эрчүүдтэй хамт мөр зэрэгцэн зүтгэж, халуунд халж, хүйтэнд хөрж улсын хил дээр одоо залуу халуун насаа өнгөрүүлж, эх орон, хил хилчдийн төлөө амьдралаа зориулан ажиллаж амьдарч байгаа ийм бахархалт бүсгүйчүүд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс амьдралын аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж та бүгдийн ажил үйлс, улсын хилийн багана шиг үргэлж босоо хийморьтой байж, амьдрал нь аз жаргалаар дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлъя. Дархан хил амгалан, эх орон сайн сайхан байг. Шекара тыныш еламан болсын.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд хариулна аа.

Л.Оюун-Эрдэнэ: Шууд асуудлаа шууд хариулчихъя. Энэ дээр би эрх баригч намын даргын хувьд Ардчилсан нам зөвшөөрвөл Хүн намтай хамт гурвуулаа санамж бичигт гарын үсэг зурахад бэлэн байна.

Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна. Монгол Улсын энэ Үндсэн хуульд оруулах өөрчлөлт, Улс төрийн намын тухай, Сонгуулийн хууль гээд 2, 3 хуульд одоо өөрчлөлт шинэчлэлт нь хийх нь одоо эрх зүйн хувьд бол нэг багц гэж хэлж болохоор байгаа. Ач холбогдлын хувьд бол улс төрийн суурь шинэчлэлийн одоо чанартай. Улс орны цаашидын хөгжил дэвшилд бол одоо чухал ач холбогдолтой гэж бол харж байгаа. Энэ хуулиудын аль нэгийг нь юм уу эсвэл хоёрт нь өөрчлөлт хийгээд эсвэл одоо нөгөө хэсгийг нь бол хэвээр үлдээх юм бол ер нь бүрэн шинэчлэл хийгдэж бол чадахгүй. Манай улс төрийн одоо суурь тогтолцоо өнөөдөр согог хэвээрээ үлдэх үү, одоо эс үлдэх тухай одоо асуудлыг нэг тийш нь шийдвэрлэх бас ийм одоо чухал үүрэг бол манай энэ удаагийн парламентын бүрэлдэхүүнд бол ноогдож байна. Тэгээд энэ орж ирсэн төсөл бол энэ сонгуулийн тогтолцоо гишүүдийн тоотой холбоотой одоо мэт асуудал боловчиг ер нь бол улс орны хөгжлийн хэтийн төсөөллийг ингээд харвал тогтолцооны агуулгын хувьд бол томоохон ийм өөрчлөлт хийхээр орж ирж байна гэж харагдаж байна. Зах зээлийн нийгэмд энэ шилжсэнээс хойш 30 жилийн хугацаанд Монгол Улс одоо тодорхой өсөлт амжилттай зүйлүүд бас байсан боловчиг гэхдээ энэ хугацаанд нийгэм, эдийн засгийн одоо бодлогын асуудал бол үндсэндээ орхигдсон.

Өнөөдөр 3 хүн тутмын нэг нь бол ядуу байна. 150-180 мянган хүн өнөөдөр ажилгүй байна. Төрийн зардал нь ДНБ-ий 40 хувьтай тэнцэх одоо үрэлгэн ийм төлөвлөлттэй байна. Баялгаа эрх мэдэлтнүүд нь өөрөө хуваагаад авчихдаг.

Одоо ингээд ийм зах зээлийн нийгэмд шилжээд бид нар сайхан нийгмийг байгуулна гэж ард түмэнд одоо амлаж байх тэр үед бол ард иргэд бол бид нарт бол итгэж байсан, дэмжиж байсан. Гэтэл өнөөдрийн иргэдийн төрдөө итгэх итгэл бол одоо маш их хугарчээ. Бухимдал дээд цэгтээ хүрсэн ийм л дүр зурагтай байна. Тэгээд энэ эдийн засгийн бодлогын хувьд бол нэг чухал асуудал энэ манай улс бол худалдааны хуульгүй явж байгаа асуудал одоо маш чухал асуудал болоод байгаа юм.

Өнөөдрийн энэ бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, инфляцын түвшин, одоо ханшийн өсөлт гээд энэ бүх л одоо худалдааны зохицуулалт Худалдааны хуульгүй энэ бодлогогүйгээс болж байгаа гэж хэлж болно. Тэгээд энэ зохицуулалтгүйгээс болоод энэ олон боломжийг ч гэсэн бид нар алдаж ирсэн. Тэгээд сая Ерөнхий сайд Үндсэн хуулийн одоо нэмэлт өөрчлөлтийг хийснээр энэ түүхэн реформыг одоо реформын нэг хэсэг байх болно гэж сая илтгэлдээ хэлсэн.

Тэгэхлээр Ерөнхий сайд одоо таны хувиар энэ дараагийн 30 жилд энэ реформын төлөвлөгөө, энэ төлөвлөлтөө юу гэж төсөөлж, төлөвлөж байна вэ гэж би асууя. Энэ төсөлтэй холбоотойгоор тоо нэмэгдүүлэх асуудлыг бол бид хүн амтай одоо уялдуулж тийм ээ одоо энэ нэмэгдүүлэх асуудлыг л үндэслэл гэж авч үзээд байгаа. Гэтэл одоо үүнээс үүсэх үр дагавар сул талууд эрсдэлийн талаар ер нь тооцоо судалгаа байдаг юм уу? Энэ талаар бол огт ярьж тайлбарлахгүй байгаа.

Тэгэхлээр давуу талаас гадна одоо сул тал эрсдэлүүд нь юу юм бэ гэдэг дээр бас хариулт авъя. 1992 оны энэ Үндсэн хуулийг хэлэлцэх үеийн түүхээс харах юм бол 1991 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн энэ Улсын бага хурлаас Ардын Их Хуралд оруулсан төслөөр бол 76 гишүүнтэй одоо 6 жилийн хугацаагаар, 3 жилээр ротац хийж сонгодог байх

хувилбарыг оруулж байсан байдаг юм байна лээ. Тэгээд одоогийн энэ Японы зөвлөхүүдийн танхимын хувилбар гэсэн үг. Тэгэхээр ийм төрлийн зохицуулалтуудыг та бүгд маань бас одоо судалж үзсэн үү? Манай улсын хүн ам ер нь харьцангуй залуу улс. Цаашид хүн ам ер нь өснө. Энэ гишүүдийн тоог ер нь хатуу заах нь ер нь хэр зохимжтой гэж үзсэн бэ? Үндсэн хууль тогтвортой байх талаасаа ч тэр ер нь энэ холимог тогтолцоотой бусад улс орны одоо туршилагаас ингээд аваад үзэх юм бол парламентын гишүүдийнхээ одоо тооны доод хэмжээг Үндсэн хуульдаа зааж өгсөн байдаг юм байна лээ.

Өөрөөр хэлэх юм бол доод хэмжээгээ заагаад олонхын буюу мажоритарээр сонгох гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулаад тогтоодог ийм уян хатан зохицуулалттай байдаг юм байна лээ. Ийм төрлийн зохицуулалтыг ер нь та бүгд судалж үзсэн үү гэж бол асууя аа.

Тухайлбал Герман, Солонгос улсыг бол энд дурдаж болно. Солонгос бол одоо 51 сая хүн амтай, 300 гаруй парламентын гишүүдтэй холимог тогтолцоотой. Үндсэн хуульдаа бол 200-аас дээш гишүүнтэй байхаар заасан байдаг юм байна лээ. Герман бол 500-аас дээш 598-аас дээш одоо байхаар заасан байдаг. 700 гаруй гишүүнтэй байдаг юм байна лээ. Эстони улсыг аваад үзэх юм бол 1 сая хүн амтай, 108 гишүүнтэй сонгуулийн холимог ийм тогтолцоотой байдаг юм байна лээ.

Тэгэхээр энэ талаар одоо хууль санаачлаад бас хариулт авмаар байна.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Ажлын хэсэг нэмж бас хариулах нь зүйтэй байх.

Нэгдүгээрт энэ бол тогтолцооны реформ бол биш. Энэ бол сонгуулийн

тогтолцооны реформ. Тэгэхээр энийг бас ялгаж зааглаж ойлгохгүй бол тогтолцоогоо хөндсөн юм бол энд байхгүй. Гагцхүү сонгуулийн тогтолцоог л өөрчилж байгаа. Тэгэхээр энэ олон реформуудын одоо нэг том бүрэлдэхүүн хэсэг бол энэ мөн гэж одоо бид нар ойлголтоо цэгцэлчих нь зүйтэй байх.

Хоёрдугаарт цаашидаа энэ маань яг ямар ямар реформын суурь болох вэ гэдэг асуудал. Энэ бол хууль тогтоох чадварт бол нэлээн тийм том хэмжээний өөрчлөлт бол гарна. Нэг үгээр хэлбэл парламентын соёл өөрөө мэтгэлцээний ийм соёл руу орно гэсэн үг. Тэгэхээр энэ бол одоо хууль батлах, Дэгийн тухай хуульд нэлээн тийм том хэмжээний өөрчлөлтийг бол авчирна. Илүү одоо урт хугацаатайгаар мэтгэлцдэг байх. Английн парламенттай маш төстэй, Германы парламенттай маш төстэй болох ийм сонгодог загвар руугаа орох ийм том алхам болно оо гэж одоо ойлгож бол болно. Мэдээж энэ реформ хийгдсэнээр одоо эдийн засгийн ийм тогтвортой томоохон бодлогууд илүү одоо уялдана гэсэн үг, илүү уялдаж явна гэсэн үг.

Тэгэхээрээ одоо бодлого бол нэлээн тийм тогтвортой явна. Бодлого бол нэлээн тогтвортой явна. Заримдаа мэдээж одоо давуу болон сул тал аль аль талдаа ч гэсэн ер нь ихэнх тохиолдолд сонгуулийн үр дүнгээр хамтарсан Засгийн газрууд байгуулагдах магадлал маш өндөр болно гэсэн үг. Тэгэхээр энэ маань өөрөө бодлогын тогтвортой байдал буюу бодлогын залгамж чанарыг одоо илүү тогтвортой болгох ийм давуу тал үүснэ. Давуу тал үүснэ. Мэдээж сул талууд бол бас байна. Сул талуудын хувьд бол засаглалын бас тогтворгүй байдал үүсэх тохиолдол бас гардаг. Одоо энэ бол жишээлбэл аль болохоор олон намын ийм төлөөлөл хангагдсан ийм парламент үүснэ гэсэн үг.

Мэтгэлцээн бас нэлээн одоо урт хугацаанд сунжрах ийм магадлал бол бас бий болно. Гэхдээ энэ маань өөрөө хурдан

шийдвэр гаргаснаас олноороо одоо хэлэлцэн шүүн тунгаахад бол илүү их тийм давуу байдлыг авчрах ийм одоо магадлалтай. Төлөвшилийн хувьд бол хамаагүй өөр ийм түвшинд очно. Тойрог болон одоо сегментийн төлөөлөл бол өөрөө хангагдана. Тэгэхээрээ манай улсад байгаа асуудал иргэд саналаа өгч байгаа юм. Саналаа өгч байгаа миний амьдралын чанарт өөрчлөлт гаргаасай л гэдэг саналыг өгч байгаа юм. Тэдэнд бол одоо бид нар энэдээ маргалдаад байх бол нэг их тийм чухал асуудал биш. Асуудлаа шийдээд том том асуудлуудаа шийдээд Монгол Улсын ДНБ-ийг тэлээсэй, амьдралын чанар өөрчлөгдөөсэй, гарц шийдлүүдээ гаргаасай л гэж бодож байгаа юм.

Тэгэхээрээ гарц шийдэл гарахад бол энэ тогтолцооны өөрчлөлт рүү орно гэдэг бол өөрөө маш том дэвшилийг авчирна. Том төслүүдийн гацах мөн одоо томоохон энэ бодлогын өөрчлөлтүүд илүү төвлөрөх гээд олон асуудал дээр цааш цаашдын реформууд бол хийгдэнэ. Энэ улс төрийн намын тогтолцооны энэ одоо реформыг бид нар энэ 3 хуулиа хаврын чуулганаар хийж чадвал дараагийн бидний том хэлэлцэх асуудал бол энэ төрийн албаны реформ байгаа. Энэ одоо данхгар бүтцийг бид нар хэрхэн одоо цалин ихтэй цомхон чадварлаг бүтэц болгох вэ гэдэг бол та бидний хувьд нэлээн тийм чухал тавигдана. Одоогоор бараг цалингийн 100 гаруй өөр шатлалтай байгаа. Энийг бидний хувьд бол нэг шатлал руу аваачна. Их Хурал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглал өөр өөр бодлогоор зохицуулагдаж байгаа. Энийг бид нар төрөөс цалин авдаг бол гэдэг нэг бодлого руу аваачна.

Ингэснээрээ төрийн бүтээмж бол бас эрс сайжрах мөн одоо улс төрийн албан тушаалтнууд төрийн захиргааны албан тушаалтнууд одоо зааг ялгаатай байх улс төрийн нам сонгуульд яллаа гэхэд төрийн албан хаагчдын тогтвортой байдалд нөлөөлөхгүй байх мэргэшсэн төрийн албан хаагчид байх зэрэг энэ асуудал дээр бол одоо нэлээн

тийм том хэмжээний реформ хийгдэнэ. Дагаад нийгмийн даатгалын реформ мөн одоо баялгийн хүртээмжийн нэлээн тийм том хэмжээний эрс реформ хийх ийм төлөвлөгөөтэй Засгийн газар байж байгаа гэдгийг танд хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Ингээд нэмэлт асуулт байвал хариулъя.

Баярлалаа.

Г.Занданшатар: Энэ завсар зочид танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Налайх дүүргийн бөхчүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Монгол жудаг ёсоо эрхэмлэсэн Монгол бөхийн цог золбоог нэр хүндийг ёс суртахууныг өндөрт өргөж одоо улам сайн барилдаж, спортын өндөр амжилт гаргахыг та бүхэндээ хүсэн ерөөе. Хишгээгийн Нямбаатар сайд нэмж хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Өнөрболор гишүүний асуултад Ерөнхий сайдын сая хариулсан дээр нэмээд нэг хэдэн зүйл хэлье ээ.

Ерөнхий сайд хамгийн түрүүнд таны асуултад хариулахдаа энэ бол тогтолцооны реформ биш сонгуулийн тогтолцооны реформыг энэ өөрчлөлт авчирна гэсэн зүйлийг хэлсэн тодотгож хэлсэн. Тэр утгаараа бид нар энэ өнөөгийн тогтолцоо энэ сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийг авчрахад дараах эерэг өөрчлөлтүүд гарч ирнэ гэж ажлын хэсэг дээр судлаачид бас ярилцсан.

Нэгдүгээрт санал гээгдэх явдал харьцангуй арилна. Бид сүүлийн жилүүдийн сонгуулийн үр дүнгийн статистикуудыг зүгээр одоо ингээд гар утсан дээрээ харж болох байх. Жишээлэхэд 2000 оны сонгуулиар Монгол Ардын нам нэг 50 гаран хувийн санал тэр үедээ Монгол ардын хувьсгалт нам

нэртэйгээр 50 гаран нийт сонгогчдын 50 гаруй хувийн саналыг аваад 72 суудлыг бүрдүүлж байсан. Өөрөөр хэлбэл цаана нь үндсэндээ 40 гаруй хувийн санал орхигдож гээгдэж байсан гэсэн энэ агуулга харагддаг. Тэгэхээр энэ холимог тогтолцооны сайн тал бол санал гээгдэх явдал үндсэндээ арилдаг. Нийгмийн бүхий л бүлгүүдийн төлөөлөл орж ирэх боломжтой болдог. Мөн хуулийн энэ гишүүдийн тоог нэмэгдүүлж цаашиад холимог тогтолцоогоор, сонгуулийн тогтолцоогоор парламент бүрдсэн тохиолдолд хуулийн хэлэлцүүлгийн чанарт ахиц гардаг. Яагаад гэвэл улс төрийн намууд холимог тогтолцооны үед бодлогын зөвлөлүүд буюу тинк танкаа илүү их ажиллуулж түүнээс гарсан, дэвшүүлж байгаа зорилтуудаараа бодлогын уралдаанд өрсөлдөөний үр дүнд сонгуульд оролцдог ийм бас давуу талуудтай. Гишүүдэд ирж байгаа гишүүний ачааллыг бууруулах боломжтой. Өнөөдөр би андуураагүй бол та 3 Байнгын хороонд харьяалагдаад явж байгаа. Таны саяын жишээ авч ярьсан БНСУ-ын парламент нэг гишүүн нэг л Байнгын хороонд харьяалагддаг.

Тухайн мэргэжлийн Байнгын хороо хуулийнхаа 1, 2 дугаар хэлэлцүүлгийг бүхэлд нь хийж дуусаад Хууль зүйн байнгын хороогоороо нөгөө экспертийн албаар оруулдаг шиг оруулаад эцэст нь чуулганы нэгдсэн хуралдаанаар ёсчилдог ийм л дэгтэй.

Тэгэхээр цаашид бид нар энэ дэг рүү явахгүй манай хуулийн чанар, бусад хууль хоорондын уялдаа энэ тэр алдагдсан зүйлүүд бий гэдгийг бас хэлье. Эрх мэдлийн тэр жинг багасгаж байгаа нэг хүнд ноогдож байгаа Их Хурлын гишүүнд ноогдож байгаа эрх мэдлийн төвлөрөл жинг бууруулах ийм том алхам болно гэж үзэж байгаа. Улс төрийн намуудын төлөвшил гэдэг их чухал зүйл байгаа юм.

Өнөөдөр манай парламентад хоёрхон намын бүлэгтэй л байж байх жишээтэй. Өмнөх үе үеийн

парламентуудад 2012-2016 оныг эс тооцоход бусад үеүүдэд ихэвчлэн 2 намын бүлэгтэйгээрээ байсан. Өнөөдөр Улсын дээд шүүхэд бүртгэлтэй бараг 40 орчим нам байдаг. Гэтэл өнөөдөр Улсын Их Хуралд суудалтай 2 нам хоёрхон намын, 3 нам хоёрхон намын бүлэгтэй байх жишээтэй. Тэгэхээр цаашид энэ холимог тогтолцоогоор сонгууль явагдсан тохиолдолд улс төрийн намуудынхаа төлөвшил ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэх тал дээр илүү их хувь нэмэртэй болно. Холимог тогтолцооны давуу тал дээр бас нэг сайн талыг судлаачид юу гэж үздэг вэ гэвэл энэ харьцангуй нөгөө сонгуулийн зардлыг бууруулж өгдөг. Мөнгөний хамааралтай тогтолцооноос илүүтэй бодлогын өрсөлдөөн мэтгэлцээн дунд сонгуулийн үр дүн гардаг ийм сайн талтай гэдэг зүйлийг ярьдаг. Мөн парламент дахь цөөнхийн хяналтын тогтолцоог сайжруулж чадна гэсэн ийм эерэг сайн талуудыг хэлдэг. Мэдээж хэрэг тогтолцоо болгонд өөрийн гэсэн сул талууд бий. Пропорциональ буюу хувь тэнцүүлсэн тогтолцоонд ч гэсэн өөрийн гэсэн сул талууд байдаг. Энэ бид нарт ердийн нөгөө улс төрийн сурах бичиг танин мэдэхүйн номууд дээр байдаг.

Тэгэхдээ бид нар өнгөрсөн 1990 оноос хойших 33 жилийн хугацаанд холимог тогтолцоог янз бүрийн байдлаар оруулахыг хичээж ирсэн. Үндсэн хуулийн цэц хоёр удаа сонгуулийн тогтолцооны талаар 2 өөр эсрэг байр суурьтай дүгнэлтүүд гаргасан. Үүнийхээ алдааг засаж 2022 оны 1 2 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог сонгуулийн шилдэг тогтолцоо дэлхий нийтэд хамгийн их ардчилсан улс орнуудад хэрэглэгдэж байгаа энэ сайн тогтолцооны хувилбарыг оруулж ирэхийг 1, 2 дугаар тогтоолд дурдсан. Үүний дагуу өнөөдрийн төсөл бичигдсэн гэдгийг бас товчхондоо хэлье ээ.

Г.Занданшатар: Гийм тэгээд нэг зүйл тодотгочихвол Эстони зуу биш 101 гишүүнтэй санаж байна. Тэгээд холимог биш пропорциональ тогтолцоог шууд

үндсэн хуульчилсан. Финлянд, Австри энэ тэр гээд ер нь энэ баруун Европын Скандиновын орнууд пропорциональ системтэй холимог Япон, Солонгос, Азийн улсуудаас гадна Унгар зэрэг хуучин социалист орнууд голицуу холимог дээд, доод танхим нь дээд тал нь пропорциональ доод тал нь мажоритар системээр дээр хольдог. Ийм бас тогтолцоонууд бий. Тэгээд энийг яг холимог тогтолцоо гэж бас нэрлэдэггүй юм байна лээ. Хосолмол гэж нэрлэхгүй бол холимог гэдэг чинь шал өөр сонгуулийн тогтолцоо биз дээ. Тийм параллель зэрэгцээ гэдэг юм уу.

Энхтайваны Бат-Амгалан
гишүүн.

Э.Бат-Амгалан: Юуны өмнө өнөөдөр Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр улс төрийн 20 гаруй намын зөвшилцлөөр олон нийтийн дунд одоо олон удаагийн хэлэлцүүлгээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлт орж ирж байгаа. Үндсэн хуулийн өөрчлөлтийг үндсэнд нь бол дэмжиж байгаа. Дээрээс нь бас нэг зүйлийг хэлэх нь зүйтэй. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт орж байгаа дээр нэг зүйлийг хэлэх нь зүйтэй гэж ингэж бодож байгаа юм. Энэ юу вэ гэвэл өнөөдөр энэ эрх барьж байгаа Монгол Ардын нам Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын толгойлж байгаа энэ нам энэ шинэчлэлийг хийхийн төлөө маш зоригтой алхам хийж өнөөдөр орж ирж байгаа.

Үнэндээ 2024 оны сонгуулиа л зөвхөн тооцсон. Зөвхөн намаа ялалтад хүрэхийн тулд тооцсон ийм байдалтай орсон бол хуучин системээрээ энэ сонгуульд орох ёстой байсан маш олон одоо хүмүүс ярьж байгаа үүнийг бол бас хэлэх нь зүйтэй гэж ингэж бодож байгаа.

Та бүхэн санаж байгаа байх 2012 оны сонгууль ийм холимог системээр явсан Монгол Ардын нам ялагдсан байгаа. Тэгээд энүүгээрээ би юу хэлэх

гээд байна вэ гэвэл залуу Ерөнхий сайдын хувьд Оюун-Эрдэнэ сайд энэ шинэчлэлт өөрчлөлтийг энэ улс эх орны хөгжлийн төлөө нэлээн зоригтой алхам хийж ингэж оруулж ирж байгаад нэгдүгээрт баяр хүргэх ёстой гэж ингэж бодож байгаа юм. Гишүүд тоотой холбоотой нэлээд олон одоо янз бүрийн л асуудлууд ярьж байна. Гэхдээ энэ олон улсын сайн жишиг энэ судалгаануудыг бас үзэж харах нь зүйтэй гэж ингэж бодож байгаа.

1992 оны Үндсэн хуулийг батлахад Үндсэн хуулийн эрх баригч Чимэд гуай анх 2 сая хүнтэй байсан тухайн үеийн Монгол Улс 120 Улсын Их Хурлын гишүүнтэй байх нь зүйтэй гэсэн ийм одоо саналыг оруулж ирсэн байдаг юм байна лээ. Тухайн үеийн одоо Их Хурал буюу тухайн үеийн Ардын депутатууд бол 52 гэдэг дээр тохироод дундын хувилбар өнөөдөр 76 гэсэн одоо Улсын Их Хурлын гишүүдийн төлөөлөлтэй өнөөдөр ингээд одоо 30 дахь жилдээ золгож байгаа.

Олон улсын жишигүүдийг харах юм бол 5-6 сая орчим иргэнтэй Эстони, Латви, Литви гэсэн энэ улсууд 100-200-гийн хооронд одоо Их Хурлын гишүүдтэй гээд ингээд одоо тоон дээр ярих юм бол маш олон зүйл ярьж болох байх.

Тэгэхлээр яах вэ бид нар ирэх 7 хоногоос иргэд сонгогчидтойгоо одоо хэлэлцүүлгийн шатанд энэ асуудлыг бас нэлээн сайн нухацтай ярих нь зүйтэй гэж ингэж бодож байна. Ер нь бол зүгээр аливаа парламент хууль тогтоохоос гадна бас нэг чухал гол үүрэг бол ерөөсөө иргэд сонгогчдыг төлөөлөх энэ төлөөллийн гол зарчим байгаа юм. Энэ төлөөллийн зарчим нь нэг 2 үндсэн зүйлээр хангагдаж байгаа гэж ингэж ойлгож байгаа юм.

Нэгдүгээрт газар нутаг, хоёрдугаарт хүн амын төлөөлөл. Газар нутгийн төлөөлөл бол өнгөрсөн 30 жилийн хугацаанд энэ одоо сонгуулийн тогтолцоогоор бол сайн хангагдаад

ирсэн. Өнөөдрийн энэ 76 Улсын Их Хурлын гишүүний 52 нь орон нутаг буюу газар нутгийн одоо төлөөллийн зарчмыг илүү хангасан байдалтай, 24 нь нийслэл Улаанбаатар хотоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд байдаг. Энүүгээр харахаар газар нутгийн төлөөлөл өнгөрсөн 30 жилийн хугацаанд маш сайн хангагдсан. Хүн амын тал хувь нь буюу яг 50 хувь нь байгаа Улаанбаатар хотод 24 гишүүн төлөөлж ажиллаж байгаа.

Ингэснээрээ өнөөдөр энэ Улаанбаатар хотын одоо хөгжлийн асуудал, энэ төвлөрлийн асуудал, түгжрэлийн асуудал, Улаанбаатар хотод үүсээд байгаа асуудлууд одоо бид бүхний нүдэнд илхэн харагдаж байгаа. Ийм учраас би асуулт бол ер нь энэ Үндсэн хуульд өөрчлөлт орсноор цаашидаа энэ Улсын Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдсэнээр энэ холимог системд шилжсэнээр Улаанбаатар хотод энэ хүн амын төлөөллийг хангах энэ зарчмыг хэр барьж энэ хуулийн төслүүд, энэ сонгуулийн хууль, дагаж хамт орох сонгуулийн хуулиуд дээр ер нь хуулийн төсөл санаачлагч ямар байр суурьтай байгаа вэ гэж ингэж асуух гэсэн юм.

Мөн дээрээс нь энэ пропорциональ, мажоритар гэсэн энэ 2 систем энэ холимог системийг бол 50, 50 байх нь зүйтэй гэж үзэж байгаа. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид нар жижиг тойргийн төлөөлөл хангасан энэ Улсын Их Хурлын гишүүдтэйгээс үүдэлтэй улс эх орны томоохон хөгжлийн үндэс болсон, хөрөнгө оруулалт болсон энэ ажлууд бол зогссоныг бол харж байгаа.

Тийм учраас энэ улсын нийслэл, Монгол Улсын нүүр царайг тахалдаг энэ Улаанбаатар хотын төлөөллийн зарчим дээр ямар байр суурьтай байгаа вэ гэсэн энэ асуулттай байна.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь

аймгийн Даланжаргалан сумын малчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ ажил хөдөлмөрийн өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Асуултад 86 хариулья. Бумдарь МУИС-ийн Улс төрийн танхимын профессор, доктор.

Д.Бумдарь: Өдрийн мэнд хүргэе. Бат-Амгалан гишүүний асуултад хариулья. Тэгэхээр мэдээж хэрэг иргэдийн санал гээгдэхгүй байх, мөн төлөөллийн ардчилал учраас 1 санал, 1 төлөөлөл гэдэг зүйлийг зарчмыг бол ялт ч үгүй барих нь бол зүй ёсных. Гэхдээ бид нарын оруулж ирж байгаа энэ хувилбар бол тойргийн мандатыг яаж хуваах вэ гэдэг нь бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал учраас бол яг тэр дээр бол хуваагдалт бол хийгээгүй. Аль болох иргэдийн саналыг гээгдүүлэхгүй байх, санал бүр ижил жинтэй байхыг бол эрхэмлэж байгаагаар 50, 50 хувийг ингээд хуваагдлыг хийж, явуулж ирсэн.

Учир нь юу вэ гэх юм бол хувь тэнцүүлсэн элемент нь өндөр байх тусмаа иргэдийн өгсөн санал суудал болж хувирах магадлал өндөр байдаг буюу шууд хамааралтай байдаг учраас 50 хувь гэсэн ийм онолын үндэслэлийг бол барьж бол жагсаалтыг 50 хувь, мажоритарыг 50 хувь гэсэн байдлаар бол төсөл бол оруулж ирсэн байгаа.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ сонгуулийн тогтолцооны реформ хийгдчихвэл би яах вэ нэг жишээн дээр л ярья л даа. Улаанбаатар хотын нийт авто замын урт 1213 километр байдаг юм байна. Танай Баянзүрх болохоор 205 километр замтай, Чингэлтэй 107 километр, Баянгол 152 километр, Сүхбаатар дүүрэг 147 километр, Хан-Уул 207

километр, Сонгинохайрхан 207 километр гээд энэчээнээс Багануур 54, Багахангай 27 километр. Энэ бол 2 бүтэн хэмжээнд нийслэл Улаанбаатар хотыг тойрох хэмжээний урт тойрог замтай болчих боломжтой байсан гэсэн үг.

Гэтэл төсөв дээр тавьсан замуудыг ингээд надаа газрын зураг нь байж байна л даа. Ингээд харахаар ихэнх нь дандаа мухар замууд байна гэсэн үг. Жижиг тойрог дээр очоод, явж байгаад ингээд 7-10 километрийн ийм замууд маш их байгаа юм. Үерийн далан дагуу барьчихсан замууд байна. Мөн зуслан чиглэлийн тавигдсан замууд бас нэлээдгүй байдаг юм байна. Мөн зарим уулзваруудыг өргөтгөсөн ийм замууд. Харамсалтай нь энэ бүх замууд хоорондоо ерөөсөө холбогдоогүй, холбогдох тийм концепцыг ерөөсөө хийгээгүй. Уг нь энэ нийслэл дээр байдаг.

Гэтэл энэ болохлоор нийслэлд сонгогдсон гишүүд дээр төсөв тавихдаа ингээд могойчлоод өөрчилчихсөн асуудал. Энэ замуудыг хооронд нь 1213 километрийг хооронд нь холбоход ерөөсөө л 200 километр зам хэрэгтэй байгаа юм. Хөдөө орон нутагт бол 3 сумыг хооронд нь холбох хэмжээний л ийм зам гэсэн үг. Энэ тохиолдолд Улаанбаатар хот заавал метро барина гэхгүйгээр, заавал LRT барина гэхгүйгээр одоо байгаа авто замын түгжрэл 30 орчим хувьтай. Ерөөсөө л 200 километр зам барьснаар буурах боломжтой гэдэг тооцооллыг гаргаж ирж байгаа юм.

Энэ өөрөө юу гэсэн үг вэ гэхээр мажоритар тогтолцоо дээр нийслэлээ ч бүтэн харж чадахгүй байгаад байна гэсэн үг. Нийслэлээ ч бүтэн харж чадахгүй. Пропорциональ тогтолцоо ингээд орохлоор 30 хувиар нэмэгдье гэж бодъё эсвэл 40 хувь, 50 хувиар ч юм уу ингээд нэмэгдлээ гэж бодоход тэр бүх төлөөллүүд нийслэлийн бодлогыг, улсын бодлогыг, бүс нутгийн бодлогыг илүү том агуулгаар харах ийм агуулга руу л орох боломжтой гэсэн үг нэг талдаа.

Нөгөө талдаа сая ингээд танилцуулгууд явж байна. Жишээлбэл манай ингээд хилийн цэргийнхэн хүртэл ингээд энэ чинь бөөнөөрөө орж ирэх ёстой шүү дээ. Гэтэл Баян-Өлгийн хилийн цэрэг, Налайхын бөхчүүдийн төлөөлөл, Дорноговийн малчдын төлөөлөл гээд ингээд орж ирж байна гэдэг нь энэ нийгмийн сегментийг бид нарын хувьд үндэсний хэмжээнд харж чадахаа больчихсон гэсэн үг. Санаачилгатай, ажиллагаатай гишүүд нь болохлоор Төрийн ордон үзүүлээд байдаг. Санаачилгадаа жоохон ажиллагаа тааруу гишүүнтэй тойргууд бол Төрийн ордонд орж ирж бараг чадахгүй байгаад байна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээрээ энэ маань өөрөө үндэсний хэмжээнд энэ бодлого маань гарч ирнэ гэсэн үг. Жишээлбэл энд ингээд 50, 50 хувьтай байвал хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн төлөөлөл танхимд сууж байна. Тэр хүн нь өөрөө манай хөгжлийн бэрхиээлтэй иргэдтэй холбоотой бодлого ингэж хэлэлцэгдэж байна гэж парламент дээр урина гэсэн үг. Багш нар, эмч нар, инженерүүд гээд. Энэ сегментийн бүлгийг хэрвээ улс төрийн намууд жагсаалтдаа оруулахгүйгээр зөвхөн улс төрчид өөрсдөө жагсаалтад орвол тэр нам санал авахгүй л гэсэн үг. Ялагдана гэсэн үг. Тэр нийгмийн сегментийн төлөөллийг хангаж чадсан нам нь ялна гэсэн үг. Маш энгийн.

Тэгэхээр яах вэ, ийм агуулгаараа л нөгөө нийслэл дээр ч бай, улсын хэмжээний бодлогын хувьд ч бай энэ маань өөрөө их тийм бас чухал том реформ болох бол магадлалтай.

Мэдээж давуу болон сул талууд бол байна. Тэрийг бол бидний хувьд ярьсан. Би тэгээд дахиад хэлэхэд энэ бол хэлэлцэж эхэлж байгаа л ийм асуудал, эцэслэн шийдвэрлэх онцгой бүрэн эрх гагцхүү Улсын Их Хуралд, ард түмэн, сонгогчдын гар дээр л байж байгаа гэсэн үг.

Тэгэхээрээ энэ давуу болон сул талуудаа бид нар ярих нь зүйтэй. Ярина гэдэг бол өөрөө маш том алхам. 2019 онд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үед энэ яригдсан учраас өнөөдөр хэлэлцэх түвшинд бас орж ирээд ингээд ярилцахад нийгэм бас мэдээлэлтэй байгаа юм.

Тэгэхээрээ энэ өнөөдөр хийгдэж чадвал сайн, хийгдэж чадахгүй бол маш том судлагдахуун болоод дараагийн парламентууд хэлэлцэх ийм суурь болно л гэсэн үг. Тэгэхлээрээ энийг бол бид нар ярилцаад давуу болон сул талаа хэлэлцээд, ойлголцоод ингээд явах нь л туйлын чухал юм гэдэг агуулгаар яг тодорхой асуулт энэ байлаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар миний хувь хүний байр сууриас гадна бас саяхан манай Үндэсний бодлогын хороо хуралдсан. Энэ хорооны хурал дээр бол эхнээс нь дуустал бүх гишүүдийнхээ саналыг нэг нэгэнгүй тэмдэглэж авч бас энэ өөрчлөлтийг бид нар ярилцаж байна.

Тэгэхээр 1 асуудал яг тодорхой асуулт би Ерөнхий сайдаас асуумаар байна. Одоо манай иргэд бас ингэж надаас их олон асууж байна. Яг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө хийчхээд л сонгуулийн хуулиа хичээл тэгээд л намар сонгууль явуулах гээд байна гэсэн ийм зүйл бол асууж байгаа. Тэгэхээр энэ дээр та бас нэг шууд тодорхой хариулт өгөөд хүмүүсийн энэ эргэлзээг бас тайлах нь зөв байх.

Хэд хэдэн санал байгаа. Ер нь энэ сонгуулийн холимог тогтолцоог бол энэ парламент эхэлснээс хойш л идэвх санаачил гарган ажилласан. Нийт 21 онд 10 удаа, 22 онд 30 гаруй хэлэлцүүлгийг хийж, хамтарч ингээд оролцсон байна. Өнөөдөр энэ холимог тогтолцоо яг Үндсэн хуульдаа ороод ингээд түгжигдэх

гэж байгаад би бол баяртай байна. Тэрнээс бол зөвхөн нэг Улсын Их Хурал юм уу Цэц шийддэгт би бол итгэл төрөхгүй байсан.

Тэгэхээр энэ хамгийн чухал ач холбогдол нь юу вэ гэхээр энэ төлөөллийн ардчилал бол хэрэгждэг. Ер нь энэ эмэгтэйчүүдийн төлөөлөл эмч нар, багш нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчин, сувилагч, инженер гээд энэ төлөөллүүд бол орж ирэх ийм боломж бол нээгдэж байгаа.

Тэгэхээр энэ дэлхийн статистикийг хараад байхаар ерөөсөө энэ төлөөллийн ардчилал бүрдсэн улс орнуудын хөгжил бол маш хурдтай бол явсан байна. Жишээлэхэд 1 иргэнд ноогдож байгаа дотоодын нийт бүтээгдэхүүн нь бол хамгийн өндөр орнууд гэхээр яах аргагүй л энэ эмэгтэйчүүдийн төлөөлөл бусад энэ бүх төлөөллүүд орсон орнууд бол яах аргагүй үнэхээр хүссэн, хүсээгүй бүүр шууд хамааралтай байна. Тийм ч учраас энэ Нэгдсэн Үндэстний байгууллагаас бас энэ дээр анхаараад ингээд төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлээд байгаа байх.

Тэгээд бид бол дандаа нэг хүнээс зөвхөн тусламж талыг нь харах ёсгүй. Бас үүргээ харах ёстой. Нэгдсэн Үндэстний байгууллагын 2030 оны Монгол Улсын биелүүлэх тогтвортой хөгжлийн 17 зорилтын 1-д нь бол энэ парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоог 50, 50-д хүргэх ёстой гэсэн ийм зүйл байгаа. Тэгээд энэ дээр Сарангэрэл дарга бид 2 бол бас энэ сүүлийн 2 жил бас нэлээд ажиллалаа. Тэгээд намуудын сонгуулийн хууль бас эмэгтэйчүүдийг дэмжсэнээр орж ирж байгаад бол би бас их баяртай байна бас. Үүний төлөө бид бас л их олон жил явлаа, тэмцлээ, зүтгэлээ.

Тэгэхээр өнөөдөр ер нь энэ эмэгтэйчүүд олон байгаа парламентад байгаа газрууд ер нь тэр ядуурлын асуудал, эрүүл мэнд, боловсролын асуудлыг нэг их ярихаа больсон байна.

Энэ бүүр уже шийдэгдчихсэн байна. Одоо эдгээр хүмүүс юу ярьж байна гэхээр ерөөсөө энх тайван, даян дэлхийд энх тайван байх, энэ байгаль экологийн сүйрэлгүй байх энэ рүү ярьж эхэлж байна.

Гэтэл өнөөдөр манайд ямар байна гэхээр ерөөсөө л нөгөө ядуурлаа л бид нар яриад л, нөгөө л эмнэлэг, сургуулиа л ярьсаар байгаа шүү. Тэгээд манай эмэгтэй гишүүд Нийгмийн бодлогын байнгын хороонд олонх байдаг тэн дээрээ маш олон чухал санал гаргадаг. Энэ эмнэлгийн засваруудаа хийе, хүүхдийн мөнгө олгоё, энэ төсөв хөрөнгөө энэ Зөв Монгол хүүхэд тэр хүн хөгжүүлэхдээ зарцуулъя гээд зөндөө санал гаргадаг шүү дээ. Төсвийн байнгын хороон дээр орж ирээд л унадаг. Энэ бол нууц зүйл биш шүү дээ.

Тэгэхээр бид нар энэ өөрсдийнхөө шийдвэр гаргах түвшинд кнопоо нэмж байж энэ асуудлууд бол шийдэгдэх юм байна. Ер нь Монголчууд бид энэ арга, билгийн ухаанаар амьдарч ирсэн улс орон. Тэгэхээр энэ дээр бол энэ аав, ээжийн төлөөлөл гэдэг шиг ер нь бүх л төлөөлөл бол байх ёстой юм.

Сая бол та нар харлаа энэ скаутын хүүхдүүд орж ирж байна. Амьдрах ухаан заадаг иймэрхүү төрлийн төрийн бус байгууллагад жоохон төсөв хөрөнгө тавья гэхэд л хөтөлбөр санхүүжүүлэхгүй л гэдэг шүү дээ. Тэгээд л нэг шавар байшин юу нэг мод ийм л юм санхүүжүүлэхээс ерөөсөө Монгол хүнээ санхүүжүүлдэггүй.

Тийм учраас энэ төлөөллийн ардчилал бий болсноор одоо жишээлэхэд сувилагчийн дутагдалд орчихсон байгаа. Сая би нэг Солонгосын парламентын гишүүн эмэгтэйтэй уулзсан. Би 40 жил сувилагч хийгээд намайг сувилагчдын төлөөлөл гээд оруулсан гэж. Өнөөдөр Монгол Улсад сувилагчийн дутагдалд орчихсон. Энэ чинь жижиг асуудал биш шүү дээ. Том асуудал. Тийм учраас энэ энэ төлөөлөл бол орж ирдгээрээ чухал

юм. Тийм учраас би энэ холимог гэдгээр нь дэмжиж байгаа.

152 гишүүний хувьд бол бас 152 гишүүнийг дэмжихгүй байна. Сая гишүүд өөрсдөө тайлбар хэлж байгаа нь ингээд өөрсдийгөө их доош нь хийх юм. Олон болохоороо лоббинд автдаггүй, олон болохоороо эрх юу гэдэг юм, авлигад өртдөггүй гээд. Үгүй ээ бид нар 1 хүн байсан ч гэсэн энэ янз бүрийн зүйлд өртөж болохгүй шүү дээ. Лоббинд өртөж болохгүй, авлигал авч болохгүй. Тэгээд олон болохоороо тэр нь ингээд больчихдог гэсэн тийм зүйл бол байхгүй шүү.

Мэдээж яах вэ 1 гишүүн бол олон Байнгын хороон дээр байдгаас энд бол сөрөг талууд гардаг. Жишээлэхэд Байнгын хороо 17 хүн байхаас 9 хүнээр ирц бүрдээд л 5 хүнээр улс орны асуудал шийдэж байгаа. Энэ бол бас дэндүү юутай асуудал гэдгийг бол би ойлгож байна.

Энэ дараа дараагийн хэлэлцүүлэг дээр тоо буурахгүй бол дэмжих боломжгүй. Тоо буурвал дэмжинэ гэдгээ хэлчихье.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахдаа анх бол ингээд 5 зүйлээр санал авсан байдаг. Тэгээд одоо ихэнх нь хасагдаад ороод ирсэнд бас жоохон харамсаж байна. Одоо жишээлэхэд энэ 66.1 байна, энэ Үндсэн хуулийн цэцийн асуудал байна. Иргэний эрх эрх чөлөө зөрчсөн асуудал. Бид нар Үндэсний бодлогын хороогоо хуралдуулаад яг энэ санал дээр 5 санал бэлд гээд ирсэн байхгүй юу. Шүүхийн тогтолцооны асуудал, иргэний эрх чөлөө ингээд маш олон асуудлаар 5 асуудлаар Үндсэн хуулийн дархлааг сайжруулах, Үндсэн хуулийн цэцийн асуудал гээд оруулж ирсэн. Тэгээд эд нар бүгд орж чадахгүй болчихлоо. Тэгэхээр энэ дээр бас харамсалтай байна.

Тэр Засгийн газрын шийдвэрийг өнөөдөр ингээд шүүх хэлэлцээд байж

байгаа. Энэ бол туйлын буруу шүү дээ. Энийгээ бид нар засах ёстой. Тэр Үндсэн хуулийн цэц нь хэлэлцэх ёстой юу? Ингээд хамтын шийдвэр гаргадаг байгууллагыг өнөөдөр хэн нэгэн шүүх ингээд шүүж байна гэдэг бол Засгийн газар зоригтой реформ хийж чадахгүй ийм зүйл болно.

Төгсгөлд нь хэлэхэд бид нар бас энэ гадаад нэр хүндээ нэлээн бодох ёстой юм. Шүүхийн шийдвэргүй баривчилгаа нь 98 хувьтай байна гэсэн НҮБ-ын энэ шийдвэрийн дагавар бид нар санал, асуулт тавьсан. Тэгээд Нямбаатар сайд энэ дээр бол нэлээд учир шалтгааныг тайлбарлаж бас энэ дээр бид хамтарч ажиллах болсон. Тэгээд өнөөдөр Засгийн газарт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 31.5.1.2 дахь хэсэгт би нэмэлт оруулахаар Засгийн газарт санал хүргүүлсэн байгаа шүү. Энийг шийдэх юм бол бидний энэ гадаад нэр хүнд бол бас нэлээд өснө гэдгийг бол хэлмээр байна. Энэ минут нь харагдахгүй юм. Юм яачихлаар хэдэн минут дутуу байгаа юм бол?

Төгсгөлд нь хэлэхэд ер нь бол энэ би 12-16 оны парламентад байсан.../минут дуусав./

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар, Ням-Осорын Учрал нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт иргэд та бүхэнд сайн сайхныг гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Хэн хариулах вэ? Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

Л.Оюун-Эрдэнэ: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Үндсэн хууль баталчхаад намар сонгууль хийх үү гэж байна. Үгүй. Парламент бол манай тусгаар тогтнол, ардчилал, эрх чөлөөний

ийм бэлгэдэл. Ард түмний сонгож байгуулсан ийм Үндсэн хууль төр.

Тийм учраас хэн нэгэн хүн тараая гээд тарчихдаг, гадна дотнын аливаа шахалтаар үйл ажиллагаа явуулдаг ийм байгууллага бол огт биш. Тийм учраас Монгол Улсын Их Хурлын сонгууль яг цагтаа явна. Энэ дээр манай иргэд, хувийн хэвшил, улс төрийн намууд бол тайван байж болно гэдгийг албан ёсоор хэлье. Цаашидаа ч энэ бүрэн эрхийн хугацаа бол огт өөрчлөгдөхгүй байх учиртай.

Нөгөө талаараа бас улс төрийн ийм том тогтолцооны сонгуулийн реформ хийхэд энэ дээр бэлтгэл ажлаа маш сайн хангах ёстой. Тэгэхгүй бол эрх баригч нам ямар нэгэн байдлаар өөртөө давуу байдлыг үүсгэх ч юм уу энэ агуулгаараа бидний хувьд бол хандахгүй. Шударгаар бусад улс төрийн намууддаа тэгш боломжийг олгож, өрсөлдөгчөө ямар нэгэн байдлаар харлуулах, гүтгэх биш бодлогын мэтгэлцээнээр өрсөлддөг ийм цоо шинэ сонгуулийн шинэ соёл 2024 онд бүрдээсэй гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт тооны асуудал. Мэдээж тооны асуудал. Би дахиад хэлэхэд Засгийн газраас өнөөдрийн оруулж ирж байгаа хувилбар бол хэлэлцүүлэгт оруулж ирж байгаа л ийм хувилбар. Эцэслэн батлах эрх гагцхүү Улсын Их Хуралд, гагцхүү Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалагдана.

Тоон дээр их олон л тоонууд гарсаар ирсэн юм байна лээ. Өмнө нь 6 ч удаагийн ийм хэлэлцүүлэг болж байсан юм байна лээ. 99 байх нь зүйтэй гэдэг ийм агуулга ч их яригдаж байсан юм байна лээ. Бүүр 92 онд л энэ агуулга яригдаж байсан юм байна лээ. 108 байх нь зүйтэй. 108 гэдэг бол бас их чухал тоо гээд ингээд ярьдаг ч хэсэг байдаг. 152 байх нь зүйтэй. Төлөөллөө одоо байгаа 76 дээр тойрог хасаж маргаан үүсгээд яах вэ төлөөллөө 2 дахин нэмчихье л гэдэг агуулга шүү дээ. Өнөөдрийн оруулж ирж

байгаа хувилбар бол ийм агуулга байдаг. 3-ны 1-ээр явъя. Заавал 50 хувь гэж том алхаад яах вэ 30 хувь болгочихъё тийм ээ пропорциональ тогтолцоогоо. Энэ тохиолдолд 134 болгоод ингээд явъя ч гэдэг зүйл байдаг.

123 байя бас өгсөх тоо, 76 буурдаг тоо гээд ч ярьдаг хүмүүс байдаг юм байна лээ. Энэ бүх зүйл ингээд л чөлөөтэй мэтгэлцээн рүү л ингээд орж байна л гэсэн үг. Тэгээд бүгдээрээ ярилцаж байгаад л энэ асуудал эцэслэн хэлэлцэх эсэх нь бол парламентын л онцгой бүрэн эрхийн асуудал. Ямар томъёоллоор яаж хийгдэх нь вэ, 57 гишүүн дэмжих ёстой. 57 гишүүн ч биш ер нь бүгдээрээ л дэмжиж байж батлагдвал өөрөө Үндсэн хууль маань өөрөө легитим талаасаа их чухал болно. Тэгэхлээр ингээд өнөөдрөөс хэлэлцүүлэг ингээд эхэлж байна гэдэг нь чухал юм гэж бодож байна.

Энэ шүүхтэй холбоотой би бас санал нэг байна. Ер нь бол гүйцэтгэх засаглал шийдвэр янз бүрийн шатад хянагдах энэ зүйлийг бол бид нар хувьдаа бас хамтдаа ярилцаж илүү их тийм зөв болгох зайлиггүй шаардлагатай. Хүний эрхийн асуудлууд дээр би бас Засгийн газрын хуралдаан дээр бол нэлээн сайн чиглэл өгсөн Нямбаатар сайдад. Бид нар хүний эрхийн 22 дахь удаагийн дүгнэлт дээр бол нэлээн сайн анхаарал хандуулаад бүүр нарийвчлаад бид нар Трансперенси интернэйшнлийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа шиг бүүр гүнзгий орох ёстой юм байна лээ. Тэр дээр Одонтуяа дарга бас оролцоод хэдүүлээ хамтдаа л яг индексүүдээ ахиулаад, олон улсад илүү зөв ойлголт өгөх ёстой гэдэг дээр бол би 100 хувь санал нэг байгаа.

Тэр шүүхийн шатад бас шийдвэртэй, шийдвэргүй гээд ийм олон асуудлууд байж байгаа. Энэ нь аль нь яг аль түвшиндээ эрх зөрчвөл тэр дээр эрх зүйн ямар өөрчлөлтүүд гарах вэ гэдгийг ярилцаж байгаад тийм завхрал байгаа бол түүнийг засаад, нээлттэй ил тод болгоод явах нь бол хамгийн чухал юм

гэдэг агуулгаар хандаж байгаа гэдгийг хэлье. Тэгээд нэмэлт асуулт байвал тодруулгаар хариулъя.

Г.Занданшатар: Болчихсон уу? Баярлалаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өдрийн амгаланг эрье. Тэгэхээр Үндсэн хууль бол маш хариуцлагатай хандах ёстой ийм зүйл. Үндсэн хууль бол эрх мэдлийн дээд хязгаар учраас бол энийг бид нар хөдөлгөнө гэдэг бол эрх мэдлийн хуваарилалтыг өөрчилдөг. Мөн ярьдаг жишээлбэл төр ард түмний гэрээ юм гэж. Тийм учраас төрийн ч, улс орны ч, иргэдийн ч хувь заяаны асуудал байдаг юм.

Тэгэхээр би бол энэ Үндсэн хуулийг бол ойр ойрхон өөрчлөлт хийхийг нэг их сайн дэмждэггүй. Өнөөдөр бол би зүгээр санал хэлнэ. Асуух зүйл бол алга. Өмнө нь ч байр сууриа илэрхийлж байсан.

Нэгдүгээрт бол би тэр тогтолцоо, тэр нөгөө пропорциональ тогтолцоо гэдгийг бол дэмждэггүй. Намын жагсаалтын ард хүн сонгогдохыг бол би дэмждэггүй.

Хоёрдугаарт бол ер нь бол энэ сонгуулийн тогтолцоо өөрчлөхөөс гадна тоо нэмж байгаа асуудал бол бас иргэд хэр хүлээж авч байна вэ гэдэгт би эргэлзээд байгаа юм. Иргэд бол энийг бас дэмжихгүй байгаа учраас. Намын жагсаалтын ард 12 онд бид нар сонгууль явуулсан. Иргэд юу гэж хэлсэн гээд тэгэхээр хаалгаар өшиглөөд гарчхаад тооноор оруулаад ирж байна гэж. Одоо бол манайхаар энэ манайхан юу гэж яриад байгаа вэ гэхээр санал гээгдэж байна гэж. Үгүй ээ энэ чинь их сонин юм байгаа байхгүй юу. Одоо жишээлбэл ингээд энэ олон ургалч үзэлтэй зах зээлийн тогтолцоонд чинь бол 100 хувийн санал авдаг гишүүн гэж 1 ч гарч ирээгүй. Цаашилаад 1 ч гарч ирэхгүй.

Тэгэхээр нөгөө гишүүн болоогүй нөгөө саналаа өгөөгүй хүн нь гишүүн болчихоор чинь нөгөө олонхын гишүүн болгосныхоо төлөө санал өгсөн олонх чинь дургүйцнэ шүү дээ. Бид энийг санал гишүүн болгоогүй байхад хэдхэн хүний санал авчхаад энэ гишүүн болоод явж байна гэж. Энэ тэгээд зөв үү? Тэр нэг санал гээхгүй байна гээд байгаа чинь. Ийм нэг асуудал байгаа юм.

Ер нь намын жагсаалтын ард бол яах вэ дээ тэгээд л янз бүрээр тайлбарлаж болно. Гэхдээ л нөгөө янз бүрийн юманд холбогддог ард түмний итгэл алдсан хулгарууд бол ороод л ирнэ. Ороод л ирнэ. Тэгэхээр энэ тогтолцоогоор бол жишээлбэл намын нэрийн ард хүн байна гэж байгаа юм. Хүнээ дугуйлсан ч намын хувьд л тооцогдоно гэж байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол нэлээн хойхон жагсчихсан нэр хүндтэй нөхрийг ингээд ард түмэн сонгогч нар дугуйлаад байлаа гэхэд намын эхэнд жагсчихсан нөгөө муу нэртэй нөхөр гишүүн болчихож байгаа байхгүй юу. Энэ чинь байж болохгүй зүйл шүү дээ. Энэ асуудлыг бид нар их анхаарахгүй бол болохгүй нь гэж.

Мөн намууд төлөвшинө гээд байгаа юм. Үгүй ээ тэр муу улсууд намын жагсаалтын ардууд нуугдаад байхаар чинь яаж нам төлөвших юм бэ. Энэ ард түмний итгэл алдсан улсууд тэнд чинь орчихоод байхаар яаж ард түмэн итгэх юм бэ тэр намд. Ялангуяа ингээд энэ 24 оны сонгуулийн дараа нөгөө ард түмний дургүй хэдэн гар энд сууж байх юм бол би энэ дэлбэрчих гээд байгаа ард түмэн юу болохыг бол хэлж мэдэхгүй байна. Ийм л зүйл. Нам ч доройтно, төр ч доройтно. Тийм учраас энэ дээр бол анхааралтай хандаарай гэдгийг би бас бодоод байгаа юм.

Тоон дээр бол мэдээж ард түмэн яаж хандахыг бол бид хэлж мэдэхгүй байна. Би бол дургүй байгаа гэж бодож байгаа. Тэгээд энэ гишүүдийн тоо нэмэх асуудлыг бол иргэдээсээ сайн асуугаарай гэж. Энэ намын жагсаалтын ард

сонгогдохоор улс орноо боддог улсууд гарч ирнэ гээд байгаа юм. 12 онд ингэж сонгосон байхгүй юу. Тэр 28 хүн улс орноо бодоод л, тэгээд л хөгжил яриад л ийм гийгүүлсэн юм огт байгаагүй байхгүй юу. Тэгэхээр энэ пропорциональ тогтолцоо гэдэг чинь 12 онд бол туршигдаад үзчихсэн. Тэр нам бэхэжсэн юм байхгүй, улс орон хөгжссөн юм байхгүй бахь байдгаараа. Харин ч бүүр ард түмний дургүй хүргэсэн 20 хэдэн хүн болсон байхгүй юу.

Тийм учраас 16 онд Цэцээр энийг чинь хүчингүй болгосон юм. Тэгэхээр иргэдээсээ сайн асуу. Өнөөдөр бол би надад иргэдээсээ асуугаагүй байж байж иргэд энийг дэмжиж байгаа эсэхийг мэдэхгүй байж байж би тэдний өмнөөс санал илэрхийлэх бол хувьдаа ямар ч боломжгүй. Тэгээд энэ бол Үндсэн хууль. Тийм учраас бид нар бол маш анхааралтай хандахгүй бол болохгүй байна гэж.

Үндэсний аюулгүй байдалд гишүүдийн тоо нэмэхээр сайжирна гээд байна. Үгүй ээ би бол харин эсрэгээрээ энэ пропорциональ тогтолцоог аюултай гэж үзэж байгаа юм. Яагаад гэвэл пропорциональ тогтолцоотой улс орнуудад гаднын улс орнуудын бодлогыг дэмжсэн гэдэг юм уу, үндэсний бодлоготой, аль эсвэл шашны урсгалыг дэмжсэн ийм намууд бол бий болдог. Энэ пропорциональ тогтолцоо орж ирснээр. 2014 онд бид нар Норвегт айлчилсан. Норвегийн парламентын дэд дарга нь Пакистан хүн байсан. Яагаад гэвэл лалын намын лалын цагаачид нь дэмжчихсэн.

Тэгэхээр бид нар юу энэний Үндсэн хуулийг яаж бодох ёстой гэвэл юу ч болж болно. Юу ч болж болно гэж. Жишээлбэл, манайд жишээлбэл урд хөрийд байдаг юм уу, хойд хөрийд байдаг юм уу томоохон хөдөлгөөн гараад сая сая дүрвэгсэд ирж болно. Ирж болно, Хэдэн жил ч манайд амьдарч болно. Аягүй бол иргэн ч болчихож мэднэ.

Гэтэл бид бол пропорциональ сонгуулийн тогтолцоотой байх юм бол яг энэ Норвег шиг балрах байхгүй юу. Хамгийн аюултай юм бол энэ пропорциональ тогтолцоонд бол энэ байдаг юм гэж. Тэгээд Засгийн газар тогтворгүй болдог. Яагаад гэвэл нөгөө олон намууд ороод ирдэг юм. Тэгээд л нэг учир нь олдохгүй олон юм. 12 онд тийм байсан юм шүү дээ. Олонх гэж байхгүй. Тэгээд л нөгөө 2 намтайгаа ээлжилж олон болсон нам нь солиод л, тогтворгүй. Хамгийн их улс орон хямарсан, өрөнд орсон ийм жилүүд бол тэр үед байсан юм.

Тэгэхээр энд бол нэгдүгээрт Улсын Их Хурлын гишүүд тангаргаа өргөсөн бидний хувьд бол бас энэ ард түмний сонгох эрхийг энэ чинь нөгөө нам сонгох эрхээ, хүнээс сонгох эрхийг нь сольчих гээд байна шүү дээ.

Тэгэхээр тангараг өргөсөн гишүүн бидний хувьд бол энийг ард иргэдтэйгээ сайн ярьж байж шийдэхгүй бол энэ болохгүй. Бид тангараг өргөсөн шүү. Та нарын төлөө үнэнч зүтгэнэ, улс эх орныхоо төлөө үнэнч зүтгэнэ гэж ингэж тангараг өргөсөн улс.

Тийм учраас энийгээ бол ард түмэнтэйгээ маш сайн зөвшилцөөрэй. Ер нь бол хэлэлцүүлэг гэж байдаггүй юм Үндсэн хуульд. Ард түмний санал асуулга явуулна гэж байдаг юм.

Тэгэхдээ одоо адаглаад тэр фейсбүүк, сайтаар гэж байсан дор бол очиж уулзаад, хэлэлцээд ингээд ирсэн нь дээр байх. Яагаад гэвэл бид тэднийг төлөөлж байгаа мөртөө 2 нүүр гаргаж болохгүй. Сонгуулиар очихоороо ёстой та нарын төлөө үхэн хатан зүтгэнэ гэж саналыг нь авчхаад, гишүүн болсныхоо дараа сонгох эрхийг нь та нарын эрх ашгийн төлөө гэж хэлж авч байгаа юм шүү. Бас тэр их муухай. Ард түмнийхээ эрх ашгийн төлөө гэж ингэж хэлэх гээд байгаа байхгүй юу. Энэ бол эвгүй зүйл. Тийм учраас иргэдээсээ энийг сайн асуух нь чухал юм гэж ингэж бодож байгаа

юм. Тийм учраас уг нь болж өгвөл гишүүд.../минут дуусав./

Г.Занданшатар: Асуулт биш үндсэндээ саналууд байна. Одоо Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Харин Төрийн байгуулалтын байнгын хороон дээр нөгөө шинэ дэг, горимоор 8 минут асуулт асуугаад, нэмж 2 минут асуугаад, дараа нь 10 минут үгээ хэлээд 20 минут ярьчихсан учраас энийг давхардуулж ярихгүй. Тэгээд бас энэ зарчмын зүйлүүд ярья гэж ингэж бодож байна.

Ер нь Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолоор гээд Цэцийн шийдвэрээр явж байгаа юм. Тэгээд би ер нь ингээд харахад улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэдэг нэг цорын ганц субъект бий болчихсон юм биш байгаа гэж ийм эмзэглэл байдаг. Үндсэн хуулийн цэц гээд. 9 хүн байдаг. Маш дураараа. Дураараа өөр өөрсдийнх нь гаргасан зам мөр, түүхээс нь харагдаж байдаг.

Ардчилсан намын ялсан буюу олуулаа болсон хамтарсан засагт орсон он жилүүдэд давхар дээл огт болохгүй гэсэн шийдвэрүүдийг байнга гаргаж байдаг. Ардын намын ялж байсан үед нь давхар дээл болно гэсэн шийдвэрүүдийг байнга гаргаж байдаг. Тэгээд одоо тэнд эрх зүйн чадамжгүй даргатай ийм л нэг субъект үүсчхээд байгаа юм. Аль ноднин бил үү, бил үү төрийн албаны дээд хязгаарт хүрээд ажиллах боломжгүй болчихсон ийм хүн. Тэгээд шүүр ажиллагаанд яагаад ч ордоггүй юм? Ийм нэг зүйл байгаа.

Тэгээд би бол ер нь өнгөрсөн он жилүүдэд бол 3 жилийн хугацаанд бол байр сууриа байнга илэрхийлж байсан. 1 нам олонх байх үед ойр ойрхон Үндсэн хуулийн өөрчлөлт орох уу, үгүй юү гэж. Гэхдээ энэ асуудал бол хувийн асуудал биш. Маш олон талаас нь ярьж, маш олон зүйлийг хэлж ярьж тохирох ийм үзэлтэй гэж.

Ардчилсан намын Үндэсний бодлогын хороо ер нь өнгөрсөн 3 жил тогтвортой хуралдаж чадаагүй. Нөхцөл байдлыг тэртээ тэргүй улс орон даяар бүх нам үзэж харж байсан, мэдэж байсан болохлоор. Сая намын даргатай, тамгатай, тэмдэгтэй, гэрчилгээтэй бүх зүйл нь цогцоороо бий болоод анхны өргөн дэлгэр хурлаа хийж ярилцсан. Олон цагаар шөнө дөл болтол бас хуралдсан. Тэгээд ийм болохлоор өнгөрсөн хугацааны улс төрийн нөхцөл байдал бас нэг дүгнэлт хийж, энэ хэлэлцээрт орж ярилцах нь зөв юм гэж шийд гаргасан. Тэгэхлээр би тэр агуулгаар санал бодлоо солилцъя гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхлээр 90 он, 92 оны энэ шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш шинэ улс төрийн нөхцөл байдал, ардчилсан, чөлөөт эдийн засаг, хувийн өмч, хүний эрх гээд энэ шинэ нийгэм рүү алхсан. Энэнээс хойш 8 удаагийн сонгууль болсон. Энэ хооронд үе уламжилж явж байсан уу гэхээс өөр улс төрчийн үе солигдож байгаагүй. Тэгэхлээр одоо энэ үед бол нэг үе солигдож байгаа тийм үе аль аль нам дээр гарч байх шиг байгаа юм.

Тэгэхлээр улс төрийн ч бай, гэр бүлийн ч бай нийгмийн харилцаа бол итгэлцэл дээр тогтдог. Итгэлцэл дээр тогтдог. Хүн ёсны харилцаан дээр тогтдог. Ноён нуруун дээр тогтдог. Тэгээд би энэ талаас нь Байнгын хорооны хурал дээр маш олон зүйлийг хэлж, Нямбаатар сайдын хариултуудад онцгой анхааруулж протоколд бас тэмдэглүүлсэн байж байгаа юм.

Бид нар маш зөв шийдвэр гаргахын тулд олон талаас нь ярилцах ёстой. Гэрэлтэй, сүүдэртэй талаас нь аль аль талаас нь ярилцах ёстой гэж байгаа юм. Тэгэхлээр би юунд жоохон юу хандаж байна вэ гэхлээр манай энд асуудлыг ярьж байгаа хэлэлцүүлгүүд, судлаачид, эрдэмтэд арай л нэг талыг бариад яриад байх юм биш байгаа юм. Тэгээд энэ нь яах вэ шийдвэр гаргахад нөлөөлж байгаа ч гэсэн бидний цаашид

авч явах үр дүнд бас сайнаар нөлөөлөхгүй ийм үйлдэл болчихгүй дээ гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхдээ бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэж асуудлыг гаргаж ирж тавьж, өмнөх хойдохоо ярьж, шинэ зүйл рүү тэмүүлж ингэж байгаа нь бол сайн талтай. Тийм ч агуулгаараа энэ Төрийн байгуулалтын байнгын хороо энэ анхны хэлэлцүүлэг дээрээ бид нар идэвхийлэн оролцож, бүх хүмүүсийн хэлж байгаа, ярьж байгааг сонсож, санал бодлоо ингэж хэлж явж байгаа юм.

Тэгэхлээр пропорциональ тогтолцоо, пропорциональ тогтолцоо Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны хурал дээр гол энэ Үндсэн хуульд орох 5 багц саналыг өгсөн. 5 багц саналыг өгсөн. Үүн дотроо бас бол нэг нь л орж ирж байна. Пропорционалийн элемент.

Дээр нь би ингээд энэ энэ зузаан номыг ингээд эргүүлээд өглөөнөөс хойш хараад байхад бас жишээлэх юм бол Хүний эрхийн комисс саяхан тайлангаа хэлэлцүүлэхэд бидний гар, хөл дутаад байна, хумс хуруу дутаад байна гэсэн. Тэгэхэд Үндсэн хуульд өөрчлөлт өгөх санал байхгүй гэж байна шүү дээ. Гэх мэтчилний ингээд манай төрийн байгууллагууд асуудалд бол хариуцлагагүй хандаж байгаа асуудлууд энэ тэр бол байгаа юм. Энэ ч одоо хойшоо өнгөрч. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл бусад чиглэлээр хоёрхон асуудал дээр ярья гэж байгаа юм байна.

Тэгэхлээр энэ пропорциональ тогтолцоог бол би 60, 40 байх нь зохимжтой л гэж үзэж байгаа. 50, 50 биш 60 оноо мажоритар байх ёстой. Яагаад вэ гэхлээр Монгол Улс бол асар том нутаг дэвсгэртэй, цөөн хүн амтай. Би Монгол Улсын тусгаар тогтнолыг бол энэ танхимд байдаг төрийн 3 өндөрлөг Улаанбаатарт байдаг зүйл гэж огт боддоггүй. Монгол Улсын тусгаар тогтнол бол тэр хилийн дээснээс нааш байгаа хүмүүсийн амь амьдрал, мэдээлэл,

мөрөөдөл, амьдралын чанар бүх зүйлээс болдог гэж ингэж хардаг. Тэр ч агуулгаараа би Улаанбаатарын түгжрэл, утаа, нерв, энэ авлигал, энэ олон муухай зүйл яригдаад байгаа зүйлийг бол би Улаанбаатартай зөвхөн өөртэй нь ноцолдоод биш энэ цагийг гаргаад өгөөрэй, биш орон нутагт амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар, сумд байгаа хүний амьдралын чанар, аймагт байгаа хүмүүсийн амьдралын чанар, Улаанбаатарт байгаа хүмүүсийн амьдралын чанар ижил болох түвшинд л бид нарын үйл ажиллагаа явах ёстой гэсэн энэ агуулгаар л асуудалд хандаж байгаа юм.

Тийм болохлоор энэ хэлэлцүүлгийн явцад бол бас идэвхийлэн оролцъё. Мэдээж ингээд цаашид ард иргэдийн саналыг тусгая. Тэгэхдээ тусгая гэхлээр хоёрхон л асуудлууд байдаг. 152 гэдгийг бол манай хүмүүс тайлбарлаж чадахгүй байгаа юм. Ерөөсөө 76 дээр 76, 152 л гэж байгаа юу гэхээс л 152-ыгоо бол тайлбарлаж чадахгүй байгаа. Тэгэхлээр энэ дугаарыг бол шинжлэх ухааны үндэслэлтэй олон талаасаа ярьж байх ёстой. Би Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хэлсэн. Ямар машины дугаар биш энэ чинь. Азын дугаар биш. Ийм байдлаас хандаж болохгүй юм гэж ингэж үзэж байгаа юм.

Тэгээд энэ Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд идэвхийлэн оролцож, бүгдээрээ ярьж, бүлээн усаар угааж, шинэ үе солигдсон энэ хүмүүс дараагийн 30, 40 жилийнхээ стратегийг төлөвлөх энэ зүйл ямар вэ гэсэн ийм байдлаар хандаж байгаа юм. Асуулт байхгүй гэж ойлго.

Л.Мөнхбаатар: Жамбын Батсуурь гишүүн хуулийн төслийн талаар байр сууриа илэрхийлж үг хэллээ.

Одоо Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд, Даваажанцангийн Сарангэрэл, Ганибалын Амартүвшин нарын урилгаар Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөл

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд, та бүгдийн ажил амьдралд хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Хэлэлцүүлэгтээ оръё. Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Үндсэн хуулийн асуудалд бол туйлын хянамгай хандах ёстой гэдэг энэ байр суурь бол адилхан. Бид нар бас өмнө нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэж байхад ч ярьж байсан л асуудал. Тэгээд бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг ярилцаж байхад зарим нэг зүйлүүд бол батлагдаж чадаагүй ийм асуудлууд бий л дээ. Тэгээд өнөөдөр бол энэ тогтолцоотой холбоотой, ялангуяа энэ парламентын гишүүдийн тоотой холбоотой ийм асуудлууд яригдаж байна. Тэгээд цаг хугацааны хувьд нэгдүгээрт ямар байгаа юм бол гэдэг нэг ийм асуудал байгаа юм.

Хоёрдугаарт би Их Хурлын гишүүний хувьд Их Хуралд сууж ажиллахдаа баримталж байсан байр суурь, тавьж байсан шаардлага, хийж байсан тэмцэл, энэ бүх юмтайгаа уялдуулаад үзэх юм бол энэ төрийн эрх барих дээд байгууллагад ард иргэдийнхээ төлөөлөх эрх мандатыг авч, төрдөө тангараг өргөсөн энэ Их Хурлын гишүүд бол ихээхэн учиртай аливаа ажил, асуудалд хувийн эрх ашиг гэдэг юмыг хойш нь тавьж, төр ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч зүтгэх ёстой гэсэн ийм байр суурийг илэрхийлж ингэж ирсэн хүн.

Тухайлах юм бол энэ төсөл, тендер, төр, ард түмний нэр барьж авсан зээл, бонд, концесс, лиценз цаашлах юм бол өөрсдийнхөө хамаарал бүхий этгээдүүдийг төрийн өндөр албан тушаалуудад тавьдаг, өөрсдийнхөө аж ахуй, бизнесийг өргөжүүлдэг ийм хууль бус, ёс бус үйл ажиллагаанд оролцож болохгүй гэдэг энэ шаардлага шахалтыг тавьж ирсэн.

Гэхдээ энийг ер нь үе үеийн парламент бол хүлээж авдаггүй байсан гэж хэлэхэд болно. Тэгээд миний тухайд бол зарим үед ер нь цөхрөх ийм цаг үе надад бас тохиолдож байсан. Гэтэл Монголчууд ярьдаг шүү дээ ер нь Монголын заяа их гэж. Тэгээд би бол бодож байгаа энэ Монголын заяа түшиж байна гэж. Энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд ялангуяа энэ Засгийн газрын Ерөнхий сайд энэ Оюун-Эрдэнийн авч хэрэгжүүлж байгаа энэ арга хэмжээнүүдийн хүрээнд бол яг би дээр хэлсэн энэ асуудлуудаар тэмцэл хийж явсан хүний хувьд бол миний юу гэдэг юм үнэхээр яг өөрөө энийг үздэг юм байна гэж ингэж талархаж байгаа юм.

Одоо тухайлах юм бол Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн дүрэм, Төрийн албаны ёс зүйн тухай хууль, цаашилах юм бол энэ Төрийн хэмнэлтийн хууль, энэ авлигал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, энэ нийтийн албанд нийтийн эрх ашгийг хангах хамгаалахтай холбоотой энэ хуулиудыг бол оруулж ирж байна. Эхнээсээ батлагдсан. Хэрэгжээд явж байна. Одоо Улс төрийн намын тухай хууль яригдах нь, Улс төрийн намын санхүүжилтийн хууль ярих нь. Ингээд энэ хууль, эрх зүйн энэ зохицуулалтын хүрээнд бол сүүлийн 30-аад жил ялангуяа сүүлийн 20-иод жилийн хугацаанд яригдсан энэ ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, авлигал хээл хахуультай холбоотой, хулгай худалтай холбоотой ийм асуудлууд ер нь нэлээн цэгц журамдаа орох нь.

Үүн дээрээ үндэслээд улс орныхоо аюулгүй байдалтай холбоотой, нийгмийн олон талын төлөөллүүдийг тэр төлөөллийн зарчмаар энэ парламентад оруулахтай холбоотой ийм асуудлуудыг бас шийдэх ийм цаг хугацаа нь болж байж мэдэх юм гэсэн ийм байр суурь байгаа юм.

Гэхдээ бол иргэд сонгогчдоосоо бид хэлэлцүүлэг хийнэ, санал онолыг нь авна. Нөгөө нэг юм нь бол хэрвээ энэ

парламентын гишүүдийн энэ төлөөллийг хангах энэ зарчмыг нь авч үзэж, анхаарч өөрчлөлт орох юм бол энэ Их Хурлын, Их Хурал гэдэг Их Хурлын 76 гишүүн гэдэг бол тийм эрх мэдэлтэй дарга ангийн ийм төлөөлөл шиг ойлголттой. Энэ төлөөлөл мэт ойлголтыг өөрснөө бий болгодог ийм байдлаасаа өөрчлөгдөх байх. Хандлага энэ соёлыг нь өөрчлөх ёстой гэж би бол ингэж бодоод байгаа юм.

Тухайлах юм бол хамгийн түрүүнд Их Хурлын гишүүний энэ бүрэн эрх, халдашгүй дархан байдлын тухай асуудлыг бол бүрмөсөн авах хэрэгтэй. Яг энэ Их Хурлын чуулган танхимд байж байх үедээ тэр халдашгүй эрх хангагдаж байдаг. Энэ гадагшаа гарах юм бол зүгээр л ард иргэн, иргэдтэйгээ л ижил хэмжээнд байдаг. Ийм байх юм бол энэ бүрэн эрх хамгаалалтын ар талд нуугдаж хулгай худал, өмнөх аж ахуй бизнестэй холбоотой элдэв юмаа хааж хаацайлах гэсэн ямар ч оролдлого энд бол орж ирэхгүй шүү дээ.

Миний түрүүний хэлдэг энэ олон хуулийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд бол энэ дараагийн сонгуулиас эхлээд хүмүүс энэ аж ахуй бизнесээ эрхлэх юм уу, эсвэл энэ улс төрийн Улсын Их Хуралд нэр дэвшээд бүх юмаа эрхээ хязгаарлуулаад ингээд сууж байх уу гэдэг хоёрхон сонголт дээр л ирнэ. Энэ нь ч зөв зүйтэй. Бусад улс орны парламентуудад ийм л жишигтэй байдаг юм байна лээ. Германы Бундестаг байна. Бусад парламентад бид нар очиж ажиллаж байсан. Ажилласан энэ өдрийн тэмдэглэл, нийтлэл бичээд олон түмэнд хүргэсэн. Ном товхимол болгоод хүргэсэн. Өнөөдрийнх шиг Монголын парламент шиг ихэнх нь бизнесийн төлөөлөл орж ирээд ингээд үүрэлцсэн ийм парламент дэлхийд чухам хэд байдаг юм бол? Ямар ч байсан Европын парламент төлөвшсөн ийм улс орнуудад бол байдаггүй л жишиг юм байна лээ. Ингээд энэ парламентын гишүүдийн хэрвээ тоо нэмэх дээр тулах юм бол энэ зардал, төсвийг нь бол одоо байгаа хэмжээнд нь багтаагаад, ямар нэгэн

төсвөөс хөрөнгө, санхүү гаргахгүйгээр ингээд зохицуулах. Энэ байгаа өрөө тасалгаанд нь 2, 2-оор нь суулгадаг юм уу. Жижигхэн шиг өрөөнд нь бол 2-оор нь, томоохон шиг өрөөнд нь бол 4, 5-аар нь суулгаад, дундаа ажлын албатай нэлээн бололцоотой цомхон болгох чиглэлээр нь шийдэж өгөх нь зүйтэй байх. Ийм санал.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүн асуулт байхгүй. Үг хэллээ. Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Улсын Их Хурлаар энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирж байна. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн гэдгийг бол миний хувьд бол төр ард түмний хоорондох гүүр, ард түмнийхээ бид нарын гүүр болог гэж томилж өгсөн ард түмний төлөөлөгч гэж ингэж ойлгодог.

Тэгэхээр бид хэд бас энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэг дээр ард түмний бодол саналыг бас 2 удаа хэлэлцүүлэх ийм дэгтэй юм байна. Тэгэхээр энэ хүрээнд нь бас очиж хэлэлцүүлээд, дахиад энэ дээр бас өөрчлөлт орох байх гэж ингэж бодож байгаа. Тэгэхээр өнөөдрийн хэлэлцүүлэг бол хэлэлцэх эсэх учраас ямар ч байсан энийг нөхцөл байдал, орчин нөхцөл маш олон төрлийн шаардлага гарсан учраас энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхийг бол дэмжиж байгаа.

Тэгээд аливаа юм чинь ер нь сайжирч явах ёстой. Нэг байран дээрээ зогсоод байж болохгүй, бүүр ухраад байж болохгүй. 92 оны анхдугаар ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас хойш 31 дэх жил рүүгээ орчихлоо. Сүүлийн үед ажиглаад байхад энэ хуулийн зохицуулалтын хүрээнд Монгол Улсын иргэдийн амьдрал өсөх дэвших биш, зогсох биш бүүр ухраад байгаа юм. Нэг бороотой өдөр халтиргаатай зам дээр халзан дугуйтай машин өгсөж явж байгаад тоормос гишгээд зогсохоор тэр байрандаа зогсохгүй ухраад яваад өгдөг.

Яг л ийм нөхцөл байдал үүссэн учраас энэ бид нар томоохон энэ тогтолцооны шинж чанартай өөрчлөлт хийх цаг нь болсон гэж ингэж үзэж байгаа юм.

Тэгээд Монгол Улсын Их Хурлын гишүүд Монголын төрийн зүтгэлтнүүд энэ яг энэ амьдрал дээр байгаа асуудлыг соргогоор харж өөрчлөхгүй бол иргэдийн маань амьдрал бидний нүдэн дээр ингээд дордоод байгаа юм. Хажуугаар нь мэдээгүй, мэдсэн ч мэдээгүй царайлаад чихээ дараад ингээд өнгөрөх бид нар бол учиргүй. Тэгэхээр энийг бол бид нар хэлэлцэх нь зүйтэй гэж би ингэж дэмжиж байгаа юм.

Миний хувьд бол энэ сая Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах ажлын хэсэг зохион байгуулагдаад, эндээс 2 удаагийн асуулгууд яваад зөвлөмж гаргаад өгчихсөн. Энэ зөвлөмжийг бас эхний ээлжид ямар ч байсан аваад Төв аймгийнхаа бүх сумуудаар ороод хэлэлцүүлээд ирсэн. Танилцуулсан тэд нарыг. Саналыг нь авсан.

Тэгэхдээ энэ дээр бол иргэдийн маань зүгээс бол яг тайлбарлаад, таниулаад яг нөхцөл байдал ийм байна гэхэд зөв тийшээ явах гэж байгаа юман дээр бол иргэд дэмжих хандлага байна. Яагаад гэхлээр Монголчууд чинь ухаалаг, дээрээс нь ийм нүүдэлчин ард түмэн. Шинэ соргог зүйл дээр бас тийм эсрэг байр сууриас ханддаггүй ийм хүмүүс учраас зөв тайлбарлаад дээрээс нь хамгийн гол нь хүмүүс зөв байвал, зөв шийд гаргаад энэ хэлсэн, ярьснаа дагах юм бол дэмжинэ гэсэн ийм байр суурьтай байгаа юм. Би бол Монголчууд ярьдаг үгэндээ суудаг хүн гэж, хэлсэндээ хүрдэг хүн гэдэг шиг энэ Монгол Улсын энэ эрх барьж байгаа хүмүүс, ялангуяа энэ намууд удирдаж байгаа, том намуудыг удирдаж байгаа дарга нар, төрийн өндөр дээд албан тушаалтнууд үгэндээ сууж чадах юм бол ард иргэд чинь бас дэмжихэд бэлэн байна гэж ингэж харж ирсэн. Тэгэхээр бүх сумуудаар явсны хувьд ийм зүйл хэлж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр ард иргэдийн дунд тэр холимог тогтолцоог яагаад дэмждэггүй юм. Тодорхой шүү дээ. Тэн дээр чинь тэд нарын үг байгаа шүү дээ. Хаалгаар гаргаад хаяхаар тооноор ороод ирдэг юм шүү дээ гэж. Тэгэхээр 2 намын даргын үгэнд гараад байгаа тэр авлигач, хулгайч, муу нэртэй хүмүүсээ тооноороо оруулахгүй л байвал иргэд маань дэмжинэ шүү дээ. Ямар нэгэн байдлаар тооноороо оруулж ирээд нэрийг нь тавих юм бол тэр дүнг чинь сонгуулиар ард иргэд нь тавиад өгнө. Энэ чинь яаж байгаа юм гээд дүнг нь тавиад өгнө. Тэгэхээр энэ Монгол Улсын Ерөнхий сайдаас энэ бодлого байр суурь дээрээ ямар байр суурьтай байгаа вэ? Энэ муу нэртэй, тодорхой авлига, албан тушаалын хулгайн хэрэгт орооцолдсон ийм хүмүүс дээр ер нь ямар байр суурь баримтлах вэ? Тэгээд би бас чуулганы хуралдаан дээр өмнө нь хэлж байсан Ардчилсан намын хувьд бол тооноо торлоно, гагнана гэж. Уг нь бол утга нь муу хүмүүсийг оруулахгүй гэсэн санаа. Тэгэхээр энэ дээр таны байр суурийг сонсьё.

Тэгээд өчигдөр тэр нийтийн албанд ашиг сонирхлын тухай гээд бас л чухал хууль орж ирсэн. Энийг би дэмжсэн. Энэ дээр тэр системийн авлигал гээд юмыг бид нар ярих цаг нь болчихсон. Монгол Улс нэг тийм хаврын хачиг, хувалздаа баригдсан борлон шиг ийм атийсан, умайсан хөдөлж олигтой ч явж чадахгүй, таргалж тэвээрдэггүй, өөдөлж дэвшдэггүй ийм байдалтай л яг үнэндээ байна. Үүнийг яаж өөрчлөх вэ гэхээр бодитой дориун тогтолцооны өөрчлөлт хийж байж л бид нар эндээс гарна. Тэгэхээр энэ системийн авлигыг задлахын тулд бид нар тодорхой том алхам хийх ёстой. Монгол Улс шиг 1 сая 500 мянган километр квадрат нутагтай ийм их газрын баялагтай, ийм цөөхөн хүн амтай дээрээс нь тэнгэрээс бид нарт өгсөн энэ МАА-тай ийм улс яагаад ийм ядуу амьдраад, улам ядуураад байгаа юм. Удирдаж л чадахгүй байна шүү дээ.

Тогтолцоо чинь л болохгүй байна шүү дээ.

Тэгэхээр бид нар бол энэ Арабын улсуудаас доор амьдарна гэж яаж байх юм бэ. Бид нар төрт ёсны ийм олон мянган жилийн уламжлалтай ийм ард түмэн, төрөө дээдэлдэг ийм ард түмэн. Ингээд яагаад ингэж ядуу амьдраад байгаа юм. Өнөөдөр парламентаар хэлэлцэгдэж байгаа хуулиуд дотор нэг арга ядсан өнөө, маргаашаа аргацаасан нэг жижигхэн жижигхэн өөрчлөлтүүд яриад байгаа. Одоо бид нар үүнээсээ болимоор байгаа юм.

Бид нар энэ ДНБ улсын орлогоо бүгдийг нь томруулаад энэ хэдхэн иргэдээ нэг гар газар, хөл хөсөр амьдруулмаар байна шүү дээ. Үүнийг хийхэд өнөөдрийн энэ Үндсэн хуулийн өөрчлөлт нэмэр болно оо гэж ингэж би ийм байр суурь дээр хандаж байгаа юм. Тэгээд энэ тэр хүмүүс дотор яагаад энэ сегментийн төлөөллүүдийг сайн хуульчид яагаад орж ирж чадахгүй байгаа юм? Малчид, тариаланч, ногоочин, ажилчин анги, дээрээс нь Монгол Улсын хүн амын 3%-ийг эзэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс яагаад 2 нам урдуур нэг, нэг хүн тавиад оруулж ирж болохгүй байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээт иргэдийн зовлон амьдралыг бид нарын хэн нь ч ойлгохгүй шүү дээ. Тэр хүмүүс л өөрсдөө ойлгоно. Тэр хүмүүсээс бол 1, 1 хүмүүсийг нь бүр оруулж ирээд тэндээс юмыг нь яагаад бодлогыг нь гаргаад явж байгаа. Бид нарын энэ хүмүүс рүү баримталж байгаа төрийн бодлого ингээд явж байгаа юм шиг боловч амьдралд нийцэхгүй байгаа нь тэр хүмүүсийн үг хүрэхгүй байгаа юм аа. Тэгэхээр би ингэж бодож байгаа. Тэгэхээр сегмент, сегментийн төлөөллүүдийг бол бас бид нар оруулах ёстой.

Ер нь бол дээрээсээ бид нар энэ шинэчлэл юмнуудаа авах хэрэгтэй. Үгүй ээ, нөгөө онигоонд хүртэл байгаа шүү дээ, дээгүүрээ л хуваагаад идчихдэг шүү

дээ гэдэг шиг. Одоо бид нар энэ дээгүүрээ хүмүүс бид нар өөрсдөөсөө энэ өөрчлөлтөө эхэлж хиймээр байна.

Тэгэхээр хэлэлцээд явах нь зөв өө гэж ингэж бодож байна. Асуултад хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Туваан гишүүнд баярлаж байна. Ийм зөв зүйтэй, бас ийм байр суурьтай бас ийм асуултыг хөндөж байгаад. Тэгэхээр энэ бол үнэн. Энэ бол улс төрийн намуудад л өөрсдөд нь л байгаа асуудал байхгүй юу. Түүнээс биш энэ иргэдэд байгаа асуудал ч юм биш. Тэгэхээрээ ер нь Монгол Улс яагаад ингээд ийм хүнд байдалд орчихсон бэ гэхээр манайх хэдхэн мөнгөтэй хүнтэй, сонгууль болохоор бүгдээрээ тэр мөнгөтэй хүмүүс дээрээ давхиж очоод, хандив аваад, хандивынхаа төлөөс нь шүүх, хууль хяналтын байгууллагуудынхаа удирдлагуудыг өгөөд, нийслэлийн газраа, өмч хувьчлалаа, дээрээс нь ашигт малтмалын лицензүүдээ, бүгдийг нь өгөөд ингээд нэг ийм хэдхэн хүний гарт орчихсон. Энэ нь аль аль намын системд нөлөөлдөг нь нууц биш. Ийм байдалтай 30-аад жил явж ирсэн. Үүнийг л бид нар хамтдаа задалж байж л яг таны хэлдгээр эдийн засаг илүү хүртээмжтэй байх энэ ойлголт бүрдэнэ.

Сая энэ нүүрстэй холбоотой асуудал, хил болон аман дээр байгаа үнийн зөрүү, эдийн засаг, ханишийн нөлөөнд мөн ДНБ-ий өсөлтөд зүгээр энэ ганцхан шийдвэр яаж нөлөөлж байгааг бид нар бүгдээрээ л харж байна шүү дээ. Одоо ингээд улсын төсөв бараг 1 их наядаар давж биелж байна шүү дээ. Энэ 1 их наядын далд эдийн засаг байсан л гэсэн үг. Тэгэхээрээ хэдүүлээ ийм асуудлуудаа зоригтой шийдэл гаргаад л ингээд л бид нар сөрөг хүчинтэйгээ хамтраад л бусад улс төрийн намуудтайгаа хамтраад л явбал тэр

хүмүүс яаж ч чадахгүй. Бид нар эрх мэдлээ энэ ордон дотор л байлгах хэрэгтэй. Ордны гадна талд байгаа өндөр байшингуудад биш.

Тэгэхээр яах вэ, би нэг зүйлд үнэхээр баяртай байгаа. Тэр нь ингээд ил тод болж байна, цахимжиж байна. Бүх асуудлууд ингээд ил тод яригдаж байна. Мэдээж дунд нь жижиг сажиг эрсдэл гарахыг үгүйсгэх аргагүй. Гэхдээ иргэдийн мэдэх эрх хангагдаж байна. Иргэд мэдэхийн хэрээр, иргэд үнэнийг ойлгохын хэрээр, өнгөрсөн 30 жилээ өөр өөрсдийнхөөрөө маш бодитой дүгнэж байна. Тийм учраас энэ дээр бид нар МАН, АН гэж мэтгэлцэхээс илүүтэйгээр энэ 2 намыг системийн хувьд бусниулсан тэр албан бус бүлэглэлийг л олж харах ёстой. Тэгээд тэр бүлэглэлийн гишүүдээсээ бид ч салах хэрэгтэй, МАН, АН ч салах ёстой. ХҮН нам энэ бүлэглэлийн гар хөлийг оруулахгүй байх ёстой. Ингээд л хаачхаж чадвал, тэгээд үнэхээр иргэдийн төлөөллийг бид нар энэ хувь тэнцүүлэх тогтолцоогоор оруулж ирж чадвал энэ бол том реформ болно. Ингэж чадахгүй, тэр бүлэглэлийн гарт нөгөө намын жагсаалтыг худалдаж, намын санхүүжилтээ босгох байдал руу шилжвэл энэ бол том эрсдэл болно. Олон, олон боломжуудыг хаана гэсэн үг. Тийм учраас хэдүүлээ улс төрийн намын хуулиар сонгуулийн зардлыг хамгийн бага түвшинд аваачих хэрэгтэй. Хамгийн бага түвшинд аваачих хэрэгтэй. Бүх намын санхүүжилтүүд ил тод байх ёстой, хэмжээг нь нэмэх ёстой. Одоо бид нар бас бие биеэ хуураад 5 сая төгрөг, 10 сая төгрөг гээд худлаа бүртгээд тэгэнгүүтээ ард нь ийм далд эдийн засаг явуулаад хэрэггүй. Үүнийг 200 сая, 100 сая болгож болно. Гол нь ил тод байх ёстой. Ил тод биш байвал энэ Эрүүгийн хуультай байх ёстой. Эрүүгийн хуультай байх ёстой, ингэж байж энэ асуудлууд бол цэгцэрнэ ээ. Тэгэхээр хэдүүлээ энэ дээр бас улс төрийн манлайлал үзүүлбэ.

МАН энэ улс төрийн манлайлалд бэлэн байна. Би сая бас Доржханд даргын асуултад хэлсэн. Шаардлагатай

бол санамж бичигт гарын үсэг зураад явъя. Энэ эрх ашгийг хэдүүлээ зааглаж ялгая. Тэгээд яг зөв тогтолцоо руу явах тал дээр ингээд анхаараад явъя.

Системийн авлигатай холбоотой энэ асуудлуудыг задлахад энэ тоо нэмэгдэх бол чанарын өөрчлөлт гарна. 76 хүн дээр ЗГ-ыг 19 хүнээр өргөн бариад огцуулах гээд л урд нь олон асуудлууд гардаг байсан. Ердийн олонхоор кноптчихдог байсан. Арваадхан хүн нэг дор уулзахад л засаглал ганхах хэмжээний эрсдэлтэй болдог байсан. 152 хүнийг лобби хийх тийм ч амар биш, мэдээлэл задарна, гадна дотноос нөлөөлөх тийм ч амар зүйл бас биш болно. Тэгэхээрээ энэ өөрөө парламентын нөлөөлөл болон албан бус лоббины дархлааг багасгаж байгаа юм. Илүү олуулаа хэлэлцэх тусам ямар нэгэн байдлаар нууц зүйл байхгүй болно. Олуулаа байх тусам хэлэлцээ, мэтгэлцээн илүү ил тод байх боломжтой болно. Энэ агуулгаараа бас энэ систем задарна аа.

Нөгөө талаараа сонгууль дээр гарах санхүүжилт ил тод, бага болох тусам иргэдийн төлөөлөх чадвар өөрөө сайжирна. Тэгэхээрээ бид нар төрийн албан хаагч дээрээ ч гэсэн нэмээд л бид нарын хувьд бол цалингаа л нэмэх л асуудал. 500 мянган төгрөгийн, 600 мянган төгрөгийн цалинтай төрийн албан хаагчдаас бид нар төрийн бүтээмж, авлигаас ангид бай гэдгийг шаардах боломжгүй. Урьд нь бол бид нар нэг тийм төрийн албанд яаж ийж байгаад хүн ажиллуулъя, гэхдээ яах вэ дээ, тэгээд ингээд орон тоон дээрээ байж байг гэдэг ийм агуулгаар л явчихсан юм шиг байгаа юм. Тэр нь тэр шилжилтийн үед бас хэрэг болж байсан байхыг үгүйсгэх аргагүй л дээ. Яагаад гэхээр өөр газар угаасаа ажлын байр байгаагүй юм чинь. Одоо асуудал өөр болж байна. Одоо бид нэлээн тийм өндөр түвшний хувийн хэвшилтэй өрсөлдөхүйц хэмжээний цалинтай, цөөн төрийн албан хаагчидтай, маш өндөр чанартай төрийн үйлчилгээтэй, авлига, хүнд суртал байхгүйгээр амьдралаа авч явдаг

ийм том тогтолцооны реформыг бид нар дагуулаад бас хийх ёстой. Тэгээд ер нь бид нар нэг ихэнх зүйлүүдээ нэг ийм гал аргацаах байдлаар тэгээд аргалаад, тэгээд худлаа байгааг нь мэдсээр байж үнэнээ ярихгүй л их удчихаж. 500 мянган төгрөгийн цалингаар амьдрах боломжгүйг нь мэдсээр байж л байлгаад л байдаг. Тэгээд яаж амьдралаа аргалж авч яв гэж байгаа юм. Ард нь авлига л ав гэсэн л үг шүү дээ, энэ чинь. Энэ мэтчилэн ийм зүйлүүдээ л хэдүүлээ ярилцъя.

Өнөөдөр жишээлбэл энэ тоо, тогтолцоотой холбоотой асуудал мэдээж нийгэмд таалагдах, таалагдахгүй 2 янз байгаа. Гэхдээ өнөөдөр ЗГ, Ерөнхий сайдын шийдвэр үүнийг ил тод би ингэж ярихыг л хүссэн юм. Мэдээж эцсийн шийдвэр гаргах нь парламентын, манай ард иргэдийн асуудал. Бид нар 2 дахь хэлэлцүүлэг дээр иргэдтэй уулзаж ирээд энэ асуудлыг больчихож болно. Эсвэл одоо батлаад 28 оноос хэрэгжүүлж бас болно. 40% биш 30% байж болно. 50-д байж болно. Гишүүдийн тоогоо багасгаж болно. Бүр хөндөхгүй орхиж болно.

Нөгөө талаараа бас нэг чухал зүйл. Үндсэн хууль гэдэг бол өөрөө эрхэм дээдийн ийм дархлаатай баримт бичиг. Энэ агуулгаараа бид нар олон олон заалт дээр ярилцаад байх биш бид нар нэг заалт дээр удаан хугацаанд ярилцах ёстой юм шиг байгаа юм, ер нь бол. Сонгодог парламентынхаа тогтолцоо руу. Тэгэхээр өнөөдрийн энэ тоо, тогтолцоотой холбоотой асуудал Цэц дээр ч бай, парламент дээр ч бай, сүүлийн бараг хориод жил маргаан болсон учраас хэдүүлээ ярилцаад нэг эцэслээд цэг тавих нь бол зүйтэй. Тэгэхгүй бол бид нар ирээдүйн улс төрчдөд зовлон үлдээнэ ээ л гэсэн үг. Энэ үед бид нар зовлонгоо үүрэхгүй бол ирээдүйн улс төрчдөд зовлон үлдээнэ гэсэн үг. Тийм амиа хичээсэн байхыг хэдүүлээ бас хүсээд яах вэ. Асуудлыг нь гал аваад ч бай, шийдэх ёстой. Эс үйлдэл хийхгүй байх ёстой. Тэгээд дараа

дараагийн улс төрчид бидэнд тухайн үедээ баярлах, тухайн үедээ жишээлбэл зөв байжээ гэдэг тэр дүгнэлт гарах л ёстой. Төрийн шийдвэр гэдэг бол угаасаа л өөрөө тийм.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Тэгэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлэлцээд эхлэхээр бусад хуулиуд хэлэлцэгдэхгүй ээ. Тэгэхээр энэ хэлэлцэх эсэхээ шийдээд орхичихсон байгаа Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль гээд энэ хуулиуд байгаа. Тэгэхээр өнөөдөр бас яг энэ ЗГ төлөөлж байгаа Монгол Улсын Ерөнхий сайдын хувиар бас энэ зарчмуудаа ярьж байна. Энэ зарчмуудаа бас цааш нь яг энэ хэвээрээ дараа дараагийн хуулиуд дээрээ бас бариад явна биз дээ гэсэн асуултыг асууя.

Тэгээд ер нь бол энэ манай дээр энэ 3 хууль хоорондоо ингээд уялдаатай явна аа. Энэ 3-аас Монголчууд бид нарын дараагийн амьдрах хувь, амьдрал бас их шалтгаална. Тэгэхээр бид нар их тийм сайн нягталж, шалгаж байж энэ асуудалд хандах ёстой. Тэгээд хэт улс төржилт бол бас замаа алдсан. Одоо өөр хүн хийсэн байвал тэр буруу гээд шууд эсрэг нь яваад өгдөг, өөр улсын юм шиг бүүр ингээд яваад өгдөг. Тэгэхээр ийм ийм явдлуудыг бас бид нар зогсоох ёстой.

Тэгэхээр тодорхой асуулт нь бол таны саяын юун дээрээс тэр хаалгаар гаргаад хаясан улсуудыг тооноор оруулахгүй байх гэдэг дээр тодорхой байр суурь хэлнэ үү.

2 дугаарт, тэр листүүд дээр сегментийн төлөөллүүдийг яг хэсэг, хэсэг бүлэг хүмүүсийн тодорхой хэлэх юм бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэр төлөөлөлд оруулах дээр та таны байр суурь?

Дээрээс нь ард түмэн сонголтоо хийнэ. Бид нар очоод асууна. Тэгэхээр энэ

дээр тоо буурах шийдвэрүүд гараад ирвэл та бас ард түмний сонголтыг яаж авч үзэх вэ гэсэн асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

УИХ-ын дэд дарга Лхагвын Мөнхбаатарын урилгаар МУИС-ийн харьяа “Байгаль эх” ахлах сургуулийн 106 ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт багш, сурагчид та бүхэнд сурлага, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна

Л.Оюун-Эрдэнэ: Би маш тодорхой байр суурь илэрхийлсэн. Шаардлагатай бол МАН санамж бичигт гарын үсэг зурахад бэлэн байна АН Хэрвээ бэлэн бол. ХҮН намын даргад би бас үүнийг хэлсэн, 1 дүгээрт.

2 дугаарт, дахиж хэлэхэд ЗГ-аас оруулж ирж байгаа төсөл бол энэ хэлэлцүүлгийн эхлэл. Эцсийн шийдвэрийг гагцхүү УИХ гаргана. Та бүхэн бол ард түмний төлөөлөл. Тийм учраас та бүхэн ямар ч шийдвэр гаргасан миний хувьд хүндэтгэнэ.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Богино биш хугацаанд бас бага биш зөрчилтэй замыг туулсаар Үндсэн хуулийн өөрчлөлт Их хурал дээр орж ирж байна л даа. Тэгэхээр энэ үгний эхэнд бас нэг хэлэхийг хүсэж байгаа зүйл нь бид нар ер нь аливаа зүйлийг асар их тийм гоёчилж хэлдэг. Үүнийг өөрчилчихвөл бүх зүйл үндсээрээ сайхан болчих гэж байна. Цэнгэлийн манлайд хүрчих гэж байна гэдэг. Хэдхэн жилийн өмнө Үндсэн хуулийн өөрчлөлт бас л ийм замаар л хийгдэж байсан. Тэгэхээр анхнаасаа ер нь сайнтай нь муутай нь гаргаж байгаа

үндэслэлүүдийг зөвхөн нэг талыг нь сайн талыг нь гэхээсээ саар талтай нь бас ингээд хамтад нь тал талаасаа ярилцаад явах нь их зүйтэй байх.

Энэ удаагийн нэмэлт, өөрчлөлт үндсэндээ нэг ганц өгүүлбэрээр 2 утга санаа бүхий ганц өгүүлбэрийн заалт л орж ирж байна л даа. Ганцхан өгүүлбэрийн заалт. Энэ дээр удаан хугацаанд яригдсан. Ардын намын зүгээс ч ярьж байсан хүний эрхийн асуудлууд, АН-ын зүгээс бүр олон 10 жил бараг үргэлжилсэн нь маш олон тэр нэг зүйтэй заалтууд саналууд хүргэгдсэн, одоо бүгдээрээ байхгүй. Үүн дээр ярьж байгаа 1 сая хэлэлцүүлгийн явцад ингээд сонсоход ярьж байгаа үндэслэл нь дараа нь илүү өргөн бүрэлдэхүүнтэй парламент үүнийг хийг ээ л гэж байна л даа. Тэгэхээр харин надад эсрэгээрээ нэг үндэслэл байгаад байгаа юм. Энэ парламент чинь одоо 57-оор Үндсэн хуулийн асуудал ийм хүнд байхад энэ 152 гэдэг тоогоор бол 110, 20 хүнээр явах нь байна. Үндсэндээ энэ магадгүй хамгийн багадаа 5, 6 нам парламентад орж ирэх нь байна. Яг зарчмыг нь, иргэдийн эрхийг, эрх ашгийг хамгаалсан, иргэдэд эрх нэмэгдсэн тэр зүйтэй олон зүйл заалтууд чинь энэ удаагийн өөрчлөлтөд орох ёстой байсан юм биш үү? Үндсэндээ үүний дараа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орно оо. Үндсэн хуульд өөрчлөлт орно гэдэг чинь үндсэндээ Үндсэн хуулийн өөрчлөлтийн тэр хаалга цонх өөрчлөгдөх боломжийг бүгдийг нь бид нар хааж хадах гэж байна шүү дээ, одоо үндсэндээ бараг. Үүний дараа Үндсэн хууль өөрчлөгдөнө гэдэг зүйл үнэхээр хэдийгээр гоё үгээрээ, нийгмийн зөвшилцлөөр гэж хэлж байгаа ч гэсэн цаана нь хумигдана.

Тэгэхээр нэгэнт Үндсэн хуулийн өөрчлөлт ярьж байгаа үед үндсэндээ энэ гишүүдийн тоог нэмэх энэ олон зүйлүүдээсээ гадна иргэдэд эрхийг нь шилжсэн тэр зүйлүүдийг хэдүүлээ энд оруулах байсан юм аа. Үүн дээр мэдээж янз бүрийн энэ улс төрийн нөхцөл байдлууд нь яваа биз. Тэгэхдээ яг ингээд

гудамжинд, гудамжинд гэнэ ээ, ер нь тэр дайныг эсэргүүцсэн жагсаал хийсэн залуучуудын эрх нь зөрчигдөж байна л гэж байна. Тэр Монголхүү, Мөнх-Эрдэнээс эхлээд энэ олон залуучууд чинь үндсэндээ шүүхийн алх цохигдоод ингээд явах юм байна. Эд нарт тэр дээд талд нь илүү том боломж ҮХЦ-ийн боломжийг нь бид нар бас гаргаж өгөх л байсан шүү дээ. Гэх мэтийн цаана нь 10-аар, 100-аар, 1000-аар тоологдох олон залуучууд үүний цаана бий. Гол нь иргэд үүний цаана бий.

Үндсэндээ миний санаа бол Үндсэн хуульд нэгэнт өөрчлөлт орж байгаа бол иргэдийн талд хийх ёстой, шүүхийн хараат бус байдлыг хангах ёстой, төрийн чадамжийг дээшлүүлэх ёстой, Үндсэн хуулийн дархлааг дээшлүүлэх энэ олон зүйл заалтуудыг энэ удаад оруулах боломжийг үндсэндээ бид нар ингээд алдаж байна. Үүн дээр би хувь хүнийхээ хувьд жоохон харамсалтай байгаа.

2 дугаарт нь, орж ирж байгаа 2 саналтай холбоотой тоо нэмэх, тогтолцоотой холбоотой 2 дээр нөгөө 2 асуулт болоод саналууд байгаад байгаа юм. АН пропорциональ тогтолцоог үргэлж дэмжсээр ирсэн, үргэлж дэмжсээр ирсэн. Үүн дээр 60, 40 буюу ер нь пропорционалийн мажоритар нь их байг ээ гэдэг саналыг хэлж байгаа юм. Энэ санал өөрөө явсаар явсаар зүгээр АН-ын үүднээс харах юм бол энэ эсрэгээрээ. АН-д пропорциональ нь илүү байвал илүү ашигтай. Тэр статистик тоо дата бүгд л тэгж л харагддаг. Гэтэл өнөөгийн нөхцөл байдал дээр бас судлаачид болоод янз бүрийн хүмүүсийн ингээд байр суурийг 2 үндэс харагдаад байна.

1 дүгээрт нь, Монгол Улсын тусгаар тогтнол гэдэг зүйл чинь өөрөө энэ Монгол Улсын зах хязгаар нутаг, том газар нутагтай, сийрэг хүнтэй энэ нь үүнтэй холбоотой.

2 дугаарт нь, бас пропорциональ хэтэрхий өндөр байснаар ер нь дараа

дараагийн Засгийн газруудын тогтвортой байдалд нөлөөлж, Засгийн газрууд чинь асар их тогтворгүй болох юм биш үү? Олон нам ордог, олон нам орсны хэрээр их том том эвслүүд гардаг. Энэ чинь тэгээд эрх ашгийн том зөрчлүүд үүсдэг, хэврэг болдог. Тэгэхээр ийм үүднээс пропорциональ нь тодорхой хэмжээгээр илүү байг ээ, магадгүй бага хэмжээний зөрөөтэй 60, 40 гэдэг харьцаа. Үүн дээр Ерөнхий сайдыг бас тодорхой байр сууриа үүн дээр бас илэрхийлж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт нь, энэ тооны тухайд 152 гэдэг тоог АН болоод АН-ын төлөөллийн төв байгууллагаас дэмжихгүй гэдгээ бид нарт бас чиглэл болгож өгсөн. Би энэ дээр энэ судлаачдын зүгээс нэг хариулт хэлээч ээ гэж хүсэж байгаа юм. Ер нь энэ судлаачид шинжлэх ухаанд техник, технологи хөгжихийн хэрээр бүтээмж дээшилдэг. Техник технологи хөгжихийн хэрээр дэд бүтэц сайжирч байна. Яг бүхий л зүйлээр 90 онд 2 сая байсан одоо 3.3 сая болчихлоо. Ер нь энэ төлөөллийн тоогоо 152 болгочих нь зүйтэй гэдэг тоо нэг ийм тайлбар давамгайлаад байна л даа. Гэтэл тэр техник, технологийн хөгжил гэдэг зүйл чинь хүн ам 50% нэмэгдэх нь байтугай энэ техник, технологийн хөгжил сүүлийн 30 жилд бараг 5 дахин илүү бүтээмжийг нэмсэн байх. Энэ 5 дахин гэдэг чинь 50%-тай харьцуулахад бараг 500% гэсэн үг, 500% гэсэн үг. Тэгэхээр та нарын үзэж судалсан зүйл дотор чинь энэ техник, технологийн хөгжил, дэд бүтцийн хөгжил, бүтээмжийн хөгжил олон зүйлээр, олон зүйлээр хүний тоог нэмэхгүй байх нь зүйтэй юм гэдэг тийм үндэслэл ерөөсөө харагдахгүй байгаа юм уу? Хүний тоон дээр яг энэ судлаачид нэг тоог хэлээч ээ. Ерөөсөө л нэг хэлж байгаа тоо бол төлөөлөх чадвар. 2 сая нь 3.3 сая болсон учраас 152 большихъё гэдэг үндэслэл чинь энэ ард иргэдэд хүртэл бас нэг үндэслэлтэй сонсогдохгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүн дээр бас ер нь философид ч гэсэн тооноос чанарт шилжих хууль гэж байдаг. Тоо байгаад энэ тоог чанаржуулж цөөхөн болгож, илүү чанартай болдог. Энэ нь техник технологи, бүтээмж, шинжлэх ухааны хөгжил дэвшилээр явагддаг гэдэг энэ зүйл байдаг. Ер нь тэгээд дахиад тоотой холбоотой ч болоод энэ олон асуудлуудыг яг үнэндээ олон хүн сууж байгаад санал асуултаар шийдэж, шинжлэх ухааны асуудлыг санал хураалтаар үндсэндээ шийдэж болдог эсэхийг бас мэддэггүй. Үүний цаана шинжлэх ухаан л байх ёстой шүү дээ, шинжлэх ухааны үндэслэл л байх ёстой.

Нөгөө дэлхий хавтгай юу, бөөрөнхий юу гэдгийг сууж байгаа хэдэн хүн тойрч сууж байгаад шийдэж бас болдоггүй шүү дээ. Тэгэхээр үүн дээр бас нэг тодорхой хэмжээний тийм байр сууриудыг бас илэрхийлж өгөөч ээ. Ер нь тэгээд энэ хэлэлцүүлгүүд цааш цаашидаа мэдээж саяын үндэслэлүүд, тэр тусмаа пропорциональ гэдэг энэ элемент, холимог гэдэг элемент, тэр тэрний байгаа сайн талууд бас бий, саар талууд ч бий. Сайн талуудыг АН дэмжиж ирсэн учраас энэ хэлэлцүүлгийн ажилд анхнаасаа бас ингээд хэлэлцээрт суугаад эхний хэлэлцүүлэгт ингээд оролцоод явж байгаа юм. Тэгээд цааш цаашидаа бас АН-ын бүлэг өөрийн байр суурьтайгаар энэ хэлэлцүүлгүүдэд бас оролцох болно.

Дараа дараагийн саналууд, тэр зарчмын саналууд, намаас өгч байгаа үүрэг чиглэл, олон зүйл дээр бид нар бас тэр тэр чиглэлүүдийг бас баримталж ажиллана гэдгээ бас хэлье.

Г.Занданшатар: Эхлээд Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт бусад олон саналуудыг яагаад орхичхов оо гэдэг асуудал. Тэгэхээр Үндсэн хууль бол өөрөө нийгмийн зөвшилцлийн тал талаас нь шүүн хэлэлцэх ёстой ийм чухал

баримт бичиг учраас ЗГ бол Журмын тухай хуулийг бол өөрчлөхгүй ээ гэдэг ийм хатуу байр суурь барьсан. Цаашидаа ч миний хувьд улс төрд байх хугацаандаа Журмын тухай хуулийг бол өөрчлөхгүй гэдэг байр суурь дээр хатуу зогсох болно. Яагаад гэхээр энэ бол өөрөө шүүлтүүртэй хэлэлцэх, нийгмээр олон талаас нь шүүн тунгаах боломжийг олгож байгаа Үндсэн хуультай яг адилхан хэмжээний ийм баримт бичиг гэж бол бидний хувьд ойлгох ёстой. Тэгэхээрээ олон олон ийм асуултууд Журмын тухай хуулийг давах ийм боломжгүй байсан. Цахимд байришуулсан 2 заалтын хувьд бидний хувьд АН болон бусад намуудаас өөр саналууд орж ирсэн учраас бидний хувьд бол хасаад явах нь зүйтэй юм гэдэг ийм агуулгаар, нэг үгээр хэлбэл шүүлтүүр дээр гараад 6 удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үед яригдчихсан, сүүлийн 20 жилийн хугацаанд шүүн тунгаасан асуудал бол энэ тоо, тогтолцоо 2-ын л асуудал. Түүнээс ҮХЦ, хүний эрх болон бусад асуудлыг шүүн хэлэлцэх үү. Мөн нутаг дэвсгэрийн нэгжтэй холбоотой хот, тосгон байгуулах уу, үгүй юү. Мөн улсын чанартай хот байх эсэх тухай асуудал бол яг үүнтэй адилхан хэмжээнд шүүлтүүр даваагүй байгаа. Тэгэхээр тэр нийгмийн хэлэлцүүлэгт ороод явж байна гэдэг нь өөрөө эрт орой хэзээ нэгэн цагт шийдлээ олох эхлэл гэж бидний хувьд бол ойлгох ёстой л юм байна лээ.

Өнөөдөр бид нар энэ асуудлыг ярьж байна гэдэг маань өнгөрсөн хугацаанд энэ асуудлуудыг гаргаж тавьж байсан олон олон улс төрчдийн, олон олон судлаачдын тухайн үед хийсэн улс төрийн байр суурь дээр өнөөдрийн энэ хэлэлцүүлэг өдий түвшинд ирж байна л гэж бидний хувьд ойлгох ёстой юм байна лээ. Тэгэхээр бидний хувьд яараад хэрэггүй, бүх зүйлийг нэг дор хийх боломжгүй. Нийгэмдээ бид нар ойлгуулаад, зөвшилцөөд ярилцах хэрээр нийгмийн ойлголцлын тэнцвэр хаана тогтоно, тэр л өөрөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт юм байна гэдэг энэ агуулгаар хандаж байгаа.

ЗГ-аас оруулж ирж байгаа нь мэдээж би түрүүн хэлсэн, тоо хэд вэ гэхээсээ илүүтэйгээр тойргоос сонгогдох төлөөлөл, нийгмийн сегмент буюу хувь тэнцүүлэх төлөөлөл 50, 50% байх ёстой гэдэг нь бидний хувьд бол хүрэх ёстой мөрөөдлийн цэг маань гэсэн үг. Мөрөөдлийн цэг маань. Энэ маань бид нар хэлэлцүүлгийн явцад 70, 30 болох юм уу, 60, 40 болох юм уу, 50, 50 болох юм уу, энэ бол ингээд л нөгөө нийгмийн тэнцвэрийн цэг гэсэн үг. Аяндаа та хэд маань иргэдтэй уулзаад, ярилцаад хүрч ирээд, 2 дугаар хэлэлцүүлэг дээр энэ тэнцвэрийн цэг тодорхой хэмжээнд бол ингээд тогтоно.

Би дахиад хэлэхэд, хэрвээ энэ тэнцвэрийн цэг тогтохгүй бол энэ хууль батлагдахгүй. Тэр тохиолдолд өнөөдрийн бид нарын энэ хэлэлцүүлэг дараа дараагийн парламент энэ асуудлыг хэлэлцэх судалгааны том суурь болж түүхэнд үлдэнэ. Магадгүй тэр нь дараагийн удаа шийдэх тэр парламентын эхлэлийг бид нар өнөөдөр тавьж байхыг ч бас үгүйсгэхгүй. Тийм учраас яах вэ, энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг үг үсэг, цэг таслал бүхэн цаанаа маш нарийн утга агуулгатай, логик уялдаа холбоотой учраас бид нар маш нарийн тооцож ингээж ажиллах нь бол зүйтэй юм гэж бас үзэж байна.

Тэгээд судлаачдаас асуулт асууж байгаад бас их баярлалаа. Тэгээд манай ажлын хэсгийнхэн яг тэр тоо болон бусад асуудал дээр дэлгэрэнгүй судалгааны нөхцөл байдлууд ямар байна. Үүнийг хариулах нь зүйтэй байх. 86 дугаар микрофон.

Г.Занданшатар: 86 Бумдарь.

Д.Бумдарь: Би яг улс төр судлалынхаа үүднээс бол тайлбарлая гэж бодож байна. Тэгэхээр энэ хүн амын тоонд харьцуулаад куб язгуур гарч байгаа гэдэг ганцхан үндэслэл яриад байна гээд тэгж байна, тийм ээ. Гэтэл

энэ маань цаанаа маш олон уул нь үндэслэлийг бол шингээсэн байгаа. Яг энэ куб язгуурын аргыг анх ашигласан нь бол 1910 онд Английн сонгуулийн үр дүнд суурилж бол хийж байсан юм. Нэг ёсондоо 2 том нам сонгуулиар ямар санал авна, тэр нь парламентад орохоороо 2 намын куб болдог юм байна гэдгийг нотолж, түүнийгээ бол тухайн үед хэрэглэж байсан байгаа юм. Тэгээд түүнийг 1969 онд Такапира ашиглаад парламентын хэмжээг бол хүн амд нь суурилж болох юм байна гэдэг зүйлийг гаргаж ирсэн байгаа юм. Тэгэхдээ куб язгуурын цаана ямар зүйл шингэсэн байдаг вэ гэхээр хүн амын тооноос гадна эдийн засгийн хөгжлийн түвшин орж ирж байгаа юм. Үүнээс гадна нийгмийн шилжилтийн түвшин, үндэсний бие даасан байдал, тусгаар тогтнол, сонгуулийн арга тийм ээ. Сонгуулийн тэр тогтолцоо нь ямар юм, парламентын чадамж, чиг үүрэг, шийдвэр гаргадаг байдал нь ямар юм, зөвлөлддөг юм уу, шууд гараа өргөдөг юм уу.

Мөн тухайн төр нь эртний уламжлалт төр юм уу, эсвэл орчин цагийн төр юм уу, хувь хүний болон үндэсний онцлог нь ямар юм бэ гэдгийг бүгдийг нь шингээж байгаад 3 төрлийн тэгшитгэл бол гаргаж ирсэн байгаа. Тэгээд бид нар нөгөө хамгийн хялбарчилсан байдлаар нь куб язгуур гэж яриад байгаа боловчиг яг эхний жишээлбэл тэгшитгэлийг нь харах юм бол хөдөлмөрийн насны хүн ам, мөн тэр бичиг үсгийн тайлагдал энэ тэр гээд, мөн дэлхийн дунджид тухайн саяын дурдсан зүйлүүд нь никтэй тэнцдэг бол тэр нь тухайн бас хэдтэй байх вэ гэдгийг бүгдийг нь тооцоолж байгаад бол гаргаж ирдэг байгаа. Тэгээд бид нарын хувьд, манай улс төр судлалын хувьд бол куб язгуур нь илүү ойлгомжтой гэдгээр нь авч ашиглаад бодож байгаа. Түүнээс биш саяын өгөгдсөн бүх зүйлүүдийг дурдах юм бол манайх бүр 154.4 гарч байгаа. Кубээрээ болохоор 150.9 гарч байгаа, ийм юутай байгаа шүү гэж хэлмээр байна.

Тэр орчин цагт бид нар технологийн дэвшлийг ашиглах ёстой биз дээ гэж байна. Мэдээж түүн дээр бол санал 1-тэй байна, ашиглавал илүү их бүтээмжтэй байх ёстой. Яагаад гэвэл парламентын хэмжээ гэдэг маань бүтээмжийн л асуудлыг ярьж байгаа тийм ээ. Хүмүүс хоорондын харилцааны асуудал хэр их бүтээмжтэй байж байж тэр парламентаас үр өгөөжтэй хууль батлагдаж байна аа гэдгийг л ярьж байгаа. Гэтэл тэр харилцааг зөвхөн технологийн давуу байдлыг ашиглаад хийнэ ээ гэвэл магадгүй энэ хэлэлцүүлгийг орон нутагт очиж тойрогтоо ярина гэдэг зүйлийг зөвхөн технологи ашиглаад ярих юм бол бас хүрэхгүй байх магадлал өндөртэй байхыг үгүйсгэхгүй тийм ээ. Тэгэхээр нөгөө энэ хүн хоорондын харилцааг яаж зохицуулах вэ гэдэг нь энэ парламентын хэмжээнд бас орж ирдэг. Энэ нь их чухал байдаг. Такапэригийн энэ куб язгуур. Тэгэхээр зэрэг минийхээр бол яг энэ тооцоонд технологийн дэвшилт байдлыг тооцоолоогүй. Мэдээж Ууганбаатар багш эдийн засагч учраас тэр технологийн дэвшлийг яаж шингээж болох вэ гэдэг талаар бол хийж өгөх байх.

Яг одоогийн нөхцөл байдлаар бол жишээлбэл Монгол Улсын нөхцөлд тойргийнхоо сонгогчтой очиж уулзахаас өөр аргагүй нөхцөл байдал байна гэдгийг бол харж байна. Мөн гишүүд хоорондын харилцаа гээд маш олон энэ коммуникац дээр тогтож байгаа учраас тэр бүхнийг энэ кубын язгуурт шингээдэг юм шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн. Байж байгаарай, Чинбүрэн гишүүнийг больё. Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

О.Цогтгэрэл: Тэгэхээр яг эндээс ард иргэдийн дотор ч гэсэн яг энэ эргэлзээ л байгаад байгаа юм л даа. Яагаад 152 гэж, нэмэгдэж болно, тэгэхдээ яагаад гэдэг тоо. Тэгэхээр яг ажлын хэсгээс хариулж байгаа, тэр

судлаачдын хариулж байгаа энэ бол сонсоод суухад надад бол үнэхээр хангалтгүй л байна л даа. Кубын язгуур л гэх юм. Наадах чинь техник, технологийн хөгжил дэвшил гэдэг чинь үржүүлэгч нөлөөтэй, нэмдэг нэмэгдэх биш үржүүлэгч асар өндөр нөлөөтэй ийм зүйл 90 онд бид нар ард иргэдтэй харилцах нөхцөл байдал, тэр үеийн харилцаа холбоо ямар байлаа, тэр үед ямар байлаа, тэр үеийн дэд бүтэц, зам, машин тэрэгний хүч, хурд ямар байлаа. Өнөөдөр бид нар хэдэн иргэнтэй яаж мэдээллээ солилцох боломж бололцоо хэдэн хувиар биш хэдэн 100%-аар, хэдэн 10 дахин нэмэгдчихээд байна. Энэ бүр хувьсгал гарчхаад байна.

Тэгэхээр энэ нөлөөг чинь наад шинжлэх ухаанд чинь энэ улс төрийн шинжлэх ухаанд энд үүнийг харгалзаж үзсэн л баймаар юм. Тэгэхээр та нар чинь зүгээр нэг л төлөөллийн чадвар тэдэн иргэн хүн ам тэд дахин өссөн гэдэг чинь бол үнэхээр тийм хангалтгүй. Тэгэхээр үнэхээр энэ ажлыг та нар ажлын хэсэг гэж яваад л энэ том төсөл, энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөд явуулах гэж байгаа бол ард талд нь тэр шинжлэх ухааны тайлбаруудаа илүү сайн шигтгэж өгөхгүй л бол наад тайлбарууд чинь бол үнэхээр хангалтгүй сонсогдож байна аа.

Г.Занданшатар: Үүрцайхын Амарбат тодорхой хариулаарай.

Ү.Амарбат: Та бүгдийн энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Саяын куб язгуурын аргаас гадна энэ парламентын гишүүдийн тоог нэмэгдүүлэхтэй холбоотой яг энэ парламент өөрийнх нь үндсэн чиг үүрэг болох 3 үндсэн чиг үүрэг дээр гишүүдийн тоог нэмэгдүүлснээр аль аль чиг үүрэг дээр ахиц дэвшил гарна гэдэг ийм судалгааны дүгнэлт бол гарсан байгаа. Үүнд:

1 дүгээрт, парламент бол ард түмнийг төлөөлөх чиг үүрэгтэй. Энэ утгаараа гишүүдийн тоог нэмэгдүүлснээр төлөөлөх чадамж тоон

утгаараа болоод агуулгын утгаараа сайжирна гэдэг энэ дүгнэлт бол гарч байгаа.

2 дугаарт, парламент хууль тогтоох чиг үүрэгтэй. Тэгээд хууль тогтоох энэ ажиллагааных нь чадамжаар парламентын чадамжийг үнэлдэг. Тэгэхээр гишүүдийн тоо нэмэгдсэнээр одоо, өмнө Хууль зүй, дотоод хэргийн сайдын дурдсанчлан парламентын гишүүд мэргэшиж ажиллах, гарч байгаа хуулиудын чанар нэмэгдэх ийм эерэг үр дагавар гишүүдийн тоо нэмэгдсэнээр гарах ийм боломжтой.

3 дугаарх нь, аливаа бодлогын үндсийг бол парламент дээр баталж байгаа. Тэгэхээр гишүүдийн тоог нэмэгдүүлээд холимог тогтолцоог оруулж ирснээр энэ батлагдаж байгаа бодлого бол аль нэг талын гэхээсээ илүүтэйгээр олон талын санал тусах, олон намын оролцоо тусах, ингэснээрээ тухайн бодлого маань өөрөө илүү чанартай үр нөлөөтэй гарах, нийгмийн олонхын дэмжсэн бодлого биш, харин зөвшилцөж, дэмжигдсэн бодлогууд батлагддаг. Ийм олонхын ардчиллаас зөвшилцлийн ардчилал руу шилжих ийм энэ боломж маань энэ 3 дахь нөхцөл дээр бүрдэнэ гэж үзэж байгаа.

Бас таны хэлсэнчлэн гишүүдийн тоог бууруулах бол нэг бас хувилбар байж болно. Гэхдээ энэ нөгөө бууруулснаар нэгжид байгаа нөлөөлөл нь өөрт нь сайжрах боловч нөгөө талдаа бид нарын энэ задлах гээд байгаа төвлөрөл маань улам хумигдаад ингээд эсрэгээрээ нэгж гишүүн дэх парламентын сонгуулийн зардал, нэгж гишүүний нөлөө ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Өнөөдөр 5 сарын 5. Эх баригчдын олон улсын өдөр. Би бас энэ микрофоныг ашиглаад 100 жилийн түүхтэй орчин цагийн эх баригч

хүйн ээжүүддээ бас баярын мэнд дэвшүүлэе гэж бодож байна.

Баярлалаа, дэмжиж алга ташина. Үнэхээр үүнд бид бас алга таших ёстой юм аа. Яагаад гэхээр 1921 онд ердөө 640 мянга гаруйхан хүн амтай байсан Монгол Улс маань өнөөдөр 3.4 сая болж, эх нярайн эндэгдлийг бууруулахад эрх баригчид та бүгдийн үүрэг ихээхэн чухал юм. Дэлхийн бусад орнуудад ер нь бол ойролцоогоор бараг 70 гаруй жирэмсэн эмэгтэйчүүд тусгай мэргэжлийн газар төрдөг бол Монгол Улсад харин 98-аас их хувь нь тусгай мэргэжлийн газар мэргэжлийн хүмүүсээр тусламж аван төрж байгаа. Тийм учраас хүний хорвоод хүмүүн болон төрөхөд хамгийн түрүүнд тосон авдаг ачтай буянтай хүмүүс эх баригч нар юм шүү. Та бүхэндээ төрүүлсэн мянга мянган үрсийнх нь өмнөөс баярлалаа гэж хэлье. Хүйн ээжүүддээ дахин олон улсын эх баригчдын баярын мэндийг хүсье.

Ингээд сэдэв рүүгээ орёе. Чухал сэдэв ээ. Тэгээд өнөөдөр УИХ-ын гишүүн ард түмний элч гэж Үндсэн хуульд заасан. УИХ бол бага ард түмэн гэдэг. Тэгээд үнэндээ яг шударга хэлэхэд бол энэ танхим дотор яг энэ ард түмний элч болоод бид бүгдээрээ сууж чадаж байна уу, тийм ээ. Энэ парламент гишүүд 76 бид дотор гэр хорооллын иргэн сууж байна уу? Хөгжлийн бэрхшиэлтэй иргэн, багш, инженер, эрдэмтэн, малчин, жижиг дунд бизнесийн төлөөлөл, эмэгтэйчүүд, залуучууд, эмч, сувилагч илүү олон байх ёстой. Тэгвэл энэ жинхэнэ ард иргэдийн нийгмийн төлөөлөл болно. Өөрсдөдөө хамаатай хууль шийдвэрийг батлалцдаг байх ёстой. Асуудал хүндээ биш ээ тогтолцоондоо байна.

Мажоритар тогтолцооны сул тал нь мөнгө, санхүү, хүн хүчний нөөц их шаарддаг учраас нийгмээ төлөөлөх хүмүүс орж ирж чаддаггүй нь үнэн шүү дээ. Улс орноо тойрогт хуваасны сул тал бас маш их байна. Жишээ нь би БЗД-ээс сонгогдсон, тэгээд зөвхөн БЗД-ийн

эмнэлгийн асуудлыг яриад байх юм уу, бүх улс орны хэмжээнд хорт хавдраас сэргийлэх асуудлыг хөндөх үүрэгтэй. Эмч хүн ард түмнээ аль тойргийнх вэ гэдгээр нь ялгах эрхгүй шүү дээ. Гэтэл улс төр ийм байдал руу түлхэж байна. Тойрог тойрогтоо эмнэлэг засахаас илүү улс орноо бүхлээр нь харж, оношилж, эмчилж урьдчилан сэргийлж чаддаг, бүх Монголоо эмчилдэг ийм тогтолцоо хэрэгтэй шүү дээ, тийм ээ.

Тойрогт гишүүд хуваагдаад байгаа төдийгүй сонгогчид бас хуваагдаж байна. Өөрийнхөө тойрогт нэр дэвшсэн хүмүүс дундаа л сонголт хийдэг нь сонголт уу, тулгалт уу? Энэ асуултыг би бүр зориуд тавья гэж бодож байгаа. Жишээлэх юм бол та нэг эм хайж яваад эмийн санд ороод тэр эм чинь байхгүй, оролцож байгаа энэ эмийг нь аваад уучих гэдгийг тийм сонголт тулж байгаатай л яг ижил. Тэгэхээр бид дэвшсэн хүмүүст дундаасаа сонгодог ийм сонголттой тогтолцоонд амьдарч өдий хүрсэн. Заавал зохион байгуулалтын бүтэцтэй, олон мянган гишүүнтэй, 2 намын нэгд нь элсэж байж л сонгуульд нэр дэвшиж ялах нөхцөл бүрддэг нь үнэн. Үндсэн хуульд Монгол Улсын иргэн төрийн байгууллагад сонгогдох эрхтэй гэж заасан. Өнөөдөр бид бодит байдал дээр нийгмийн гэрээ гэдэг Үндсэн хуулийн заалт хэрэгжихгүй байна. Үндсэн хуульд Монгол Улсын иргэн төрийн байгууллагаас сонгогдох эрхтэй гэж заасан юм бол иргэн бүр төлөөлөл болоод төрийн өндөр байгууллагад ажиллах боломж нээлттэй юм уу? Үгүй л байна. Гэрээ бол хэрэгждэг байх ёстой, хэрэгжихгүй байгааг гэрээг хэдэн ч удаа шинэчилж болно. Тэр ч утгаараа Үндсэн хуулийг бид хэдэн ч удаа өөрчилж болно.

Улс төр эрүүл биш өвчтэй байна. Тийм учраас би Ерөнхий сайд, МАН-ын дарга Оюун-Эрдэнийн энэ Монгол Улсын тогтолцоог төрийн энэ тогтолцоонд том шинэчлэл хийх гэж байгаа мэс засал хийх энэ эр зоригийг нь үнэхээр үнэлж байна, дэмжиж байна.

Өнөөдөр эрүүл мэндийн салбарт 60 гаруй мянган эмч, сувилагч, эмнэлгийн ажилчид ажиллаж байна. 31 жилийн хугацаанд 8 удаагийн сонгуульд түүхэндээ уртаашаа зургаахан эмч сонгогдсон байдаг. Яг одоогийн парламентад эмч мэргэжилтэй 3 гишүүн, жишээлбэл ажиллаж байх жишээтэй. Тэр 60 мянган цагаан нөмрөгтэй эмч нар, эмнэлгийн ажилчид 3.4 сая иргэнээ эмчлэх үүрэгтэй ажиллаж байгаа өнөөдөр, эрүүл байлгах үүрэгтэй ажиллаж байгаа. Тэгэхдээ л бид энд 3-уулаа сууж байгаа учраас энэ 3.4 сая иргэнийг төлөөлж дуу хоолой нь цөөдөж байна. Яагаад сувилагч хүн Их Хурлын гишүүн болж болохгүй гэж.

Өнөөдөр би 14 мянган сувилагч, бага эмч, тусгай мэргэжлийнхэнтэй уулзаж явж байна. Маргааш Говь-Алтай аймагт баруун бүсийн 4 аймгийн сувилагч нартай уулзалт хийх гэж байна. Энэ уулзалтын үеэр хэлж байгаа зүйл бол сувилагч гэдэг энэ ховордсон мэргэжлийн эрх ашиг, энэ мэргэжлийн үнэ цэнэ, энэ мэргэжлээр ажиллах хүсэлтэй хүмүүсийг нэмэгдүүлэх бодлого та нарт дутагдаж байна гэдгийг сувилагч болгон шүүмжилж хэлж байна.

Тэгэхээр төгсгөлд нь миний хэлэх гэсэн санаа бол намын жагсаалтын ард хүн нуугдахгүй ээ. Тэгж яривал нэр төртэй нийгмийн олон янзын төлөөллөөс бүрдсэн жагсаалтын ард нам нь нуугдана шүү, харин. Тэр төлөөлөл нийгмийн сайн төлөөллийн ард нам нь нуугдах юм аа. Өнөөдөр хүн нуугдаад байхаар тийм нэр хүндтэй нам ч алга. Салбар салбарын мэргэжлийн хүмүүсийн нарийн шүүлтүүр хэрэгждэг хууль хэрэгтэй, бодлогыг баталж парламент илүү бодлогыг болж төлөвшинө. УИХ бол ... /минут дуусав/

Г.Занданшатар: Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Чинбүрэн гишүүнд бас үргэлжлүүлж ярих боломж олгохын тулд асуултад хариулж байна.

Яагаад гэхээр маш чухал асуудлыг их тийм зөв хөндөж байна гэж бодож байна. Ер нь сая Чинбүрэн гишүүн бараг л энэ Үндсэн хуулийн энэ нэмэлт, өөрчлөлтийн гол концепцыг ер нь бол маш сайн гаргаад тавьчихлаа гэж би бол зүгээр хувьдаа бодож байна.

Өнөөдөр бидний дунд хэрвээ Чинбүрэн гавьяат эмч байгаагүй бол өнөөдөр бид нар магадгүй саяын тэмдэглэлт өдрийг мэдэхгүйгээр энэ хэлэлцүүлэг болоод л өнгөрчихнө гэсэн үг. Энэ танхим дотор өнөөдөр энгийн малчны төлөөлөл байсан бол ХАА-н бодлого хэлэлцэж байх үед биднээс шал өөр түвшиний энгийн амьдрал дээр байгаа асуудлыг гаргаж тавина. Энэ танхимд сувилагчдын төлөөлөл байсан бол өнөөдөр эмч, сувилагчдын тоо, сургалтын чанар хэрхэн алдагдаж байгаа талаар олон олон асуудлыг бид нарт гаргаж ирж тавина. Энэ танхимд автобусны жолооч нарын төлөөлөл байсан бол өнөөдөр нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг биднээс хамаагүй илүү түвшинд ойлгож ярьж, хэлж сануулж бас чадна. Энэ танхимд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл байсан бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хуулийн заалт, зүйл бүхэн дээр үүнийг илүү тодоор харж, томъёолж гаргаж ирэх ийм боломж бас бүрдэнэ. Гэр хороололд амьдарч байгаа иргэдийн төлөөлөл олон байх тусам гэр хорооллын хөгжлийн асуудлыг илүү их томоор, илүү их бас цогц бодлогоор гаргах ийм боломжууд бүрдэнэ. Энэ танхимд магадгүй гадаадад хүнтэй суусан Монголчуудын төлөөлөл байсан бол айгаад ярьж чаддаггүй байгаа тэр асуудлыг гаргаж ирж нийгэмд зоригтой илэрхийлж бас чадна. Тэр бүрээр дуу хоолой нь бүрддэггүй. Нийгмийн цөөнх болсон олон олон төлөөлөл хэрвээ парламентад орж ирвэл бодлого илүү дэмжлэгтэй, тогтвортой, мөн нийцтэй байх боломжтой.

Нэг ийм жишээ бас байдаг юм байна лээ. Одоо цэцэрлэг засаад, эцэг эхчүүд хүүхдүүдээ дагуулаад орсон,

хүүхдүүд засагдаагүй байна гэж үзсэн. Яагаад гэхээр том хүний харах өнцгийн түвшинд байгаа ханыг будчихсан байсан. Цэцэрлэг хүүхдүүдийн харах өнцөг дээр өөрчлөгдөөгүй л байсан. Бодлого буруу гарч байна гэсэн үг. Яг үүнтэй адилхан парламент томорч нийгмийн төлөөлөл орж ирэх боломж нэмэгдэх тусам төрийн бодлого илүү зөв болно, илүү мэргэн болно. Тэгэхээр энэ агуулгаараа л энэ сонгуулийн хувь тэнцүүлсэн тогтолцоо маань өөрөө нийгмийн сегмент бүрийн төлөөллийг хангах боломжтой болно.

1, 2 сонгуулиар төлөвшихгүй байж магадгүй. Гэхдээ энэ цаашидаа, гэхдээ энэ цаашидаа хэрвээ нийгмийн сегментүүдийнхээ дуу хоолойг сонсохгүй яваад байвал тэр улс төрийн нам, улс төрийн тавцангаас арчигдана гэсэн үг. Ийм шинэ шинэ намууд үүсэж бий болж гарч ирнэ. Тэгэхээрээ энэ бол бас сонгуулийн тогтолцооны бас ийм чухал зүйлүүдийн нэг юм гэдгийг бас хэлээд тэгээд Чинбүрэн эмчдээ бас баяр хүргэе. Яг өнөөдөр бид нарын дунд ингээд эмч нарын яг ийм чухал сегментийн төлөөлөл сууж байна гэдэг маань өөрөө парламентад ямар их тийм өнгө төрхийг тодорхойлж, өөр байгаа байдалд оруулж байгааг бол бид нар бас бодитоор харж байгаа нэг илэрхийлэл юм аа.

Ингээд танд үлдсэн минутаа өгье.

Г.Занданшатар: Агар-Эрдэнэ дарга аа, энэ гадаа байгаа улс, яриад л суугаад байх юм. Наад хурал, зохион байгуулалтад анхаараач. Гадаа энэ ярьж байгаа улсууд, энэ нэг бол хаалгаа ав, нэг бол наадуулаа, зохион байгуулалт алга. Асуулт хариултад хариулж байхад. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Ерөнхий сайдад баярлалаа. Бас миний коментуудыг бас дэмжиж ярьж байгаад. Тэгэхээр би бас энэ дээр нэмж хэлэх гэсэн зүйл бол энэ тооны тухай байна аа. Ер нь манай анагаах ухаан бол өөрөө нотолгоонд тулгуурласан шинэжлэх ухаан, өөрөө

дандаа энэ төлөөллийг тодорхойлж байдаг. Түүнээс энэ санамсаргүй тоо гаргачхаагүй ээ, 152 гэдэг тоо бол өөрөө судалгаатай, нотолгоотой гаргасан гэдгийг түрүүн Амарбат ч гэсэн бас хэлж байна, тийм ээ.

Тэгэхээр энэ дээр бол ер нь төлөөллийг ямар магадлалаар оруулж ирдэг юм бэ гэдгээ илүү та бүхэн бас энд хэлж ярьж өгч, тухайлах юм бол бид өнгөрсөн 5 сард ард иргэдтэй уулзалт ярьж явсан. Ингэхэд бол ард иргэд тайлбарлаад, ухуулаад, ойлгуулахаар дэмжиж байна лээ. Энэ бол санамсаргүй одоо гэнэтхэн ярьсан зүйл биш ээ.

Мөн бас Их Хурлын даргатай бид бас Японд албан ёсны айлчлал хийхэд Япон улсын жишигээг бид харсан. Тэр 1988 оны үед Рекрют гэдэг том хэрэг зөрчил гарсан. Одоогоор бол манай энэ нүүрсний хулгай, Хөгжлийн банкны хулгайтай яг адилхан зүйл шүү дээ, тийм ээ. Тэгээд доор нь мажоритар тогтолцоогоо сольсон. Дээрээс нь хулгай хийх боломжийг хуулийн багц хуулиудаараа хулгай хийх боломжийг хааж өгчихсөн ийм сайн туршилага. Өнөөдөр Япон улс мажоритар тогтолцооноосоо холимог тогтолцоо руу шилжчихсэн 495 парламентын гишүүдтэй ингээд сууж байна. Энд бол бид сайн жишигийг, сайн эмчилгээний технологийг авдагтай адилхан сайн жишигүүдийг бид даруй хурдан авч хэрэгжүүлэх ёстой. Тийм учраас харин бид удаан байна, Ерөнхий сайд аа. Харин бид илүү хурдан ажиллах хэрэгтэй байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Сонгуулийн тогтолцооны өөрчлөлт ярьж байна. Аливаа өөрчлөлт шинэчлэлийг агуулдаг гэдэг утгаараа энэ яриад явах нь зүйтэй. Тоо энэ тэрийнхээ юуг үзэх нь зүйтэй. Энэ ингээд 152 гэж өргөн баригдсанаас хойш нийгмийн сүлжээнд байж байгаа хүмүүсийн санал энэ тоог их байна гэсэн ийм зүйл яригдаж байна. Тэгэхээр үүнийг

бол хэлэлцүүлгийн явц дунд үзэх ёстой гэж.

Японд тийм байдаг, Америкт тийм байдаг, Европт тийм байдаг гэж байгаа. Аливаа зүйл бол эдийн засгаар баталгаажсан л байх ёстой. Хэр зэрэг өнөөдөр манай энэ улс төрийн тогтолцоо, сонгуулийн энэ тогтолцоо энэ маань эдийн засгаараа яаж баталгаажиж байна? Монгол Улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжээд 30 жил явахдаа нэг 15 тэрбум долларын эдийн засгийг л бий болгосон байгаа юм. Дэлхийд 15 тэрбум доллароос дээш орлоготой 13500 компани байна. Монгол Улс Оюутолгой, Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгойгоо нийлээд энэ 13501 болж эд нарын дараа жагсаж байна. Нэг хүнд ноогдох ДНБ нь 12 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаар 5032 доллар болж одоо л 5 мянган доллар давж байгаа. АХБ-ны сүүлийн гаргасан судалгаагаар 10 мянган доллароос доош Жи Ди Питай улсууд ядуу оронд хамаарч байгаа. Тэгэхээр үүнийг яагаад ингэж ярьж байна гээд ингэе гэхээр зэрэг эдийн засгаар баталгаажихгүй байна. Үүнийг би хэлэх гээд байгаа юм.

Монгол Улсын хөгжил бол яг өнөөдөр энэ 30 жилийн хугацаанд яваад хөгжлийн мухардалд орчихсон байгаа шүү. Үүнийг бол бид хүлээн зөвшөөрөх ёстой. Гадаад өрийн хэмжээ 33.4 тэрбум доллар. Эдийн засаг нь өсдөг боловч өгөөжгүй, хүртээмжгүй, нийт иргэдийн 27 дээр нэмэх нь 15 гээд 42 орчим хүн ядуурах магадлалтай болчихсон. Бүтээмжийн өсөлт тэг, баялгийн менежмент муугаас баялгийн хараалд өртсөн, Голланд өвчинд өртчихсэн. Тэгээд чөтгөрийн тойрогт орсон гээд. Ингээд энэ тойргоос гарахад нэг 10 жил хэрэгтэй гэж байгаа юм. Тийм учраас энэ улс төрийн шинэчлэлийг хийхдээ эдийн засгийн шинэчлэлийг бол давхар бодож байх ёстой шүү. Үүнийг би өнөөдөр зориуд хэлье гэж бодож байгаа юм. Том, том юм ярьж болно, том том юм мөрөөдөж болно, эдийн засгийн

асуудлаа бол давхар авч явах ёстой гэдгийг би хэлэх гээд байгаа юм.

Энэ ингээд энэ 30 жилийн мухардал энэ сонгуулийн тогтолцоондоо байсан юм уу эсвэл бидний алдаанд байсан юм уу. 2 хөрш маань Монголд маш их таатай хандаж ирсэн, одоо ч, өнөөдөр ч таатай хандаж байгаа. 3 дахь хөршүүд маань бидэнд сайхан хандаж ирсэн. Яагаад өнөөдөр ингээд мухардалд орчхож байна гэхээр зэрэг бидэнтэй өөрсөдтэй нь холбоотой, Монгол хүмүүстэй холбоотой, Монголчууд бид Монгол Улсаа хөгжүүлж чадаагүй. Энэ нь сонгуулийн тогтолцоондоо байсан юм уу эсвэл юундаа байна аа? Үүнийг би асуух гэж байгаа юм, 1 дүгээр асуулт энэ байна.

2 дугаар асуулт, 2 дугаар асуулт. Ер нь хэлэх үг бол 1992 онд 1 гишүүнд 27 мянган сонгогч оногдож байсан, одоо үндсэндээ 41.7 болох юм байна л даа. Тэгээд тэр 92 онд чинь энэ цахим, интернэтийн орчин бараг байхгүй байсан шүү дээ. Өнөөдөр ингээд бид нарын өглөөнөөс хойш ярьж байгаа, ерөөсөө Монгол даяар хараад сууж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ төлөөлөх, энэ мэдээлэл авах орчин маань 92 оныхоос хамаагүй өөр болчихсон. Ийм учраас энэ энэ тэртэйгээ тооцож барьж, энэ хүн амьтныхаа тоогоо бодох нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа. Зарим газар бол 2, 3 сая хүнийг төлөөлж байгаа гээд ийм орнууд ч байж байгаа шүү дээ. Ер нь тэгээд эцсийн эцэст энэ сонгуулийн төгс тогтолцоо гэдэг юм дэлхийд бол хаана ч байхгүй, санал гээгддэггүй систем гэж хаана ч байхгүй. Тийм учраас бол аль Монгол Улсын өнөөдрийн онцлогт тохирсон энэ тогтолцоог л бид нар олж авах нь зүйтэй байгаа юм.

Ер нь байдал бол маш хүнд байгаа шүү дээ. Өнгөрсөн ингээд 3 жил 20, 21, 22 онд Монгол Улсын нийт нэгдсэн инфляцын түвшинд 34% болсон. Нийт Жи Ди Пигийн 66 орчим хувь нь өрхийн секторт оногдож байгаа шүү дээ. Өрхийн секторын орлого 0.7%-аар

буурчихсан байгаад байдаг. Тэгээд энэ ерөөсөө эдийн засгийн харилцаа харьцаа ерөөсөө алга болчихсон болчихсон. Тэгээд ингээд энэ инфляцаар нь тооцоод үзэхээр зэрэг 14 их наяд төгрөгийг нэмээд иргэдийнхээ карманаас хийсгэчихсэн байгаа байхгүй юу. Ийм л эдийн засагтай байна, бид нар. Тэгээд эдийн засгийг бид нар их бага ярьж байна. Хани гээд тэгэхэд сүүлийн 30 жилд 900 дахин уначихсан байгаа шүү дээ. Тэгээд үүнийг яагаад хэлээд байна гэхээр энэ эдийн засгаар баталгаажсаагүй ямар ч юм амин сүнсгүй. Монголын ардчилал ч гэсэн төгс ардчилал биш болчихсон. Яагаад гэхээр эдийн засгаар баталгаажсаагүй. Ийм юм байгаа юм аа.

Тэгээд би хэд 3 асуултууд байна. Түрүүн нэг асуулт асуучихсан. Энэ манайх зах зээлийн эдийн засгийн харилцаанд бүрэн шилжээгүй байгаа юм аа. Яг яах вэ дээ, улс төрийн 25 нам нэгдээд энэ холимог гээд ингээд ярьчихсан юм байна. Яг энэ судалгаанууд байна уу? Ямар судалгаа байна? Яг өнөөдрийн нөхцөлд ийм эдийн засагтай, яг ийм боломжтой, ийм хөгжлийн түвшинд хүрсэн улсууд яг ямар сонгуулийн тогтолцоо өнөөдөр Монголд тохирох вэ? Энэ эрдэмтдийн, эрдэм шинжилгээний байгууллагуудын, энэ улс төр судалдаг улсуудын энэ ийм судалгаа байдаг юм уу, үгүй юү гэсэн ийм 2 дахь асуулт байгаа юм.

Дараагийн асуулт бол юу гэхээр энэ манайд зүгээр яах вэ намуудын хууль дээр нэлээн сайн ярих байх л даа. Олуулаа больё гэж байгаа. Яах вэ олуулаа болохдоо яах вэ дээ. Бид хамгийн гол нь хөгжлийн төлөө эв нэгдэлтэй байж чаддаг хүмүүс энэ Их Хуралд олноор орж ирэх ёстой. Ёс зүйтэй хүмүүс энэ Их Хуралд олноор орж ирэх ёстой. Монгол Улсын хөгжлийн төлөө чин шударгаараа зүтгэж чаддаг хүмүүс энэ Их Хуралд орж ирэх ёстой. Улс эх орныхоо том эрх ашгийг жижиг эрхийн ашгийн өмнө сөгддөггүй, том эрх ашгийг барьж ажиллаж чаддаг ийм хүмүүс орж ирэх ёстой. Тэгээд энэ чиглэлд бид нар яг юу

бодох вэ? яах вэ? янз бүрийн төлөөллүүд энэ тэр орж ирэх л юм байна. Өөрөөр хэлбэл шүүлтүүр ямар байх ёстой вэ? Ард иргэд сонгуулийн энэ боловсрол, ард иргэдийн энэ юмнуудыг яаж ойлгуулах ёстой вэ? Энэ чиглэлд ямар бодол санаа байна аа? Ямар юм бодож байна. Энэ би ажлын хэсгийнхнээс асуух гэж байгаа юм.

Мэдээж зөндөө судалгаа энэ тэр хийсэн байх. Үүнийг тэгээд энэ өнөөдөр бас яригдаад байгаа юман дээр жижиг мажоритар бол хөрөнгө оруулалтыг жижиг юм руу татдаг барьдаг л гээд байгаа юм л даа. Тэгээд энэ яах вэ? Нэг хуулиар хориглохож болох ёстой. Улаанбаатарын мухар зам Их Хурлын гишүүд гэхээсээ илүү хотын захиргаатай холбоотой байх шүү. Үүнийг бодмоор байгаа юм аа.

Энэ дотор сүүлийн асуулт нэг юм байна. Их хурлын гишүүний нөлөөлөл, эрх мэдлийг багасга гэж байгаа юм. Би 2 дахь удаагаа сонгогдож 7 жил сууж байна. Надад нэг их айхтар нөлөөлөөд эрх мэдэл надад нэг их тийм юм алга, хууль санаачлах эрх байна. Энэ ямар юу гэсэн үг вэ? Ямар судалгаан дээр гарсан ийм зүйлийг энд гаргаж ирж, ярьж байгаа юм бэ? Ийм асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Өнөөдрийн бодит нөхцөл байдал олон улсын хувьд ч сорилттой, дотоод нөхцөл байдал ч сорилттой байна. Үүнийг бид нар шийдвэрлэхийн тулд шинэ сэргэлтийн бодлого хэмээх ийм яг эдийн засгийн төрөлжсөн бодлогыг УИХ-аар батлуулж хэрэгжүүлж эхлээд байна. Тэгээд Баттөмөр гишүүн мэдээж мэдээлэлтэй, гэхдээ би үүнийг бас хэлчих нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Ер нь бол Монгол Улсын өнөөдрийн нөхцөл байдалд бид нар ДНБ 48.1 орчим их наяд төгрөг. Гэхдээ үүнийг

21-22 оны дунджаар авч үзвэл энэ бол манай эдийн засгийн багтаамж гэж ойлгож болно. Уртаашаа өргөөшөө 40 литрийн бидон дотор байгаа яг ийм л хэмжээний л эдийн засаг бид нарт байна гэсэн үг. Үүний 16.9 их наяд нь буюу 35 орчим хувь нь бол Монгол Улсын нэгдсэн төсөв байна. Харамсалтай нь урсгал зардал 79% буюу бараг 80-аад хувьтай байна. Хөрөнгө оруулалтын зардал 21% буюу ерөөсөө 3.8-хан их наяд төгрөг. Үүн дотор шилжих хөрөнгө оруулалт нь 2.9 их наяд төгрөг, шинэ хөрөнгө оруулалт ерөөсөө 900 тэрбум ийм байдалтай байна. Гадаад өр 96 их наяд. Тэгэхээр сүүлийн үед ЗГ яагаад ингээд л Чингис бондын өр төлөлт, Самуурай бонд, Гэрээг бонд гээд ийм өр төлөлтүүдийг хийгээд байна. Яагаад ЗГ бас нэмж өр үүсгэхгүйгээр ингэж асуудлуудыг аль болохоор төр, хувийн хэвшлийн түншил хөрөнгө оруулалт дээр тулгуурлаж хийх ийм концепц дэвшүүлээд байна гэдэг нь бид нар гэр орноо цэгцэлж авах гэж байгаа л ийм хувилбар гэж ойлгож болно. Тэгэхээр үүнийг бол манай Баттөмөр гишүүн маш сайн мэдэж байгаа.

Бидний бас нэг маш сайн анхаарах ёстой зүйл бол энэ төлбөрийн тэнцэлтэй холбоотой асуудал. Бид нар ерөөсөө нүүрс, зэс гэдэг ийм хоёрхон бүтээгдэхүүн, дээрээс нь төмрийн хүдэр, алт гээд ийм дөрөвхөн бүтээгдэхүүн дээр бид нар валют олж, экспортолж валют оруулж ирдэг. Нефтид бид нар 1.7 тэрбум ам.доллар, хүнсэнд 1 тэрбум ам.доллар барилгын материалд 1 тэрбум ам.доллар, автомашинд 600-700 сая ам.доллар, эрүүл мэнд болон боловсрол болон бусад үйлчилгээнд бид нар жил бүхэн 450 сая ам.доллар, эрчим хүчинд 180 орчим сая доллар. Ингээд архи, тамхи болон бусад хэрэглээнд бид нар 100 орчим сая ам.долларыг алдчихаж байна. Тэгэхээрээ бид нар эдийн засгийн хувьд яаж энэ бодлогыг тогтвортой эдийн засаг 6-8 хувьтай байх вэ. Яаж инфляц нэг оронтой тоонд тогтвортой байх вэ. Яаж бид нар импортыг орлуулж өөрсдөө аж үйлдвэржилтээ дэмжих вэ. Яаж бид нар экспортоо зөвхөн энэ 4

бүтээгдэхүүн биш уул уурхайн бусад экспортоо дэмжиж, үүнийг баланстай байлгах вэ гэдэг л бидний гол зорилт.

Өнөөдөр бид нар шинэ сэргэлтийн бодлого бас хэрэгжсэнээр цар тахлын үед 2021, 2022 оны байдлыг авч үзвэл бас ч гэж энэ ахицтай. 43.5 их наяд 2021 онд байсан бол, өнөөдөр Дотоодын нийт бүтээгдэхүүн Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжиж эхэлснээр боомтууд сэргэж эхэлснээр энэ уул уурхайн далд эдийн засаг ил болж эхэлснээр 52.8 их наядад анх удаа хүрч байгаа юм. Нэг үгээр хэлбэл 40 литр ус маань 50 литрийн багтаамжтай болсон гэсэн үг. Энэ маань өөрөө экспортын орлогыг 9.2 тэрбум ам.доллаароос 12.5 тэрбум ам.долларт хүргэх ийм боломжийг бүрдүүлсэн. Нэг үгээр хэлбэл экспортын орлого 12.5 тэрбум ам.долларт хүрсэн гэсэн үг. Яах вэ харамсалтай нь эдийн засаг цар тахлын үед -4, -5 хувьтай удчихсан учраас энэ сэргэлт иргэдэд шууд мэдрэгдэхгүй байна гэсэн үг. Юутай ч өсөлтийн энэ график бол явж байна гэсэн үг.

Боомтууд сэргэсэнээр нүүрсний экспорт 16.1 сая тонноос 31.8 сая тоннд хүрсэн байна. Энэ бол бас 1 жилийн дотор чамлахааргүй амжилт. Төсвийн орлого 18.6 их наяд болж бидний төсөвлөснөөс 1 их наядад давж биелж байна гэсэн үг. Тэгэхээр одоо бид нар энэ дээрээ бас тодотгол хийх үү эсвэл төсвөө сайжруулаад явах уу гэдгийг парламент бас хамтдаа шийдвэрлэх ёстой болж байгаа. Засгийн газрын өр 5.8 их наядтай холбоотой бас энэ өрийн бусад зохицуулалтуудыг бол өнгөрсөн хугацаанд бидний хувьд бол хийлээ.

Тэгэхээр өнөөдрийн байдлаар ингээд макро эдийн засаг бол ингээд тэнцвэржиж байна. Одоо гагцхүү бид нар яаж энэ тэнцвэрийг хангаж байгаа өнөөдрийн амжилтыг 10 жилийн хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх вэ гэдэг л бидний хамгийн том сорилт болж байгаа юм. Тэгэхээр бодлого тогтворгүй ингээд л янз бүрийн концепц гаргаж

тавиад л яваад байхлаар бидний хувьд бол энэ боломжоо л ингээд алдаад байдаг. Тэгэхээр ерөөсөө өнөөдрийн энэ сонгуулийн тогтолцооны бас нэг гол зүйл бол бодлого илүү тогтвортой байх, илүү хамтарч энэ асуудлыг шийдвэрлэх. Одоо байгаа 2023 онд 5 мянган ам.долларт хүрч байгаа үр дүнг яаж бид нар маш богино хугацаанд 10 мянган ам.долларт хүргэх вэ. 10 мянган ам.долларт хэрвээ хүрчихвэл 1950-аад оны Солонгос, 1960-аад он, 1970-аад он руу шилжих яг энэ шилжилтийн үе ерөөсөө л 10 мянган ам.доллар бол нэг үгээр хэлбэл тухайн улс орны хөгжлийн суурь өөрчлөлтийн эхлэл цэг байсан. 10 мянган ам.доллар. Сингапур яг тийм байсан. Япон ч гэсэн 2 том нам нь бүр нэгдэж энэ асуудлыг хийхийг л хүссэн шүү дээ. Ер нь бол түүх нь өөрөө тийм. Либерал Ардчилсан нам өнөөдөр ингээд яг л Японы тухайн үеийн хүндрэлийг олж хараад, энэ асуудлын төлөөлөл хэдүүлээ хамтдаа нэгдье бусад жижиг сажиг улс төрийн асуудлуудыг бүгдэнг нь хойш нь тавья гэдэг л итгэл үнэмшилтэйгээр нэгдсэн. Ингээд эдийн засгаа 20, 30 дахин тэлж чадсан. Тэгэхээр өнөөдөр бид нар 30 жил ингээд явчихлаа. 30 жил зөндөө маргалдлаа. 30 жилээр зөндөө бие биеэ өөнтөгчилж харлаа. Одоо энэ бүх асуудлуудаа бидний хувьд засаад, үнэхээр алдаа оноотой байсан асуудлууд байвал түүнийгээ засаад, одоо бид яаж маш богино хугацаанд 5 мянган ам.долларын өнөөдрийн амжилтыг 10 мянган ам.долларт 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг өсгөх вэ. Яаж өнөөдрийн 50 их наядын эдийн засгийн багтаамжийг 120-180 их наяд болгох вэ. Энэ л бидний ерөөсөө хамтын гол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж байгаа гол агуулга гэж ойлгож болно. Түрүүн бас Бат-Амгалан гишүүн хөндөж байсан. Хэрвээ зүгээр сонгууль бодсон бол энийг хийх бол эрх барьж байгаа намын толгойлж байгаа хүний хувьд бол надад бол маш утгагүй зүйл хийж байгаа шүү дээ би. Нэг үгээр хэлбэл ялсаар ирсэн тоглоомын дүрмээсээ өөрийн хүсэл эрмэлзлээр татгалзана гэдэг бол. Гэхдээ надад ялалтаас

илүүтэйгээр хамтарч ажиллаад энэ 10 мянган ам.долларт хүргэх энэ зорилго л илүү чухал байгаа юм. Ингэж байж иргэд парламентын ардчилалд илүү итгэх итгэл нэмэгдэнэ. Ингэж байж бид нар Ардчилал, тусгаар тогтнол болон бусад асуудлуудаа хийж чадна.

Тийм учраас би гэдгээсээ хойшоо алхаад, бид гэдэг рүүгээ хараад, жижиг сажиг гомдол, тэмцэл, бүх зүйлүүдээ бидний хувьд хойш нь тавиад ерөөсөө л улсаараа бид нар дотоодын нийт бүтээгдэхүүнээ 10 мянган ам.долларт 1 хүнд хүргэе. Ингэхийн тулд бид нар яах вэ. Хувийн хэвшил нь яах вэ, хөрөнгө оруулагчид нь яах вэ, ямар орчин байх вэ. Ганцхан жилийн дотор бид нар -4 хувьтай байсан эдийн засгийг +7 хувь руу авчирч болж байна. Бид нар заавал 1940 он, 1950 онд 10 мянган ам.долларт хүрэх албагүй. Бид нар хүсвэл энийг 3-4 жилийн дотор хийж болно. 3-4 жилийн дотор хийж болно. Гагцхүү бид нар ийшээгээ төвлөрөх хэрэгтэй. Бусад маргаанаа хойш тавиад явах. Энэ агуулгаараа л энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол чухал гэж л бод.../минут дуусав/

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ 76 гэдэг тоо яаж бүтсэн юм бэ гээд би бас харж байсан юм. Ер нь Бага хурал тэр үед 1990 онд 53 хүнтэй. 99 байх уу, 120 байх уу гэж байгаад л хамгийн дунд талын тоо нь 76 гээд л бүтсэн юм байна лээ шүү дээ. Тэр үед тэгж 1 их айхтар куб язгуурын арга ч гэж бодоогүй л байх. Тэгээд энэ тоог бол хөдөлгөх ёстой, үгүй гэдэг дээр гишүүд янз янзын байр сууриа хэлээд байх шиг байна. Энийг бол жоохон нэмэх ёстой. Тэгээд хэд байх вэ гэдэг асуудал байгаа. Тэгээд энэ Үндсэн хууль дотор гадаад үг байна уу. Энэ төсөл дээр 2 ч үг оруулаад ирэх юм. Надад хэлээд өгөөч. Энийг Монгол үг болгож болох уу. Энэ өргөн барьсан төсөл дээр гадаад үг л бичээд байгаа юм. Монголын бүх хууль монгол хэлтэй, үүгээрээ л явах

ёстой гэж бодох юм. Орчуулагддаг л үгнүүд байгаа.

Энэ тогтолцоо өөрөө давуу, сул олон талтай. Манай Их хурал чинь өөрөө харьцангуй өндөр эрх мэдэл бүхий улсуудын тоонд орж байгаа шүү дээ. Тэгээд 2009 оны тэр Кембриджийн судалгаагаар гэхэд Итали, Германтай тэнцэхүйц. Тэгээд энэ эрх мэдэл өнөөдөр яг хаашаа замхарчихсан бэ гэхээр 8 сарын 15-нд тэр давхар дээл зөвшөөрсөн Цэцийн тогтоол, үүгээр замхраад алга болсон. Энэ 20 сайд, 19 сайдын гарт орсон. Одоо энэ сайд нар өнөөдөр байр суурь, танхимын зарчим нь алдагдаад Их Хурал дээр орж ирж юм ярьдаг. Бие биеийнхээ эсрэг. Эд нарыг дагаж тойрч хамгаалж явдаг бүр өөрийн гэсэн 9, 10 гишүүдтэй болчихсон. Тэгээд Их Хурлын хяналт гэдэг юм чинь энэ дотор алга болчихож байгаа байхгүй юу. Яагаад энэ сүүлийн үед Засгийн газраас, Байнгын хороодоос ингэж их чиглэл өгсөн тогтоолууд гараад байгаа юм Засгийн газар руу. Тэгээд тэрний хэрэгжилт хаана байгаа юм. 0. Энэ чинь ерөөсөө л нөгөө гишүүдээрээ дамжуулж юм хийгээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ давхар дээл гэдэг чинь өөрөө яг өнөөдөр би бол өнөөдрийн амьдралд байгаа зовлонг л ярьж байгаа юм шүү. Давхар дээл гэдэг чинь өөрөө энэ Их Хурлын чинь эрх мэдлийг үгүй болгосон. Тэгэхээр энэ Их Хурлын хяналтыг нь сайжруулахын тулд тооны асуудал зайлиггүй гарах ёстой. Энийг гаргахгүй бол болохгүй. Дан дээлтэй байхад бас зовлон байсан. Сайд нар нь асуудлаа оруулж ирдэггүй. Энийг нь дагаад Их Хурлаас маш олон тооны ажлын хэсгүүд гарч Засгийн газрын ажил руу оролцдог болсон байсан. Энэ бид нарын өнөөдөрт байгаа зовлон маргааш энэнээс ч илүү томорч магадгүй энэ их зовлонг л давахын тулд бид нар энэ рүү явах ёстой л гэж хараад байгаа юм.

Дан мажоритар гэдэг юм уу, тойргоос сонгогдсон асуудал чинь сүүлдээ бол 21 улс болгочихсон. Монгол Улсыг хөрөнгө оруулалтын төсвийг нь. Тэгээд энэ 21 улс чинь хэрвээ нэгдсэн 1

бодлогоор тэр бол тогтолцоо нь өөрөө хүссэн, хүсээгүй тойрог руугаа мөнгө, хөрөнгө оруулалт татахаас өөр аргагүй. Хэрвээ тийм биш байсан бол бид нар өнөөдөр цалин, тэтгэврээ нэмчихсэн, татвараа 5 хувь болгочихсон ийм бодлогын юмыг бол хийх боломж байсан. Тогтолцоо чинь өөрөө энэ рүү үүний эсрэг учраас яагаад ч ийм байдлыг бий болгож чадахгүй. Тийм учраас энэ тогтолцоо дээр бол би бол 100 хувь дэмжиж байгаа. Тогтолцоо дээр. Энэ тогтолцоо ингээд явахаар өөрөө энэ тогтолцоонд бас нэг сул талууд байгаа. Засгийн газрыг олон намууд хамтарч бий болгоно. Засгийн газрын гишүүдийн тоо өсөх магадлал бас ихтэй болов уу гэж бодож байгаа би.

2012 онд яг энэ холимог тогтолцоогоороо явахад 4 нам нийлж засаг байгуулж байсан. Ардчилсан нам, Шударга ёс эвсэлд орсон 2, 3 нам нийлээд. Одоо энэ тэгээд тоо нэмэхээр босго энэ хэрээр яг өнөөдрийн байгаа сонгуулийн өргөн барьчихсан байгаа төслөөр ингээд явахаар бол 7, 8 нам орж ирж, засагт хамтарна гэж юм ярих вий дээ. Тэр үед л хамгийн их зовлонг бид эдэлнэ дээ. Энэ төр эдэлнэ. Явж явж тэрийг чинь энэ хууль гацаахгүй, хуулийг нь хүн гацаана. 2012 онд яг засаг байгуулагдах үед Ардчилсан намынхан сандаглах Батбаяр гишүүн орж ирээд өөрсдийнхөө яг фракцын гишүүдийн картыг хармаалчхаад ороогүй шүү дээ. Гэх мэтчилнээр ийм юмнууд үүсэж байсан бодит харж байсан нь. Тэгээд тэр үед бас энэ Засгийн газрын гишүүдийн тоо нэмэгдэх нэг юм гарах талтай, нөгөө талдаа Засгийн газар байгуулагдахад бас зовлон учрах вий гэсэн ийм болгоомжлол байна. Энэ төлөөллийн хувьд маш зөв л дөө. Чинбүрэн гишүүн, олон ч гишүүн төлөөлөл ярьж байна. Манайх чинь энэ пропорционалиар Нямаагийн Энхболд гишүүн бол санаж л байгаа байх. Пропорционалиар явж байхад малчны төлөөлөл байя гээд л, барилгачны төлөөлөл байя гээд л Баянхонгор аймгийн нэг барилгачин Искра ч билүү,

цэргийнхний төлөөлөл байя гээд Өвөрхангайн Дивизийн захирагчийг ч гэдэг юм уу, эмч байя гээд Говь-Алтайгаас Зуунаа гэж хүнийг оруулъя гээд ингээд л гэх мэтчилнээр ингээд төлөөллүүдийг нь л хангаж л байсан юм. Энэ нь бол бас яг өнөөдрийн амьдралд нийцсэн, зохицсон тийм шийдвэрүүдийг гаргахад бас аль аль талдаа үгүйсгэх нь бас хэрэгтэй л байсан байх. Энийг бол зайлшгүй бас харгалзан үзэх ёстой юм болов уу гэхдээ өнөөдөр энэ Үндсэн хууль дээр яригдах биш. Намын сүүлийн Их Хурлын сонгуулийн хууль дээр яригдах намын бодлого, намынх нь өөрийнх нь улс төрийн бодлогын л асуудал болж таарах болов уу гэж бодож байна.

Ер нь бол яах вэ. Энийг дагаад бас нэг юм энэ шашины нам ч гэдэг юм уу, энэ пропорциональ их өндөр хувьтай орж ирэхээр шашины нам ч гэдэг юм уу, бусад ийм янз бүрийн бүлэглэлийн намууд үүсэх магадлал бас өөрөө сөрөг тал болж хувирах вий гэж болгоомжлол бас байдаг юм. Энийг бол бас үгүйсгэх арга байхгүй. Хорих арга байхгүй. Хуулийн дагуу байгуулагдаад ороод ирэхэд бол боль гэх боломж бол бас тэр бүр байдаггүй. Тэгэхээр энийг бас тооцож л байх ёстой болов уу л гэж харах юм.

Ер нь бол хөрөнгө оруулалтын бодлого жоохон ингээж сарнисан бодлого өөрөө энэ улс орныг өнөөдрийн байдалд, яг ийм байдалд хүргэж байгаа нь бол үнэн л дээ. Монгол улсыг нэг айл гэх юм бол 21 хуваагаад хаячихаар чинь энд Спортын ордон барина. Спортын заал барина гээд байдаг. Нөгөө газар нь эмнэлэг байхгүй байна шүү дээ. Өнөөдөр бид нар энэ Хавдрын эмнэлэг, бусад 3 дахь шатлалын том эмнэлгүүдийнхээ очер дарааллыг хар. Тэнд Соёлын төв биш энд эмнэлэг нь хэрэгтэй байгаа учраас, тэгээд тэнд Соёлын төв барих сонирхол нь сонгогдсон гишүүнд нь байгаа учраас тэрний төлөө явахаас өөр арга байхгүй. Тийм тогтолцоог бол хөдөлгөхөөс өөр аргагүй юм болов уу л гэж харж байгаа юм. Ийм зүйлүүд, асуулт бол алга байна. Энэ төсөл дээр

байгаа тэр 2 гадаад үгээ Монгол үг болгож болох байх. Тэрийгээ тэгж янзлахгүй бол Үндсэн хууль дотор ингээж гадаад үг бичмээргүй байх юм.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

Л.Оюун-Эрдэнэ: Яах вэ энэ нөгөө пропорциональ, мажоритар гээд үгэн дээр зүгээр яагаад ингээд оруулчихсан юм бэ гэдэг тайлбарыг бас хэлчих нь зүйтэй байх. Энийг Их Хурал руу оруулж ирэхэд нөгөө хувь тэнцүүлсэн эсвэл олонхын зарчмаар шууд сонгох эд нар гэхээр аль нь ч яг нөгөө пропорциональ, мажоритар гээд яг энэ тогтолцооныхоо бүтэн агуулгыг илэрхийлэхэд ийм маргаантай байгаад байсан юм. Тийм учраас энийг өөр байдлаар ойлгогдохгүй агуулгаар оруулж ирье. Тэгээд парламент дээр хэлэлцээд яг аль үгээрээ авч үзээд батлах нь бол парламентын бүрэн эрхийн асуудал юм гэж Засгийн газар дээр бол ярьсан юм. Тэгэхгүй бол одоо жишээлбэл пропорционалийн хувь тэнцүүлсэн гэх үү, олонхын зарчмаар гэх үү гэхээр маргаантай л юм байна лээ л дээ. Онолын хувьд. Мажоритарыг бас тойргоос гэх үү, нутаг дэвсгэрийг төлөөлж гэх үү гэхээр бас их олон агуулгатай учраас аваад ингээд явчих нь зүйтэй юм гэж үзсэн. Мэдээж яг эцэслэн батлагдахад бол энэ бол яг энэ үг үсгээр бол орохгүй нь ойлгомжтой. Гэхдээ яах вэ Үндсэн хууль дээр прокурор гэдэг үгээс авхуулаад жишээлбэл бас шууд хэрэглэдэг ийм үгнүүд бол бас аль ч улс орны Үндсэн Хуульд бол байдаг юм байна лээ. Гэхдээ Раднаасэд гишүүний хэлдгээр энийг бол парламентын хэлэлцүүлгийн явцад Монголоор маш ойлгомжтой хэлбэрээр томъёолоод ингээд батлах нь зүйтэй гэдэг дээр бол Засгийн газрын хуралдаан дээр бид нар ярилцаж байх үед бол санал нэгдсэн. Энийг бас би нөгөө очиж тайлбарлахад гишүүдэд хэрэгтэй учраас бас яг энэ тайлбарыг нэг мөр болгоод хэлчихсэн нь зүйтэй болов уу гэж бодлоо.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Би өнөөдрийг болтол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлаар байр сууриа илэрхийлж, дэмжинэ, аль эсвэл дэмжихгүй гэж байр сууриа илэрхийлээгүй байгаа. Яагаад гэхээр бас хууль санаачлагчаас үндэслэлээ хэрхэн яаж тайлбарлаж байгаа юм бэ гэдгийг харъя гэж бодож ингэж ирсэн. Үндэслэл юмнуудыг сонслоо, дэмжих шалтаг шалтгаан байна. Бас болгоомжлол байна гэж ингэж харж байна. Өнөөдөр төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал, гүйцэтгэх засаглал Засгийн газрыг ард түмэн маань юу гэж харж байна вэ гэж. Юу гэж үнэлж байна вэ гэж. Ерөөсөө Улсын Их Хурлын гишүүн гэхээр бүх юмны эрх мэдэлтэй, их л эрх мэдлийн нэгдлийг хангадаг, хаана л бол хаана Их Хурлын гишүүн байж байдаг, хаана тендер, концесс байна тэнд орж байдаг, хаана зээл, урамшуулал байна тэндээс авч байдаг, хаана сул орон тоо гарч байна тэнд найз, нөхдөө шахаж байдаг ийм үйл ажиллагаанд өнгөрсөн хугацаанд орооцолдоод байсан учраас, ороод байсан учраас ард түмэн Их Хуралд итгэх, Засгийн газарт итгэх итгэл бас буурсан юм байна гэж би хувьдаа бол дүгнэж явдаг.

Уг нь бол Улсын Их Хурлын гишүүний тэр онцгой бүрэн эрх нь юунд байдаг юм бэ. Энэ их Төрийн ордон руу хяналт, шалгалтгүй орж ирдэг юм байна. Орж ирсэн хойноо энэ чуулганы танхимд суух эрхтэй юм байна. Суусан хойноо хэлэлцэж байгаа хуульд бага ард түмний, их ард түмний төлөөлж санал, бодол, үгээ хэлэх эрхтэй юм байна. Санал хураалтад оролцох эрхтэй юм байна. Нөгөө талаар орон байр, гэр орноо, нэр хүнд, алдар хүндээ хуулиар хамгаалуулдаг юм байна. Энэнээс өөр ямар эрх байх ёстой юм бэ. Энэ л үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж ажиллах ёстой. Гэтэл өнгөрсөн хугацаанд манай Төрийн өндөр албан тушаалтнууд, зөвхөн Их Хурлын гишүүд гэлтгүй Төрийн өндөр

албан тушаалтнууд үндсэн чиг үүргээсээ гажууд саяын хэлсэн зүйлүүдэд орооцолдож явсан учраас. Тийм учраас энэ эрх мэдлийг нь хязгаарлах гэж энэ удаагийн Их Хурал, Засгийн газрын тэргүүнүүд ул сууриар нь асуудалд хандаж, Төрийн өндөр албан тушаалтнууд аль болох саяын асуудлуудад орооцолдохгүй байхын тулд нэгд оны өмнө Эрүүгийн хуулиар ялын бодлогыг нь чангалаад өгсөн. 2-т өчигдөрхөн баталсан Ёс зүйн хуулийг батлаад өглөө. Өчигдөрхөн өргөн барьсан Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөө зохицуулах хуулийг бас өргөн барьж байна. Ингээд эхлэхээр энэ Төрийн өндөр албан тушаалтнууд ер нь цаашидаа зөвхөн хууль батлах, хууль хэлэлцэхэд үзэл бодлоо илэрхийлэхээс өөр зүйлд оролцох тэр бололцоо боломжийг ул сууриар нь хааж байгаа юм байна гэж би харж байна. Оролцуулахгүй байх тэр нүх сүвийг нь хааж байгаа юм байна гэж би харж байна. Тэгээд өөр ашиг, сонирхолтой. Ард түмний төрийн эрх ашгаас дээгүүр хувийн эрх ашгаа, тодорхой бүлгийн эрх ашгийг дээгүүр тавьдаг нөхдүүд цаашидаа ер нь тэр бизнесийнхээ зарчмаар гэдэг юм уу бусад тэр ашиг сонирхлоо хөөгөөд тусдаа яв гэдэг тийм үзэл бодолтой улсууд энд байх боломжгүй юм гэдгийг хязгаарлаж байгаа гэж би хувьдаа харж байна. Тийм учраас цаашидаа зөвхөн Их хурлын гишүүд гэлтгүй ер нь бол Төрийн өндөр албан тушаалтнууд үндсэн чиг үүргээсээ гадуур ажил хийвэл болохгүй шүү гэдгийг бүх талаар нь хааж байгаа юм байна гэж ингэж харж байна. Тийм учраас Их Хурлын гишүүдийн тэр эдлээд байгаа тэр үндсэн чиг үүргээс гадуур хөөцөлдөөд яваад байгаа, санаархаад яваад байгаа тэр эрх мэдлийг хязгаарлахын тулд энэ 76 гишүүн чинь 152 хурлын төлөөлөгч болж бараг үндсэндээ эрх мэдлийн тэр төвлөрөл гэдэг юм уу нөгөө талаар ажиллах бололцоо боломжийг нь эрс хязгаарлаж байгаа юм байна гэж би харж байна. Тэр үүднээсээ бас дэмжих шалтаг шалтгааны нэг нь энэ юм байна гэж.

Нөгөө талаасаа болгоомжлол нь бол 152 гишүүнтэй болсноор цаашидаа Улсын Их Хурлын шийдвэр гаргах чадамж ер нь хэр дээшлэх юм бол. 2 дахин нэмэгдэнэ л гэж байна энэ тоогоор. Яг амьдрал дээр яаж нэмэгдэх юм бол. Харин ч эсрэгээрээ шийдвэр гаргах, хууль батлахад хүндрэл үүсэх юм биш үү. Босго давж чадах уу, чадахгүй юу. Ийм асуудал бас эргэлзээ төрүүлж байна. Болгоомжлол төрүүлж байна. Тал тал тийшээ тархсан, бүлэг фракцад хуваагдсан, шантаа хийдэг ийм байдлаас болж шийдвэр гаргах энэ асуудал маань чадамж маань цаашидаа бас буурчих вий гэдэг ийм болгоомжлол байна. Энэ дээр та бүхэн бас юу гэж үзэж байгаа вэ.

3 дахь асуулт өнгөрсөн жил бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар бас ярьж хэлж явсан л даа. Нэлээд олон өөрчлөлтүүдийг хийж явсан. Хамгийн их санал авч байсан нь Төрийн сүлдийг өөрчлөх асуудал дээр хэлэлцүүлэгт оролцож байсан гишүүдийн бараг 90 гаруй хувь нь өөрчлөх нь зүйтэй, дэмжиж байна гэдэг санал өгч байсан. Монгол улс цаашидаа цаазын ялыг сэргээх асуудлыг олон иргэд бас дэмжиж байсан. Цаашилаад Үндсэн хуулийн Цэцийн асуудлыг хүртэл бас ярьж хөндөж байсан асуудал бол бий. Тэгээд олон асуудлуудыг ярьж байсан. Тэгээд өнөөдөр бол ганцхан гишүүдийн тоо, тогтолцооны асуудлыг оруулж ирж байгаа нь яаж байгаа юм бол. Ямар учиртай юм бол. Цаашидаа бас энэ дутуу хийгдсэн гэдэг юм уу, яригдаж байсан асуудлуудыг дараа нь ахиад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гээд дахиж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхгүй гэх баталгаа нь юу вэ. Ийм зүйлүүд дээр бас хариулт өгөөч гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Энэ авлига, албан тушаалын ашиг сонирхлоос ангид байж Улсын Их Хурал бол зөвхөн иргэдийн

төлөөлөх эрхийн ийм мандат юм гэдэг яг энэ агуулга руу энэ сонгодог Үндсэн хуулийн концепт руугаа бид нарын хувьд орох ийм алхам хийж байгаа нь бол үнэн. Энэ дээр манай парламентын гишүүд маань бас улс төрийн манлайлал үзүүлж бас энэ агуулгыг дэмжиж байгаад би үнэхээр талархаж байгаа. Тэгэхгүй бол 76 дарга, 76 төсвийн захирагч гэж ингээд ойлгоод удчихаж байгаа учраас иргэдийн хувьд гишүүдээс хүсэж байгаа зүйл нь ч гэсэн ийм бодлогын мэтгэлцээн гэхээс илүүтэйгээр тойрог дээрээ юуг шийдэж байна вэ, ямар хөрөнгө оруулалт тавиулж чадав гэдэг энэ агуулга руу нь илүү ханддаг болоод бас 30-аад жил өнгөрчихлөө. Нөгөө талаараа тойргоосоо хэнийг томилж байна, хэн хэн хүмүүсийг илүү нөлөөтэй болгож байна гэдэг энэ уралдаанд бас ороод 30 жил болчихлоо. Тэгэхээрээ манай Сандаг-Очир гишүүн өөрөө нийслэлийн төлөөлөгч байсан хүн маш зөв тодорхойлж байна. 76 даргаас 152 иргэний төлөөлөгч рүү шилжих эрх мэдлийн задрал тогтолцооны реформ гэж ойлгож болно. Мэдээж энэ хийхэд тийм амар биш.

Гэхдээ хийснээрээ парламентын гишүүдийн тоо хэд байх, парламентын гишүүдээс хүсэж байгаа зүйл ямар байх гэдэг энэ агуулга өөрөө сонгогчдын болон нийгмийн сэтгэл зүйд өөрөө өөрчлөгдөнө, өөрөө өөрчлөгдөнө. Ганцхан гүйцэтгэх засаглалтай, ганцхан хууль тогтоох засаглалтай, ганцхан шүүх засаглалтай л байх ёстой бид нар. Хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглалын ажил руу хутгалдаж орсноороо сайн зүйлийг бид нарын хувьд хийж чадах баталгаа бол биш. Зураг төсөвгүй, тооцоо судалгаагүй олон олон асуудлыг бид нар тойргийн хөрөнгө оруулалт нэрээр төсөв болгон дээр хувааж авч, жижиглэж шийддэг. 2 талтай л асуудал. Яагаад гэхээр энийг бид нар тогтолцооны хувьд өөрчлөхгүй болохоор гишүүдийн бас буруу гэж үзэхэд аргагүй. Яагаад гэхээр очоод л энэ л асуудлыг асуудаг, энэ л асуудлыг шийдэхийн төлөө байдаг. Гэхдээ бид нар ингэж яваад их өгөгдөл дээр

тулгуурлаад, хиймэл оюун ухаанаар төлөвлөлт хийдэг болчихсон энэ улс орнуудтай яг ийм байдлаар бид нар хөгжлөөрөө бол уралдаж чадахгүй. Манай улсын төсвийн байдал, эдийн засгийн байдал хүрэхгүй. Тэгэхээр бидний хувьд хамгийн чухал асуудлуудаа эрэмбэлээд хөгжлийн цогц нэгдсэн бодлоготойгоор л асуудалд хандаж байж энэ бүх асуудлуудыг шийдвэрлэх ийм боломжтой юм гэж. Тэгэхээрээ энэ бол энэ агуулга талаас нь.

Давхар дээлтэй холбоотой асуудал. Сонгодог парламентын засаглалтай аль ч улсад Их Хурлын гишүүд сонгогдох тусмаа үнэлэгддэг үнэлэмж нь дээшилдэг нь бол аль ч улсын парламентын засаглалын үнэт зүйл. Тэгэхгүй Засгийн газрын гишүүн байж байгаад дадлага хийж парламентдаа ордог байх энэ тогтолцоо бол цаашаа дахиж хөндмөөргүй юм байна лээ. Энийг би аль аль талд нь одоо Ерөнхий сайдаар ажиллаж үзсэн хүний хувьд аль аль Засгийн газарт нь, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан хүний хувьд хэзээ ч дахиж битгий энэ Их Хурлын гишүүдийн сайд байх эрхийг хязгаарлаасай гэж үнэхээр бодохгүй байгаа. Энэ бол зүгээр гэнэн романтизм юм байна лээ. Энэ бол Монгол Улсын хөгжлийг маш их хэмжээгээр хойш татах хэмжээний гэнэн романтизм. Тэгэхээрээ бидний хувьд мэдээж төлөөлөл хяналт тэмцлийн асуудал сая Раднаасэд гишүүний хөндөж байгаа асуудал байвал бид нар зохих хэмжээндээ тоогоо нэмээд үнэхээр Засгийн газар дээр нэмэгдэх ийм хандлага байвал харин тэдээс илүүгүй түвшинд Засгийн газрын сайд нар төлөөлөл чадамжтай байна гэж нөгөө талаас нь хязгаарлаж өгөх энэ боломжийг бол гаргах нь зүйтэй юм байна лээ. Мэдээж мэргэжил болон бусад асуудлаараа заавал жишээлбэл бүгд гишүүн байх ёстой биш. Энийг бол тэгээд л тухайн үед Ерөнхий сайд өөрөө нөхцөл байдалдаа тохируулаад л явах нь зүйтэй юм байна лээ. Тэгэхгүй ингээд хүчээр хязгаарлана гэдэг бол өөрөө их тийм буруу жишиг юм гэдэг энэ

агуулгаараа хандах нь зүйтэй болов уу гэж бодож байгаа.

Сайнаас илүү саар зүйлүүдээ ярих нь зүйтэй гэдэг дээр би бас санал нэг байна. Энэ дээр манай парламентын гишүүд, иргэдийн маань хувьд ч гэсэн, манай судлаачдын хувьд ч гэсэн олон талаас нь бид нар шүүн хэлэлцэх ёстой. Үнэхээр бодитой Засгийн газар ихэнх тохиолдолд хамтарсан Засгийн газар болох магадлал бол үлэмж хэмжээгээр өндөрсөнө. Хамтарсан Засгийн газар байна гэдэг бол сайн ч талтай, саарч талтай зүйл. Зөвшилцөл бас нэлээдгүй хэмжээгээр нэмэгдэнэ. Гэхдээ энэ зөвшилцөх боломжийг шантай болгож хувиргавал энэ өөрөө төрийн хэвийн ажиллагаанд бас нөлөөлөх хэмжээнд асуудал үүснэ. Асуудал үүснэ. Намын жагсаалтыг бид нар нийгмийн сегмент бүрийн төлөөллийг оруулах боломж гэж харвал энэ маш зөв зүйл болно. Иргэд, олон нийт дэмжинэ. Энийг эрх мэдэлтэй хүмүүс юм уу эсвэл аль нэг компанийн захирлуудад тохироод худалдчихвал энэ өөрөө гамшиг болж хувирна. Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг бид нар бусад салбарын хуулиар Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн Сонгуулийн тухай хуулиар бол энийг хязгаарлаж, нэлээдгүй тийм адаглаад төлөвших хүртэлх хэмжээний дараагийн 2-3 сонгуульд бол энэ асуудлуудыг бидний хувьд бол шийдвэрлэх нь зүйтэй. Дахиад хэлэхэд эрт орой хэзээ нэгэн цагт энэ асуудал зайлиггүй яригдана. Өөр зам байхгүй. 10 жилийн дараа ярьж болно. 20 жилийн дараа ярьж болно.

Гэхдээ бид нар аль болохоор наана ярих тусам л цаг хугацаа хожно. Энэ агуулга дээрээ л бид нар нэгдэх нь зүйтэй болов уу. Пропорциональ төлөөлөл 30 хувь байж болно, 40 хувь байж болно, 50 хувь байж болно. Энэ нээлттэй асуудал. Гэхдээ 50/50 байх нь манай улс оронд өргөн уудам газар нутагтай, цөөн хүн амтай манай улсын хувьд бас нийгмийн сегментүүд олон байдаг манай улсын хувьд 50/50 байх нь хамгийн зөв гарц. 76/76 гэдэг хувилбарыг түрүүн

Цогтгэрэл гишүүн бас хөндөж асуусан. Энэ одоо байгаа тойргийн мандатын системийг хөндөхгүй байх. Тэгээд төлөөллөө 50/50 байлгах гэдэг агуулгаар л 152 гэдэг тоо гараад ирж байгаа юм. Тэгэхээр энийг хэдүүлээ тэгээд ярилцаад тоо 152 байх юм уу, олон бэлгэдлийн тэр тоонуудаа ашиглах юм уу. Энэ бол тэгээд л бас манай парламентын гишүүдийн бүрэн эрхийн л асуудал шүү дээ. Тийм ээ. Тэгэхлээр энэ асуудлуудаа ярилцаад явах нь зүйтэй.

Зүгээр би Сандаг-Очир гишүүний бас асуултад ингээд өчигдөр бид нар Нийтийн албаны ашиг сонирхлыг нь урьдчилан сэргийлэх хуулийг баталлаа. Төрийн албаны ёс зүйн хуулийг баталлаа. Одоо Төрийн өмчит компаниуд болон төрийн энэ бүтэц дээр бид нар реформ хийчихвэл аяндаа энд зөвхөн төлөөлөхийн төлөө л хүмүүс орж ирнэ. Нийтийн сайн сайхны төлөө. Бусад бүх боломжуудыг бидний хувьд илүү шилэн болгоод, хаагаад ингээд л бусад улстай адилхан ийм сайн засаглалтай л болгочих хэрэгтэй. Энэ тохиолдолд Баттөмөр гишүүний хэлж байгаагаар эдийн засгийн маш тийм үсрэнгүй хөгжил бол бас ирэх бодлого тогтвортой байх ийм боломж бол бас үүснэ. Мэдээж аль ч тогтолцоо төгс биш. Давуу болон сул тал 50/50 хувь аль аль тогтолцоонд нь байгаа. Энийгээ бид нар хүлээн зөвшөөрөөд, аль болохоор эрсдэлээс хаагаад. Гэхдээ бүх юмыг заавал болохгүй гэдэг өнцгөөс биш болох гэдэг өнцгөөс хэдүүлээ хараад, тэрийгээ бусад органик хуулиудаараа зохицуулалт хийгээд явах нь бол зүйтэй болов уу л гэсэн ийм агуулгаар хандаж байгаа юм.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Би нэг үг хэлээдэхье гэж бодож байна. Өөрөөр хэлэх юм бол Зөвлөлдөх санал асуулгын зарчмаар бас Зөвлөлдөх зөвлөлд оролцож үгээ хэлсэн. Санал, асуулгад оролцож саналаа ирүүлсэн. Нийтдээ 5 мянга гаруй саналаар 33,900 гаруй

саналаа ирүүлсэн 6 мянга орчим сонгогч, Монгол Улсын нийт ард иргэдийн төлөөлөл болсон иргэддээ бас баярлалаагаа хэлэх гэсэн юм. Өөрөөр хэлэх юм бол төрийн эрх барих эрхээ эдлэх тэр боломжийг нээх, илүү их иргэдийн төлөөлөл болох тэр боломжийг нээж өгөх энэ санал хураалтад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд бас саналаа өгсөн иргэддээ, иргэний нийгмийн байгууллагадаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх байгууллага болон зохион байгуулагдсан ажлын хэсгийн хамт олондоо бас талархлаа илэрхийлье. Яагаад ингэж би хэлээд байна вэ гэвэл одоо бас гишүүд өөрсдөө тойргоор явж, сонгогчдынхоо үгийг сонсох, саналыг нь авах энэ ажлыг хийх гэж байгаа энэ цаг мөчид сонгогчид маань бас бидэнд үгээ хэлж, өөрсдийнхөө үзэл бодлыг илэрхийлж, Үндсэн хуульд оруулах энэ өөрчлөлтөд өөрийнхөө эрх, үүргийн дагуу бас оролцоорой гэдэг ийм уриалгыг хэлэхийг хүссэн юм.

2 дугаарт нь би Улсын Их Хурлын гишүүн болчихоод 2021 оны төсөв батлагдах тэр цаг мөчид төсвийн ажлын хэсэгт ороод зөвхөн тойргоо яриад байх юм улсаа 1 тойрог гэж хараач, улсынхаа хөгжлийг яривал яасан юм бэ гэдэг саналыг илэрхийлж байсан. Одоо ийнхүү Үндсэн хуульд өөрчлөлт орсноороо улс нэг тойрог болж, улсынхаа хөгжлийг харах тэр боломж бас нээгдэж байна гэдэгт бас талархалтай байгаагаа хэлэхийг хүссэн юм.

2 дугаарт үнэхээр 1992 онд шинэ Ардчилсан Үндсэн хуулиар Монгол Улс парламентын засаглалаа тогтоож, 8 удаагийн бүрэн эрхийн хугацаандаа 76 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулснаар өнөөдрийг хүрч байгаа. Өнөөдөр бид нар 76 байх уу, 152 байх уу. Яаж сонгогч түмнийхээ саналыг гээхгүй байх вэ. Ард түмний төлөөлөл нь яаж хүчирхэг байх вэ. Иргэндээ ойртсон, сонгогчдоо ойртсон тэр үйл ажиллагааг хэрхэн яаж явуулах вэ. Сонгогч иргэдийнхээ эрхийг хэрхэн яаж хамгаалах

вэ гэдэг энэ өөрчлөлтийг хийхээр санал хураалт явагдаж байна. Хүчтэй сөрөг хүчинтэй байх, холимог тогтолцоонд шилжих, жендерийн тэгш байдлыг хангах, нийгмийн бүхий л давхарга төлөөллийг бий болгох бүрэн боломж нээгдэж байна гэж харж байгаа. Өөрөөр хэлэх юм бол хүчтэй сөрөг хүчин дутагдсанаар бид бас үйл ажиллагаагаа эрчимжүүлэх тэр хүч дутагдаж байна уу гэж харж байгаа. Тэгвэл үнэхээр энэ боломжийг бас бий болгох хүчтэй сөрөг хүчинтэй байж хөгжлийн төлөө, зөв нийгмийн төлөө эрчтэй ажиллах тэр боломж бас нээгдэх юм болов уу гэж харж байгаа. 1992 оны батлагдсан Үндсэн хууль байгуулагдсан парламент бас маш энгийн төлөөллүүдийг бүх ард түмний төлөөллийг оруулж чадаж байсан. Та бүхэн сайн санаж байгаа бол Чимэд гуайгаас авхуулаад Намхайнямбуу малчин, тэгээд Бавуугийн Лхагвасүрэн гуай, Нацагийн Жанцанноров гуай, Хурц геологич гээд. Ингээд бүхий л давхаргын төлөөллүүд оролцож байсан. Ганболд, Ганди гээд сэтгүүлч нар хүртэл энэ парламентад сууж байсан ийм түүх бидэнд байгаа. Үнэхээр зорилтот бүлгийн гэдэг юм уу, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ төлөөллийг оролцуулах энэ боломж бий болно гэж бид хуулиа харж байна. Тэгвэл хэрхэн яаж энэ төлөөллөө жагсаалтад оруулах вэ гэдгийг би тодруулах гэсэн юм. Өөрөөр хэлэх юм бол намд байгаа энэ төлөөллүүдээ бид жагсаалтад оруулах нь гэсэн энэ ойлголт байна. Өөрөөр хэлэх юм бол би маш энгийн асуултыг асууж байна. Жагсаалтаа 76 жагсах жагсаалтаа хэрхэн яаж энэ төлөөллөө оролцуулах вэ гэдэг ийм асуулт. Миний асуулт зөвхөн энэ парламентад байгаа нөхөд, ажлын хэсэг, Ерөнхий сайдаас, Засгийн газраас гадна нийт иргэддээ мэдээлэл өгөх гэж асууж байгаа шүү гэдгийг би дахиад хэлье ээ.

Сонгогчийн жагсаал санал гээгдэхгүй гэдэг ийм зорилт байгаа. Тэгвэл жагсаалтын оноо хүрэхгүй тохиолдолд хэрхэн сонгогчийн саналыг гээхгүй байх вэ. Нэг шилжүүлнэ гэсэн нэг

ийм юм байгаад байгаа шүү дээ. Сонгуулийн хуульдаа. Бид нар Сонгуулийн хууль, Улс төрийн намын тухай хууль гээд бас хэлэлцэх байгаа. Тэгэхээр энэ 2 асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Хүсвэл бид нар Улс төрийн намын тухай хууль дээр хуульчилж ч бас болно шүү дээ. Би сая хэллээ. Ардчилсан нам, ХҮН нам хэрвээ хүсвэл төлөвштөл нь ийм ийм байдлаар хязгаарлалт тогтооно гэдэг байдлаар бид нар санамж бичигт гарын үсэг зураад, тэгээд та хэд маань тойрог тойрог руугаа очоод иргэдтэйгээ уулзахдаа энэ тооноор хөөгөөд гаргачихсан нөхдүүд хаалгаар ороод ирлээ гээд энэ агуулга дээр ямар зохицуулалт байвал энэ асуудал дээр илүү их итгэл төрөх вэ гэдгийг бас та хэд маань уулзаж ярилцаад, хэлэлцүүлэг хийгээд магадгүй энэ чинь 40-өөд хоног үргэлжилнэ шүү дээ. 40-өөд хоног дундуур энэ жагсаалттай холбоотой асуудал дээр ямаршуу байдлаар яаж хандвал зүгээр вэ. Энийг салбарын хуулиудаар яаж зохицуулж болох вэ. Улс төрийн намын дүрмүүдээр яаж зохицуулж болох вэ. Энэ бүх байдал дээр бидний хувьд бол хамтарсан шийдэл гаргаж болно шүү дээ. Энэ бол Үндсэн хууль дээр бол ерөнхий л заалт орно. Бусад хууль дээр бид нарын хувьд илүү зохицуулаад ингээд явчихвал боломжтой. Зүгээр 1, 2 бүтэлгүй хүний гаргасан ганц 2 алдаанаас болоод Монгол Улсын нийт 30 жилийн боломж битгий алга болоосой л гэж бодож байна. Тэгэхээр энэ дээрээ улс төрийн намууд, улс төрчид маань илүү их хариуцлагатай байж шаардлагатай бол үүнийг хуульчилж, 4/25-ын зарчим байна ч гэдэг юм уу эсвэл 30/30/30 байх зарчим байна ч гэдэг юм уу эсвэл 50/50 байх зарчим байна ч гэдэг юм уу. Жагсаалтыг яаж эрэмбэлэх вэ энэ дээр яаж нийгмийн төлөөллийг хангах вэ гэдгийг илүү нарийвчилж бас өгч болно. Энэ бол нээлттэй асуудал. Үндсэн хууль

бол ерөнхий л зохицуулалт шүү дээ. Үндсэн хууль бол ерөнхий л чиг баримтлалыг хийнэ. Үндсэн хуульд бол нэг их нарийвчилсан зохицуулалтыг хийх нь бол өөрөө практик дээр хүндрэл гаргадаг юм гэдгийг бол бид нар бас өмнө нь ойлгосон.

Дээрээс нь яагаад Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой бусад асуудлуудыг оруулж ирэхгүй байгаа юм бэ гээд. Мааш их хэлэлцэх ёстой учраас оруулж ирэхгүй байгаа юм. Журмын тухай хуулийг миний хувьд Ерөнхий сайдаар ажиллаж байх хугацаандаа лав хөндүүлэхгүй. Тийм учраас 2019 онд мөн 5, 6 удаа хэлэлцэгдсэн энэ сонгуулийн тогтолцоо болон тоотой холбоотой асуудлыг л бид нар ярилцъя. Энэ нэг өгүүлбэр мөртөө энэний цаана мааш том агуулга нуугдаж байгаа. Мааш том агуулга нуугдаж байгаа. Тэгэхээрээ цаашидаа Үндсэн хуультай холбоотой олон удаа шүүн яригдсан энэ асуудлууд дээрээ л хэдүүлээ ярьж бага өөрчлөлтийг урт ярьж хийж байх нь энэ бол өөрөө Үндсэн хуулийнхаа легитимд бас ард иргэддээ илүү зөв ойлгуулах тал дээр улс төрийн намууд зөвшилцөх хугацааны хувьд Их Хурлын гишүүд бас хоорондоо мэтгэлцэж ярилцах боломжийн хувьд зөв болно. Зөв болно. Цаашидаа ч гэсэн бас бид нар өөрчлөлттэй холбоотой олон жил яригдсан асуудлуудыг яригдвал яг л ийм байдлаар бид нар их тийм урт хугацаанд хэлэлцэж байж, нийгэм бүтэн мэдээлэлтэй байх үед нь тэр дэмжлэгийг бид нарын хувьд авч ярилцаж, тайлбарлаж байж давуу болон сул талаа бид нарын хувьд тооцож байж, эрсдэлийг тооцож байж л шийдвэр гаргах нь бол зүйтэй юм гэж хэлэх нь зүйтэй болов уу.

Дахин хэлэхэд энэ бол Монгол Ардын намын санал гэхээс илүүтэйгээр энэ бол Ардчилсан нам болон манай бусад улс төрийн хүчнүүдийн олон жилийн хугацаанд дэвшүүлэн тавьж байсан ийм дэвшилттэй үзэл баримтлал юм. Энэ дэвшилттэй үзэл баримтлал дээр бид нар өөрт байгаа өнөөдрийн боломждоо

боломжийг нээхгүйгээр ингээд эс үйлдэл гаргаад суугаад байж яах юм бэ л гэдэг энэ шийдвэрээр л өнөөдрийн энэ хэлэлцүүлэг эхэлж байгаа гэж бас олон нийт маань ойлгох нь зүйтэй. Бид нарын хувьд бол зөвхөн ялах гэдэг агуулга бол биш. Бидний хувьд улс яаж урагшаа хурдтай хөгжих вэ, яаж илүү зөвшилцөх вэ, бусад улс төрийн намуудаа бид нар төлөвшихөд нь яаж бас дэмжлэг үзүүлэх вэ гэдэг бол бас хамтын нэг сорилт болчхож байгаа юм. Хамтын нэг сорилт болчхож байгаа юм. Бид нар хуваагдаж байсан. Бусад улс төрийн намуудад ийм эрсдэл битгий учраасай гээд бид нар чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Яагаад гэхээр мааш их цаг хугацаа өөрөө шаардагддаг юм байна лээ. Энэ агуулгаараа энэ асуултуудад хариулж байгаа юм гэдгийг хэлье. Мааш их баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн, Содномын Чинзориг, Гочоогийн Ганболд нарын урилгаар Чинзориг сайд суудалдаа суучихна уу та. Зочдоо хүлээж авах уу, авахгүй юу. Хурал үймүүлээд ингээд. Гочоогийн Ганболд даргын урилгаар Өвөрхангай аймгийн Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ард иргэдийгээ төлөөлж, сум орон нутгийнхаа хөгжлийн төлөө ажиллаж байгаа эрхэм хүндэт төлөөлөгчид та бүхний төр түмнээ төлөөлөх ариун үйлс, их ажилд чинь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөгөөд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж байгаа энэ цаг үед бас орж ирж, манай намын бүлгийн даргын олонхын бүлгийн даргын, тойргоос ирсэн төлөөлөгчдөдөө 3 гишүүн төлөөлөгчдийн нэрийн өмнөөс болон нийт гишүүдийн өмнөөс баяр хүргэж, халуун талархал дэвшүүлъя.

Даваажанцангийн Сарангэрэл
гишүүн асуулт асууна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Үдээс өмнөх Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай болон Сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийн талаар хэлэлцсэн. Энэ үеэр бол би Улсын Их Хурлын гишүүдийн тоог 152 болгохыг бас эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн. Энэ хувь гишүүний байр суурь гэхээсээ илүүтэй Хан-Уул дүүргийн 260 гаруй мянган хүнийг төлөөлж байгаа бас гишүүний хувьд тойргийнхоо иргэдийнхээ байр суурийг илэрхийлсэн хэрэг. Тэгээд өнөөдөр энэ хуулийн төслийг хэлэлцэж байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд эдгээр асуудлаар өөрийнхөө байр суурь болон энэ хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг нэлээн сайн тайлбарлалаа. Өөрөөр хэлэх юм бол энэ Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэх асуудал нь өөрөө парламентын бүрэн эрхийн асуудал. Ажлын хэсэг байгуулагдана. Тэгээд ярилцаад эндээс гол шийдлээ гаргах нь нээлттэй байгаа гэдэг асуудлыг ярьсан учраас энэ дээр айхтар тогтоож ярих ийм шаардлагагүй боллоо гэж.

2 дугаарт хэлэх гэж байгаа зүйл бол мөн иргэдийн саналыг л уламжилж байгаа хэрэг. Та түрүүн бас хэлсэн. Монгол Улс маань том газар нутагтай, 1.5 сая хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, ард иргэд маань энэ том газар нутагтаа тархан суудаг. Тийм учраас бол энэ тойрог төлөөлөх гишүүдийн тоог бууруулах тал дээр бол иргэд нэлээн тийм хатуу байр суурьтай байна лээ. Холимог тогтолцоог шүүмжилнэ гэхээсээ илүүтэй аль аль нь тэнцвэртэй байх нь өөрөө парламент ард түмнийг төлөөлөх ийм боломжийг бол бас нээж өгөх юм гэдэг ийм байр суурийг хэлсэн. Тийм учраас таны түрүүний хэлсэн ер нь энэ тэнцвэртэй байх 50/50 хувь байх нь өөрөө энэ хуулийн өөрчлөлтийн амин сүнс юм гэдгийг бол дэмжиж байгааг би бас энэ ташрамд илэрхийлж байна.

2 дугаарт хэлэх гэж байгаа зүйл бол энэ хуулийн өөрчлөлтөөр хэд хэдэн дэвшил гарч байгааг би илэрхийлэх гэсэн юм. Түрүүн Одонтуяа гишүүн маань бас хэлчихнэ лээ. Бид нар их олон жил энэ жендерийн тэгш байдлын асуудлыг ярьсан юм байгаа юм. Улсын Их Хурал дахь 13 эмэгтэй гишүүн ер нь олон хуулийн төсөл дээр ажилласан даа. Бид нар Хүүхдийн эрхийг хамгаалах, Хүүхэд хамгаалах, Чихрийн агууламж өндөртэй ундааны татварыг нэмэгдүүлэх, түүнээс гадна Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх, Жендерийн тэгш байдлыг хангах гээд олон асуудлыг бол бид нар ингээд хөндсөн. 3 гол асуудал дээр бид нар анхаарлаа төвлөрүүлж байгаа. Энэ нь өөрөө улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх. 3 гол асуудал буюу энэ жендерийн тэгш байдлыг хангах асуудлыг энэ хуулийн өөрчлөлтөөр оруулаад ирж байгаа нь бол би их том дэвшил гэж үзэж байгаа. Улсын Их Хуралд сууж байгаа 13 эмэгтэй гишүүн гэхээсээ илүүтэй Монголын хүн амын 51.3 хувийг эзэлж байгаа олон чадварлаг эмэгтэйчүүдийнхээ төлөөллийг оруулж ирэх тэр боломжийг энэ хуулийн өөрчлөлтөөр нээж байгааг бол бид нар талархан хүлээж авч байгаа. Нэгэнтээ бас байр сууриа илэрхийлэх цаг байгаа учраас би шууд холбоогүй ч гэсэн 2 зүйлээ хэлчихье.

Бид нар бол бас эмэгтэйчүүдийнхээ эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх гээд хуулийн төсөл санаачлаад, энийг парламент маань бас дэмжээд явж байгаад талархалтай байгаа.

3 дугаарт бидний гол анхаарал хандуулж байгаа зүйл бол эмэгтэйчүүдээ умайн хүзүүний хорт хавдрын улмаас алддаггүй байх. Тийм хууль, эрх зүйн орчныг санхүүжилттэй нь хамт бүрдүүлэх ийм боломжийн чиглэлд ажиллаад аль аль нь дэвшилттэй явна. Эрүүл мэндийн сайдтай уулзсан. Хуулийн төслийг удахгүй өргөн барина.

Санхүүжилтийн асуудал шийдэгдэнэ гэдэг ийм боломжийг бол бас хэлсэн байгааг би энэ таширамд олон нийтдээ мэдээлчихье гэж ингэж бодож байна.

4 дүгээрт хэлэх гэж байгаа санаа бол ард иргэдийн дунд бас үнэлгээ байна. Өнөөдрийн 76 гишүүнтэй Монголын парламент Монголын ард түмнийг төлөөлж чадаж байна уу гэж ард түмэн асуугаад, чадахгүй байна гэдэг хариултаа бодитоор өгчихсөн. Энийг та бид бүгдээрээ өөрсдөө мэдэж байгаа. Биднийг бол ер нь юу гэж нэрлэж байна гэвэл явцуу эрх ашигт автсан парламентын бүлэглэл гэдэг хүртэл ийм шүүмжлэл, нэр хочийг өгчхөөд байж байна. Энэ нь юу вэ гэх юм бол нөгөө л нүүрсний хулгай, ЖДҮ, Хөгжлийн банк, Төмөр зам гээд ийм олон асуудалтай холбоотойгоор 76 гишүүн 76-уулаа ийм хүнд байдалд орсон байгаа. Харин Засгийн газар энэ асуудал дээр нэлээн дорвитой арга хэмжээ авч, хар цагааныг нь ялгах гээд ажиллаж байгааг бол би бас талархан дэмжиж байгаа. Тэгэхээр энэ өөрчлөлтүүд өнөөдөр эцсийн эцэст нэг намын биш, цаашидаа Монголын парламентын дархлаа нэмэгдүүлэх, үндэсний аюулгүй байдлаа хамгаалах, улс төр геополитикийн үүднээсээ ч гэсэн ер нь энэ үйл ажиллагааг, энэ өөрчлөлтийг хийх цаг нь болсон юм байна гэдгийг өнөөдрийн хэлэлцүүлгээс ер нь гишүүд нэлээн сайн ойлгож авсан байх. Энд илэрхийлсэн гишүүдийн байр сууриас ард иргэд маань ч гэсэн ойлголт нь нэлээн жигдэрч байгаа болов уу гэж бодож байгаа.

Тэгэхдээ цаашидаа бид нар ард иргэдтэйгээ уулзаж, учирч энэ мэдээллээ өгч, ойлголтыг өгөх ёстой. Яагаад гэвэл Үндсэн хуулийн өөрчлөлт гэдэг бол парламентад суудалтай намуудын асуудал биш. Монголын бүх ард түмний оролцож, байр сууриа илэрхийлж, дийлэнх олонх нь хүлээн зөвшөөрсөн үед энэ хийгдэх ёстой ажил учраас энийг бол бид нар хийх ёстой гэж бодож байгаа. Тэр дундаа энэ өөрчлөлттэй холбоотой гишүүдийн тоог нэмэгдүүлэх, сонгуулийн

тогтолцооны өөрчлөлтийнхөө ач холбогдлыг манай ажлын хэсгийн түвшинд нэг бүрчлэн тодорхойлмоор байна. Би тухайлбал нэг гишүүний кнопын эрхийн асуудлыг хөндөхөөр би ичээд байгаа юм. Угаасаа тангараг өргөчихсөн ард түмэндээ үйлчлэх ёстой гишүүд маань олуулаа байхгүй байдал худалдагдах гээд байна. Эд нарын энэ кнопынх нь эрх мэдлийг ер нь бууруулахгүй бол болохгүй байна гэдэг ийм зүйл яриад сууж байна гэдэг бол бас л ичгэвтэр асуудал л даа. Тийм учраас бол цаашидаа энэ хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор тэр тойргоос ч бай, жагсаалтад ч бай ямар ч байсан дахин парламент ард түмнээ төлөөлж чадахгүй байна гэдэг шүүмжлэлд хүргэдэг ийм хүмүүсийг бас судалж, нэлээн нарийн шүүлтүүрээр бол нэр дэвшүүлэх нь цаашидаа дахин ийм нэр хочийг зүүхгүй Монголын парламентын нэр хүнд өнөөгийн түвшинд хүртэл унахгүй байх тэр боломжийг бол бүрдүүлнэ гэж ингэж бодож байгаа. Тэгээд миний хэлж байгаа энэ байр суурь дээр бас Ерөнхий сайдыг тодорхой тайлбарууд, ялангуяа өнөөдрийн энэ парламентын нэр хүндийг өдийг хүртэл нь унагахгүй байх тал дээр ямар арга хэмжээ авах вэ. Хуульд ямар заалтууд орно гэж бодож байгаа, хуулийн үр дүн нь өөрөө яаж гарах вэ гэдэг талаар таны байр суурийг сонсоод дараа нь тодруулга хийе. Баярлалаа.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Бид нар 1992 онд парламентын засаглалтай ийм ардчилсан тогтолцоо руу орсон. Маш их олон давуу талууд үүссэн, нээлттэй ярилцдаг болсон, асуудлыг олон талаас нь шүүн хэлэлцдэг болсон. Зүгээр яах вэ нэг шүүмжлэлтэй байгаа асуудал бол ерөөсөө л энэ Их Хурлын гишүүд эрх мэдлийн төвлөрөл болчхоод байна. Тендер, хээл хахуулийн хэрэгт холбогдоод байна. Бизнесийн лобби хийгээд байна. Тэгээд тэр мөнгөөрөө саналын эрх

худалдаж аваад байна. Томилгоо дээр лоббидож өөрийнхөө ойрхон хүмүүсийг томилоод байна. Энэ нь өөрөө засаглалын ажилд их тийм хүндрэлтэй нөхцөл байдал үүсгээд байна гэдэг л ийм л шүүмжлэл байгаа юм. Тэгэхээрээ гишүүд маань сайн дурын үндсэн дээр төлөөлнө гэж л ийм тангараг өргөсөн ийм л Үндсэн хуулийнхаа дагуу ажиллаж байгаа юм чинь мэдээж энэ парламентын бүх гишүүд биш нэг хэсэг хүмүүсийн харалган үйлдлээс болоод л парламентын нэр хүнд бас бүхэлдээ ийм түвшинд хүрч байгаа. Гэхдээ энэ бол сүүлийн 20-иод жил байнга л яригдаж байсан асуудал. Хураагдаж хураагдаж одоо бид нар ил тод дүгнэж ярьж байна гэдэг маань л өөрөө их тийм сайн зүйл. Тэгэхээр энийгээ бид нар ингээд шийдчихвэл Монголын ард түмэн бол парламентын засаглалдаа үргэлж итгэсээр л ирсэн. Парламентын засаглалаас бол Монголын ард түмэн татгалзахгүй. Монголын ард түмэн парламентын засаглалыг цаашидаа илүү төгөлдөржүүлэх ийм л хүсэл эрмэлзэлтэй байгаа. Тэгэхээрээ энэ цаг үед та бид хамтдаа ажиллаж байгаа энэ цаг хугацаа маань өөрөө өмнөх алдаа дээрээ бид нар дүгнэлт хийгээд, сургамж аваад цаашидаа бид нар төрт ёсныхоо парламентын засаглалынхаа нэр хүндийг өсгөх тал дээр дор бүрнээ л чадах бүх зүйлээ иргэдтэйгээ хамт хийх л ийм л асуудлууд байж байгаа юм. Мэдээж Эрдэнэтийн 49 хувиас авхуулаад л Хөгжлийн банк, тэгээд л нүүрсний хулгай гээд л олон л асуудлууд гарч ирлээ. Гэхдээ энийг гаргаж ирэхээс өөр аргагүй. Гаргаж ирээд л бидний хувьд энийг шийдвэрлээд л явна. Ийм асуудалд оролцсон хүмүүсээс болж парламент өөрөө хүндэрч болохгүй. Тийм учраас энэ асуудлууд ингээд шийдвэрлэгдээд л цаашаа явах байх. Дарга нар гэж бодоод байгаа учраас, эрх мэдэл төвлөрөөд байна гэж бодоод байгаа учраас миний төлөөлөл гэж харахгүй байгаад гол асуудал болчхоод байгаа юм. Ерөөсөө энийг л бид нар засах ёстой. Парламент хэрвээ төлөөлөл биш харагдаад эхэлбэл нэг аюултай зүйл бусад улсуудад бол үүсэж байсан юм байна лээ. Тэр нь бол

парламентын гадна талд тийм албан бус төлөөлөл үүсэх, хүлээн зөвшөөрөлтэй албан бус төлөөлөл үүсэх гэсэн үг. Одоо энэ цахим ертөнцөд жишээлбэл олон дагагчтай бас том том инфлюенсерүүд энийг үүсгэж байна гэж бас үзэж болно. Тэр бол зүй ёсны асуудал. Парламентаас илүү төлөөлөх чадамжийг хангаж байгаа ийм иргэний нийгмийн байгууллагууд ийм томоохон төлөөллүүд парламентын гадна талд байх. Энэ бол өөрөө төр тогтворгүй байх, нийгэм тогтворгүй байх, өнгөт хувьсгал гарах, гадна дотнын тусгай албадууд орж ирж зориуд өдөөх, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд халдсан ийм асуудал болоход бол туйлын ийм том эмзэг хөрс болдог. Тэгэхээрээ аль болохоор энэ төлөөллийн бүх зарчим парламент дотроо л асуудлыг шийдэж, хэлэлцэн мэтгэлцэх учиртай. Мэдээж яах вэ улс төрийн бусад олон намууд орж ирснээрээ парламентын мэтгэлцээний уур амьсгал бол ширүүснэ. Заримдаа зарим асуудлууд гацна. Завсарлага авна. Гэхдээ хуулиар зохицуулагдана, эгээр зохицуулагдана, журмаар зохицуулагдана. Ийм зохицуулалттай хэлэлцэж бид нар асуудлыг шийдэх нь хамаагүй илүү. Дүрэмгүйгээр, жагсаал цуглаанаар, магадгүй мөргөлдөөнөөр, зэвсэгт байдлаар хоорондоо ч илүү асуудлаа шийдэх ийм олон улсууд байна. Тэгэхлээр бид нар 1992 онд тайван замаар бас Ардчилсан тогтолцоо руу бид нар шилжиж чадсан. 30 жилийн дараа бид нар зарим нэг алдаа оноогоо засахыг иргэд маань гадаад талбай дээр жагсааж, мөн олон хэлбэрээр сэтгэл хангалуун биш байгаагаа илэрхийлж байна. Тийм учраас энийг ч гэсэн бид нар мэдэрч байгаа бол цаг алдалгүй засаад, илүү зөвшилцлийн илүү хүртээмжтэй ийм ардчиллын сонгодог парламентын засаглалын хэлбэрээр нь энэ нийгмийн инерцийг энэ хүчний албан бус төвлөрлийг бидний хувьд бол илаарьшуулах, илүү нийгэм цаашаагаа илүү зөвшилцлөөр тулгуурлаж асуудлуудаа шийдэх энэ зүйлийг хийх нь геополитикийн энэ нэн эгзэгтэй цаг үед, улс орон бүхэн аюулгүй байдлынхаа

стратегийг бас томоохон хэмжээнд гадаад бодлогоо эргэж харж байгаа энэ цаг үед, цар тахлын болон дайны хүндрэлтэй байгаа энэ цагаас сургамж авсны хувьд бид нар шийдчих нь дараа дараагийн сорилт дээр тухайн үед ажиллах парламентдаа, тухайн үед ажиллах Засгийн газартаа, тухайн үед ажиллах шүүх засаглалдаа илүү их тийм том боломжийг илүү их тийм шийдвэрлэх соёлыг үлдээж байгаа энэ цаг үеийн бидний үйлдэл юм. Эс үйлдэл хийгээд бид нар нийгмийн шүүмжлэлээс ч юм уу зайлсхийгээд, эсвэл яах вэ дээ гээд ийм байдлаар явчихвал өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа асуудал маань ирээдүйд үлдэнэ ээ л гэсэн үг. Дахиад л тэр үед яригдана. Тэр үед та нар тэгээд энийг мэдсээр байж байж хийхгүй яасан юм бэ гэдэг энэ зүйл түүхийн тавцан дээр тавигдана. Тэгэхээр энэ агуулгаараа хэдүүлээ түүхийн өмнө олон жилийн ярьсаар ирсэн энэ асуудлаа шийдвэрлэхийн төлөө дор бүрнээ хичээж ажиллах нь бол энэ цаг үеийн улс төрчид, та бидний эрхэм үүрэг юм. Зөв байсан, буруу байсан эсэхийг хожим түүх шүүнэ. Тийм учраас энэ дээр та хэд маань их мэргэн ухаанаар олон талаас нь асуудлыг шийдвэрлэж хараасай гэж хууль санаачлагчийн хувьд хэлье.

Эцэст нь дахиж хэлэхэд энэ дээр би парламентын гишүүд яг л өөр өөрсдийнхөө л саналаар Үндсэн хуульд хандаасай гэж бодож байгаа. Энэ дээр ямар нэгэн байдлаар ятгаж, ямар нэгэн байдлаар энэ дээр Засгийн газрын зүгээс лобби хийж асуудалд бол хандахгүй. Яагаад гэхээр энэ бол ард түмнээ төлөөлж байгаа, мандатын эрхийг хэрэгжүүлж байгаа, ард түмний бүрэн эрхт элч болсон парламентын гишүүд та бүхний онцгой бүрэн эрхийн асуудал юм. Бид нар зүгээр Засгийн газрын хувьд нэгэнтээ ингээд хийгдэх ёстой зүйлийг эс үйлдэл хийж үлдсэн гэдэг энэ агуулгаар хандахгүйн тулд бидний хувьд оруулж ирж байгаа. Тоо хэд байх, хувь тэнцүүлэх болон тойргийн төлөөллийн систем хэдэн хувь байх, бүр эцэст нь энэ нэмэлт,

өөрчлөлтийг хийх, үгүй эсэх нь гагцхүү парламентын онцгой бүрэн эрх.

Дахин хэлэхэд та бүхэн маань ард иргэдтэйгээ уулзаад, ярилцаж тайлбарлаад ингээд л та хэд маань асуудлаа 2 дугаар хэлэлцүүлэг, 3 дугаар хэлэлцүүлэг дээр шийдвэрлээд явах нь бол зүйтэй. Юутай ч бид нар өнөөдөр энийг олон талаас нь шүүн хэлэлцэж, гадаад нөхцөл ямар байна, дотоод нөхцөл ямар байна хийхгүй бол юу болох вэ, хийгдвэл юу болох вэ, ямар давуу тал байна, ямар сул тал байна гэдгийг нээлттэй өнөөдөр парламент дээрээ ярилцах нь л хамгийн чухал зүйл юм. Бид өөр хаана ярилцах вэ. Парламент дээрээ л ярилцахгүй гэдэг агуулгаар нь тайлбарлая. Тэгээд баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа. Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу хэлэлцэх эсэх асуудлыг Монголын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11, 12 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 5 сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч мажоритар сонгуулийн тогтолцоог дангаараа хэрэглэх нь иргэдийн санал гээгдэх тойргийн ашиг сонирхол улс орны эрх

ашгаас өндөрт тавигдах, олон нийтэд танигдсан хөрөнгө санхүүгийн боломжтой хүмүүст давуу байдал үүсгэх зэрэг сөрөг талыг бий болгож ирсэн.

Пропорциональ сонгуулийн тогтолцоог хэрэглэгчид хэрэглэхэд сонгогчдын санал гээгдэх нь бага, парламент дахь нийгмийн бүлгүүдийн төлөөлөл жигд хангагдах, бодлогын намыг төлөвшүүлэх зэрэг давуу талтай гэж үзжээ.

Иймд мажоритар болон пропорциональ аргын давуу талуудыг тусгасан сонгуулийн тогтолцоотой байх зохицуулалтыг тусгаж, сонгуулийн тогтолцооны тогтвортой байдлыг хангана гэж үзсэн байна.

1991-1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж батлах үед Улсын Их Хурлын гишүүдийн тоог тухайн үеийн нийт хүн амын тоонд үндэслэн нэг гишүүн дунджаар 27 мянган иргэнийг төлөөлөхөөр тооцоолж, 76 гишүүнтэй байхаар хуульчилсан.

Харин өнөөдөр нэг гишүүн дунджаар 44.7 мянган иргэнийг төлөөлөх болсон. Ингэснээр нэг гишүүний төлөөлөх иргэдийн тоо бараг 2 дахин нэмэгдэж, парламентын төлөөлөх чадамжийг бууруулж байна.

Парламентын засагтай олон улсад парламентад дунджаар 100 тавиас доошгүй гишүүнтэй байдаг нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт хяналт тэнцлийг хангахад чиглэдэг байна.

Тиймээс иргэдийг төлөөлөх парламентын чадавхыг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүдийн тоо хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын 76 гишүүнийг мажоритар, 76 гишүүнийг пропорциональ аргаар сонгохоор Монгол Улсын Үндсэн хуульд оруулах

өөрчлөлтийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Үндсэн хууль сонгуулийн тогтолцоог тодорхой зааж баталгаажуулснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо тогтвортой байх, намууд сонгуульд шударгаар өрсөлдөх, иргэдэд ойлгомжтой байх, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэний сонгох эрхийг баталгаажуулах ач холбогдолтой гэж мөн хууль санаачлагч үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэхтэй холбогдуулсан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Т.Доржханд, Ж.Батсуурь, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Б.Пүрэвдорж нар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Сарангэрэл, Г.Ганболд, Ц.Мөнхцэцэг, Ж.Батсуурь, Г.Занданшатар, Т.Доржханд нар улс төрийн намуудын төлөвшил, Улсын Их Хурлын гишүүдийн нөлөөллийн жинг бууруулах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тэдгээр нь бодлогын институт болж төлөвших нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн давхар бүлгүүдийн төлөөллийг хангах, улс төрийг мөнгөний нөлөөллөөс ангижруулах, төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, засгийн эрх мэдлийн хяналт, тэнцэл зохистой байх шаардлагатай талаар байр сууриудаа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын доошгүйн буюу 80 хувийн саналаар дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэг дэх хэлэлцүүлэх буюу хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Би цэцийн сийрүүлсэн албан бичгийг танилцуулсан.

Үндсэн хуулийн цэц 2022 онд холбогдох шийдвэрийг гаргасан болно гэдэг маань 2022 онд сонгуулийн тогтолцоо, тоотой холбоотой цэцийн шийдвэр гаргаж ирүүлснийгээ ингээд дурдаад, ийм цэцийн шийдвэр ирснийг би түрүүнд танилцуулсан учраас дахиж нуришихаа больё.

Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Ингээд Үндсэн хуулийн хэлэлцүүлэг явж байна.

Үүнтэй холбоотой ер нь Ардчилсан нам өнгөрсөн хугацаанд асар их ач холбогдол өгч тал талдаа ажилласан. Үндэсний бодлогын хороо хуралдсан. Оройжин шөнөжин хуралдсан.

Үүнтэй холбоотой саналууд хүргүүлсэн. Саналууд орсонгүй гэдэг яриа үүгээр нэлээн явсан.

Ер нь ямар санал хүргүүлсэн юм бэ гэдэг дээр би нэг томилоод хэлчихье. Үүнийг ард иргэд мэдэх ёстой байх. Сая 5 багц, 18 санал. Өмнө нь 2015 онд яг Үндсэн хуулийн асуудал яригдаж байхад 22 санал бүхий ийм төсөл бэлдэж байсан юм билээ.

Ер нь Ардчилсан нам өөрөө Үндсэн хуулийн асуудалд яг ямар саналууд дээр илүү түлхүү байр суурь илэрхийлж байсан бэ гэж.

Ер нь томоороо хувь тэнцүүлсэн тогтолцоо, холимог тогтолцоо гэдгийг Ардчилсан нам дэмжиж байгаа учраас өнөөдөр бид ч гэсэн энэ зарчмын байр суурийг үргэлжлүүлэх ёстой гэж үзэж байгаа юм.

Сүүлийн сая өгсөн 5 багц санал жишээ нь одоо ингээд эхнээс нь дурдвал Монгол Улсад цаазаар авах ялыг халъя. Цаазаар авах ялыг халъя. Үүнийг Үндсэн хуульдаа оруулж өгье гэдэг ийм хүрээний багц саналууд.

Хоёрдугаарт нь, эрх мэдлийн хуваарилалтантай холбоотой. Монгол Улс Үндсэн хуулиараа эрх мэдлийг хуваарилсан гэж байгаа мөртлөө яг одоо тодорхой зүйл, заалт байхгүй.

Улсын Их Хурал хязгааргүй бүрэн эрхтэй. Улсын Их Хуралд эргээж хариуцлага тооцох боломж байхгүй.

Засгийн газрын гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага гэсэн үг, өгүүлбэр өнөөдөр ч Үндсэн хуульд алга байна гэх жишээний ийм багц саналууд.

Дараа нь тэр шүүх тогтолцоо, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангахтай холбоотой бас нэг багц саналууд байгаа юм. Жишээ нь, энэ дотор гэхэд Монгол Улсын Дээд шүүх бол шүүх эрх мэдлийн дээд байгууллага биш. Монгол Улсын Дээд шүүх бол хяналтын шатын л шүүх.

Шүүх эрх мэдлийн дээд байгууллага гэхээр шүүхийн хараат бус байдалд бас халдах гээд байна гэдэг багц саналууд явж байгаа.

Дахиад нэлээн том чухал заалт бол энэ Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой бүлэг

заалтыг Үндсэн хуульд оруулъя гэдэг Ардчилсан намын ажлын хэсэг болоод үе үеийг нь судлаачдын, үе үеийн энэ байр суурийг илэрхийлж байсан хүмүүсийн саналууд.

Тавдугаарт нь, Үндсэн хуулийн өөрийнх нь дархлааг бий болгоё. Улам нэмэгдүүлье. Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг дордуулсан аливаа заалт оруулахыг сэргийлье гэсэн ийм багц заалт жишээ нь сая өгсөн саналууд дотор явсан байх жишээтэй.

2015 онд тэр 22 багц заалтаас гэхэд би зүгээр ганцханыг нь л уншихъя.

Засгийн газрын яамдын тоог тодорхой болгоё. Энэ 2015 оны санал жишээ нь. 9 яамыг зааж өгье, 3 яамыг яамыг тухайн үеийн Ерөнхий сайдад шинээр 3 хүртэл яам байгуулах эрх олгоё гэх мэтийг нь.

Ер нь ингээд харахад дандаа төрийн эрх мэдлийг хязгаарласан, иргэдийн эрх мэдлийг илүү тийм тэлсэн, шүүх эрх мэдлийг нь бие даасан тусгаар байдлыг хангахад чиглэсэн дандаа ийм заалтуудыг өнгөрсөн хугацаанд Ардчилсан намын зүгээс санал, санаачилга болгож ажиллаж байсан.

Тэгэхээр бид бүгдийн хувьд ч гэсэн энэ удаагийн хэлэлцүүлгүүдэд улс орны эрх ашгийг эрэмбэлэн дээдлээд ер нь Ардчилсан намын үе үед баримталж ирсэн энэ саналуудыг зарчим болгож бид бүгд энэ удаагийн Үндсэн хуулийн хэлэлцүүлгүүдэд оролцох болно гэдгээ хэлье.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Ингээд долоо хэмжиж нэг огтлох асуудал. Энэ бол.

Ингээд Засгийг газрыг, олонхыг бол долоо хэмжиж үзсэн байх гэж найдаж байна.

Тэгээд өнөөдрийн хэлэлцүүлэг галт тэрэг ингээд хөдөлж байна л даа. Хөдөлчихлөө гэж үзэж болно. Тэгээд олонх маань тэгээд энэ галт тэргэндээ жаруулаа сууж чадсан уу? Уг нь та нар чинь 62 билүү. Одоо 60 байгаа байх.

Энэ Үндсэн хуулийг өөрчлөхөд хоёр зам байгаа. Тийм ээ. Нэг нь, ард түмнээс санал асуух. Нөгөөдөх нь бол 57 кноп.

Тийм 57 кноп та нарт байгаа.

Тэгээд Ерөнхий сайд бол ярьж байна л даа.

Энэ хийх гэж байгаа өөрчлөлтдөө итгэл үнэмшилтэй байх ёстой. Тэр “Алсын хараа-2050”, 30 жилийн дараа харах энэ юмыг бүгдийг нь багтааж авах ёстой.

Та бүхэн бол одоо 100 жил болсон нам. Өнөөдөр Монгол Улсын ачааг нуруундаа үүрээд явж байна. Хэрвээ энэ 60 нөхөр чинь энэ галт тэргэн дээр хамт суучаад энэ 60 нөхдүүдээ ойлгуулж чадаагүй юм бол цаашаа явах юм уу, үгүй юм уу?

Тэгээд татчихаж магадгүй юм яриад байна. Ийм хариуцлагагүй юм байж болохгүй. Татах гэж байгаа бол одоо тат. Засгийн газар хэзээ дуртай үедээ татаж болно гэж хэлж байх шиг байна.

Тэгээд цаг хугацаа үрээд, баахан олон түмнийг үймүүлээд ийм юм хийж болохгүй.

2019 онд Үндсэн хуулийг та нар өөрчилсөн. Тэр Үндсэн хуулийнхаа өөрчлөлтөөр 2022 оны 08 сарын 29-нд ухарсан. Бараг Үндсэн хуулийн манаач буюу Үндсэн хуулийн цэцтэй хамтарч хулгай хийсэн. Баахан хүмүүс сандал ширээ, суудлаа бэхжүүлсэн.

Энэ өөрчлөлт бол Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүн байгаад харилцан хяналттай Засгийн

газар, Улсын Их Хурал хууль тогтоогч байх ийм л боломжийг бий болгож байгаа юм.

Одоо энэ юм бол байхгүй болчихсон шүү дээ. Тэр дээр анхаар. Тэрийгээ олигтойхон тайлбарла. Та бүхэн ард түмэнд очиж үүнийгээ сайхан ярь, тайлбарла, ойлгуул.

Нөгөө талаар Ерөнхий сайд яав. Намайг андуурав уу, эндүүрэв үү. Миний жоохон хоолой сөөчихсөн байгаа шүү. Аргагүйн эрхэнд л би ярьж байна. Тийм.

Би нэг их өрөөнд нь ороод л, Ерөнхий сайдтай нэг юм яриад л, гарч ирээд нэг юм яриад байгаа юм ёстой байхгүй шүү. Хүнтэй андуураад байх шиг байна. Би Ерөнхий сайдтай сүүлийн нэг жил бараг уулзаагүй байх.

Харин Японы Ерөнхий сайд Ф.Кишидатай, Их Хурлын даргатай уулзаад байгаа. Ганц нэг хундага юм татаад байгаа. Тийм.

Тантай бол амжихгүй л яваад байгаа. Тийм.

Тэгээд нөхдүүд минь наад юмаа хариуцлагатай хийгээд хариуцлагатай яваарай. Ачаагаа үүрсэн шиг үүрээд ард нь гараарай. Тэгэхгүй Монголын ард түмнээр тоглоод байж болохгүй шүү.

Тэгээд өнөөдөр цаг хугацаа хожиж байгаа юм шиг талбай дээр нэг жагсаал болохгүйн тулд иймэрхүү санаагаар Үндсэн хуулийн өөрчлөлтийг оруулж ирээд л татаад. Ийм юм байхгүй.

Үүнийгээ сайн боловсруулаад сайн судалгаа шинжилгээ хийгээд ингээж хийсэн юм байгаа биз дээ. Тэр вагондоо хөдөлсөн жаруулаа та нар багтаарай. Та нарт хангалттай тэр 57 кноп чинь байна. Тийм. Энэ юмыг чинь хэлчихье.

Тэр хариуцлагаа үүр. Дараа нь тэгээд ирээдүй чинь харуулна. Цаг

хугацаа чинь харуулна. Зөв зүйтэй гэсэн бол тэрийгээ хий. Бүх хууль ёс, эрх мэдэл нь та нарын гарт байна.

Өнөөдөр олон түмэн маш их бухимдалтай байгаа. Энэ олон хэрэгтэй, хэрэггүй дарга нар, энэ олон Улсын Их Хурлын гишүүдийг бид нар яаж тэжээх юм гэж байгаа.

Гэтэл тэрнээсээ их хулгайчдыг тэжээж байгаа шүү дээ. Бид нар. Тэнд маш их бухимдалтай байна. Энэ юмны үнэ хани дийлдэхээ байлаа. Тэгээд зарим нь юу билээ 200 мянгаар сар болдог гээд л байх юм. Тийм юм байхгүй шүү дээ. Бүгдээрээ л 20, 30 саяар сар болгож байгаа улсууд шүү дээ. Та нар бол.

Монголын ард түмэн бол тийм байна шүү үнэхээр. Тийм. 200 мянгаар л амьдрал ахуйгаа явж байна.

Энэ чинь тэтгэврийн 500 мянга нь юугаар нь эмийг нь авах юм, юугаар нь өөрийгөө амьдрах юм, тэжээх юм гэж ийм бодолтой ийм амьдрал хэцүү байна. Үүнийгээ орон нутгаараа яваад мэдэр.

Тэгээд энэ сайхан өөрчлөлтийг хийгээд. Сайхан ч гэж дээ. Ямар ч юм. Тийм ээ.

Тэгээд Монголын ард түмний хөл хөсөр, гар газар ингээд сайхан жаргаана гэдэг тэр үлгэрээ яриад, тэгээд итгүүлээд, үнэмшүүлээд ирэхийг чинь харъя. Тийм.

Тэгээд энэ өөрчлөлт чинь явахгүй бол олон түмэн, энэ Их Хурал чинь Засгийн газарт итгэхгүй байна л гэсэн үг шүү дээ. Тийм.

Энэ Засгийн газраас гаргасан санал, санаачилга. Монгол Ардын намын дарга, Монгол Ардын намын бодлогыг энэ Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөхгүй байна л гэсэн үг шүү дээ. Тэрийгээ та нар хариуцлагатай ойлгож байгаа юм байгаа биз дээ.

Би ахиад хичээл заалтай биш дээ. Та нарт. Аягүй бол дуусгахгүй юм болно. Баярлалаа. Ингээд дуусгая.

Г.Занданшатар: Болсон уу. Гишүүд үг хэлж дууслаа.

Энэ гишүүдийн асуулт хариулт, сая санал бодлоо илэрхийлж байгаа төлөв байдлаас сая хэлсэн энэ тоо нэмж байгаа үндэслэл, аргументыг ажлын хэсэг зөвхөн нөгөө сонгогчдын тоо нэмэгдсэн, куб язгуурын томъёо зэргээр үндэслэж байгаа нь хязгаарлагдмал байгаа гэдгийг сануулаад ажлын хэсэгт чиглэл өгөх, бас гишүүдэд тойрог, орон нутагтаа ажиллахад нь мэдээлэл өгөх зорилгоор нэг зүйлийг тодруулж хэлье.

Ер нь ардчилсан парламентын хүчтэй ардчилсан байх шинж чанар Олон улсын парламентын холбооноос гаргасан зарчмаар 5 кредит шалгуур үзүүлэлтээр тодруулсан.

Нэгдүгээрт нь, төлөөлөх чадвар. Төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлж байгаа төлөөлөх чадвар.

Хоёрдугаарт нь, нээлттэй. ил тод байдал. Энэ манайд байна. Бүх юм нээлттэй, ил тод явж байна.

Гуравдугаарт нь, ард иргэдийн оролцоог хангасан хүртээмжтэй байдал. Бид зөвлөлдөх санал асуулга, D-Parliament, ард иргэдийг сонсох, тойрог сонгогчидтойгоо уулзах энэ ажлуудыг зохион байгуулж байгаа.

Цар тахлын үед ер нь хаягдсан. Энэ бол алсарсан асуудал болсон. Одоо тойрогтоо.

Энэ хагас сайнаас эхлээд долоо хоногийн хугацаатай ажиллана. Энд чинь хэрэгтэй болов уу гэж мэдээлэл өгч байна.

Дөрөвдүгээрт нь, энэ төсвийн хараат бус байдал, бие даасан байдал,

харилцан хяналт, тэнцлийг хэрэгжүүлж байгаа байдал.

Үүнээс болоод нэр хүнд унаад байдаг энэ тоотой холбоотой нэг асуудал бол эрх мэдлүүд харилцан уусах юм бол бие биедээ харилцан хяналт тавьж байх ёстой хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлүүд харилцан бие биедээ уусах юм бол энэ авлигал хээл хахууль гаарч, энэ төрийн эрх барих дээд байгууллагуудын нэр хүнд унаж байгаа нэг шалтгаан болж байгаа юм.

Олонхын бүлгийн хоёр юм уу, гурван хүний нэг нь сайд, дарга болохоор тэрүүгээр дамжаад нөлөөлөөд, одоо янз бүрийн авлига, тендер, зээл хууль бүх юманд оролцоод байна гэсэн ийм. Энэ маань бүх уналтын үндэс болж байгаа юм? Энэ чинь тоо нэмэх нэг үндэслэл.

Тэгээд тоо нэмэх хоёр дахь гол үндэслэлийг энэ ажлын хэсэгт олон удаа хэлж байгаа.

Ойлгохгүй байгаа учраас гишүүдийг анхааруулж маш тодорхой нэг зүйл хэлье гэж бодож байна.

Ерөөсөө төлөөллийн чадвар гэдэг маань, төлөөлөх чадвар маань гэдэг маань 3 зүйлээс бас тогтож байгаа юм.

Нэгдүгээрт нь, тойрог төлөөлөх. Сонгуулийн тойрог гэдэг бол хүн ам, нутаг дэвсгэр хоёрын хоёуланг нь төлөөлж байгаа юм. Тойрог гэдэг бол.

Хоёрдугаарт нь, сонгогчдыг төлөөлнө. Энэ бол хүн ам гэж бидний яриад байгаа нэг л үзүүлэлт нь. Тэр хүн амын тоо өссөн гээд.

Гуравдугаарт нь, сонгогчдын бүлэг, кластер, анги, хэсэг.

Ийм 3 зүйлийг төлөөлж чадаж байна уу, үгүй юу гэдгээр энэ төлөөллийн чадавхыг тодорхойлдог юм.

Тэгтэл зөвхөн хүн амын төлөөллөөр харгалзчихаар иргэд чинь Энэтхэгтэй харьцуулаад л, хүн ам ихтэй улсуудтай харьцуулаад л, та нар битгий худлаа яриад бай гээд байна шүү дээ.

Тийм учраас энэ дээр би нэг жишээ хэлье. Австралийн парламент. Одоо манай Ч.Хүрэлбаатар сайд сайн мэдэх ёстой.

Тасманы арал 531-хэн мянган хүнтэй. Ньюс Саут Уэльс бол 8 сая хүнтэй. Яг адилхан гишүүдтэй. Яагаад гэвэл тойрог төлөөлж байгаа учраас.

Тэр газар нутаг, нутаг дэвсгэрийн төлөөлөл чухал учраас. Энэ улс орны аюулгүй байдал. Нэн ялангуяа нутаг дэвсгэрт томтой улс.

Монгол Улс дэлхий дээр нэгд ордог хүн ам тархуу суурьшсан улс. Уудам нутаг дэвсгэртэй. Энэ харгалзан үзэх зайлшгүй хүчин зүйл байгаа юм.

Одоо жишээлбэл Америкийн Нэгдсэн Улс байна. Муж болгоноос 2 квооттой, суудалтай. Сенат.

22 сенат 22 мужийн нийт хүн ам 38 сая байдаг. Энэ 22 мужаас тус бүр 2 гэхээр 44 хүн төлөөлж байдаг. Тэгтэл 38 сая хүн амтай Калифорниа. Хамгийн олон хүн амтай Калифорниа муж 2-хон суудалтай.

Өөрөөр хэлбэл заавал хүн амаараа ингэж тооцдоггүй. Энэ төлөөлөл, тойрог сонгуулийн тойрог. Ийм учраас Сонгогчдын зөвлөл Электрол коллеж буюу одоо Бүгд найрамдахчууд нь хөдөө орон нутагтаа фермерүүдийн ч юм уу дэмжлэгийг, илүү санал авдаг учраас энэ тогтолцоог өөрчлөхгүй гэхэд Ардчилсан нам нь хүн ам ихтэй газраасаа санал авдаг байх жишээтэй.

Энэ чинь өөрөө амьдралын хэв маяг, ардчиллын үнэт зүйл байхгүй юу. Энэ чинь зөвхөн хүн амын тооноос хөөцөлдөх чинь ингээд алдаатай тайлбар

болоод байгааг ажлын хэсгийг анхаарч манай гишүүд хөдөө тайлбарлахдаа үүнийг ярьж явмаар байгаа юм.

Япон ч гэсэн нэг муж, нэг хүн төлөөлнө. Хүн амаас үл хамаараад.

Хэрвээ хүн амаас хамаараад явчих юм бол энэ жижиг аймаг хүнгүй, хүн төлөөлөх шаардлагагүй. Тэр хоосорно, эзгүйрнэ. Газар нутаггүй бол улс орон үгүй. Газар нутаг улсын үндэс. Тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндэс. Улаанбаатар улс болж хувирна.

Энэ бол 76 гишүүний яг тойрогт төлөөлсөн хэвээр нь байлгах нэгдэх үндэслэл байгаа юм.

Тэгтэл цаана нь бид сонгогчдын хэсэг, бүлгийг төлөөлдөг тоо алга болчихоод байна. Тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг, тэр малчдыг, тэр багш, эмч нарыг. Кластер буюу анги давхаргыг төлөөлөх төлөөлөл байхгүй байна. Үүнийг чинь нэмэх гээд байна. Ахиад 76-гаар.

Энэ бол гол үндэслэл юм шүү гэдэг энэ зарчмаараа бид нар энэ хосолмол тогтолцоог зэрэгцүүлж авч, тэгээд ардчиллын мөн чанарыг хийхгүй бол.

Унгарын парламентын даргатай би өчигдөр санал солилцсон. Хэлж байна лээ.

Манайх 199 гишүүнтэй. 103 нь мажоритараар, 96 нь пропорционалиар сонгогддог. Тогтвортой.

Герман энэ тэрийнх бол хуучин социалист манай улсад тохирохгүй. Танайх шиг улсад тохирохгүй. Манайх хуучин социалист байсан. Адилхан бас төстэй улс учраас.

Манайх 9.7 сая хүн амтай. Ийм хосолмол тогтолцоо бол ардчиллын санал гээгддэг, сонгогчдын төлөөлөх чадвар хаягддаг энэ бүх юмыг нөхсөн сайн тогтолцоо юм.

Ингэвэл ардчилал бэхэждэг юм шүү.

Тэгээд дэлхийн улсуудыг хараарай. Дангаараа мажоритар тогтолцоотой улсууд. Одоо Африкийн хэчнээн улс байна, Европын хэдэн улс байна гээд.

Тэгээд энэ бол бас ардчиллыг бэхжүүлдэг, төлөөлөх чадавхыг сайжруулдаг нэг гол үзүүлэлт учраас үүнийг нэг харгалзаж үзмээр байгаа юм.

Дараагийн нэг үндэслэл нь бол тэр давхар дээл. Ерөөсөө гүйцэтгэх эрх мэдэл болон хууль тогтоох эрх мэдэл бол харилцан уусах ёстой.

Сонгогчид өгсөн амлалтаа хэрэгжүүлэхийн тулд. Мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн тулд.

Гэхдээ энэ хяналт, тэнцлийг алдагдуулаад байна. Өнөөдөр манай энэ тооны гажуудал маань.

Ийм учраас гишүүдийн тоо нэмэгдүүлэх зайлиггүй шаардлага эндээс урган гарч байна.

Европын парламент байна, Шинэ Зеланд байна. Дандаа нөгөө нутаг дэвсгэрийг тэнцүү. Тойргийг тэнцүү төлөвлөж байгаа байхгүй юу. Хүн амын ялгаагүйгээр.

Ийм учраас би нутаг дэвсгэрийн төлөөлөл гээд газар нутаг улсын үндэс. Тэрний төлөөлөл гэж би ажлын хэсгийнхэнд хоёр, гурван удаа хэлсэн. Үүнийг сая тайлбарууд дээр ерөөсөө нарийвчилж судлахгүй хаяад байгаа учраас.

Нэн ялангуяа манайх шиг том нутаг дэвсгэртэй улс. Францаас 4 дахин том нутаг дэвсгэртэй улс шүү дээ. Газрын баялагтай улс. Дэлхий дээр газрын баялгаараа дээгүүр ордог улс.

Ийм учраас энэ тусгаар тогтнол, эдийн засаг, уул уурхайн энэ хөгжил шаардлага маань нутаг дэвсгэрт тойргийн төлөөллийг хадгалах зайлиггүй шаардлага бий болгож байна гэдгийг сайн үндэслэж бодож энэ асуудлуудыг цаашидаа иргэд, сонгогчидтой уулзахдаа үндэслэлээ ярихгүй бол зөвхөн ингээд хүн ам өсчихсөн юм. Ингээд механикаар хэлэхээр чинь хүмүүс тэр Энэтхэгийг хар, тэр Германыг хар гээд ингээд шууд тоонд хуваачхаад байна.

Ер нь дэлхий дээр куб язгуурын томъёог хэрэглэдэг боловч ерөөсөө нийтлэг томъёолол байхгүй юм байна гэж улс төр судлаачид эрдэмтэд тохирсон байхгүй юу.

Парламентын гишүүдийн тоог тогтооход нийтлэг томъёо байхгүй. Харин энэ нутаг дэвсгэр, улс орны онцлог, геополитикийн нөхцөл байдал.

Манай улсын геополитикийн онцлог, аюулгүй байдлын онцлог, газар нутгийн уудам дэвсгэрт дэлхий дээр хамгийн тархуу суурьшидаг хүн амтай улсын энэ онцлог байдалтай тохируулж ийм өөрчлөлт зайлиггүй хийх аюулгүй байдлын болон эдийн засаг, геополитикийн шаардлага, уул уурхай, эдийн засаг энэ бүх юм чинь ийм шаардлага бий болгож байна гэдгийг бас үндэслэлүүд дээрээ манайхан ажлын хэсэг нарийвчлан судлаад гишүүдийг хөдөө явахад нь, тойрогтоо ажиллахад нь энэ үндэслэлийг сайн боловсруулж өгмөөр санагдлаа.

Ингээд энэ дээр удирдамж сая баталлаа.

Маргаашаас эхлээд Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо 15-ны өдөр хүртэл ажлын долоо хоног ажиллаж, энэ мэдээллүүдийг өгч саналаа авна.

Ажлын хэсэг байгуулагдаж байгаа. Үүнийг ингээд санал хураалтын дараа тараад явчих учраас би энэ мэдээллүүдийг өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Хэрвээ шаардлагатай бол энэ талаар бүр дэлгэрэнгүй 2019 онд судалж байсан судалгаа материалынхаа талаар бүлгүүдэд танилцуулж ярьж болно.

Одоо ингээд санал хураалт явуулна. Гишүүд үг хэлж дууслаа. 6 минут үг хэллээ.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12.1.10-д төслийг цаашид хэлэлцэх эсэх талаар зөвшөөрнө, татгалзана гэсэн томъёоллоор санал хураана гэж заасны дагуу Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэснийг зөвшөөрье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад гишүүд анхааралтай бэлдээрэй. Зөвшөөрье гэсэн. Зөвшөөрье гэдгийг дэмжье гэсэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

59 гишүүн дэмжиж, 96.7 хувийн саналаар Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэхийг гуравны хоёроос дээшийн саналаар зөвшөөрлөө.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар дэмжье гэсэн биш зөвшөөрөх, татгалзах гэсэн хоёр саналын томъёоллоор санал хураалцаж байгаа учраас зөвшөөрье гэдэг нь илүү нөгөө хууль зүйн нэр томъёо нь байгаа юм.

Ингээд гуравны хоёроос дээш хүн саналаар буюу одоо 96.7 хувийн саналаар зөвшөөрсөн тул төслийг нэг дэх хэлэлцүүлгийг хийсэнд тооцон хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

17.20 цаг

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Одоо дараагийн асуудалд орно. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 54 дүгээр тогтоолоор Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт, тэнцлийг хангах хүрээнд төрийн эрх барих дээд байгууллагад ард түмнийг төлөөлөх Улсын Их Хурлын гишүүдийн тоог шинэчлэн тодорхойлох, Улсын Их Хурлын сонгуулийн дэвшилтэт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасантай холбогдуулж Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлсэн билээ.

Энэхүү төсөлтэй уялдуулан Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн 1 дүгээр зүйл буюу Улсын Их Хурлын гишүүдийн 76-г мажоритар аргаар, 76-г пропорциональ аргаар сонгоно гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Их Хурлын

2020 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй гэсэн заалтыг тусгасан болно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгах заалтыг тусгалаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданишатар: Төслийн талаарх Төрийн байгуулалтын байгуулалтын санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүд өмнөх Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийн ажлын хэсэгтээ нэр, овог, ажил, албан тушаал нэг адил. Протоколтой гэж тэмдэглэгдье.

Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу? Дэмжсэн, дэмжээгүй. Алга байна. Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Тэгээд маргаашаас эхлүүлээд гишүүд орон нутгаар явж уулзалт хийх юм байна.

Тэгэхээр би өнгөрсөн хугацаанд аймаг, орон нутгийн дэмжлэгээр ер нь уулзалт хийж байгаагүй.

Тийм учраас энэ удаа төрийн ажлыг явж, өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар уулзалт хийх юм байна.

Тийм учраас Их Хурлын дарга тодорхой чиглэл өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ уулзалтыг зохион байгуулах тал дээр. Ялангуяа Ардчилсан намын

засаг барьж байгаа аймаг, сумууд ч байна, Монгол Ардын намын засаг барьж байгаа аймаг, сумууд ч байна. Харилцан тэгшээр иргэдийг оролцуулах ажлуудыг зохион байгуулах тал дээр, иргэдийн оролцоог сайн байлгах тал дээр.

Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн өөрчлөлт гэдэг бол Монгол Улсын тусгаар тогтнолын бас баталгааг тодорхой хэмжээгээр хөндөж байгаагийнхаа хувьд иргэдийн оролцоо их байж байж, тэр итгэлцэл сайн байж байж энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр явах ёстой гэж ийм зарчмын байр суурьтай байна.

Тийм учраас энэ ажлыг зохион байгуулах тал дээр янз янзын тээг тавихгүйгээр Их Хурлын гишүүдийн хурлын үйл ажиллагааг амжилттай болгох тал дээр Их Хурал, Засгийн газраас, ялангуяа санаачлагч Засгийн газраас тодорхой чиглэлүүдийг орон нутагт өгөх ийм шаардлага гарч ирж байна.

Маргааш орой 6 цагт би Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум дээр уулзалт хийгээд эхэлнэ.

Тэгээд 10 гаруй сумаар явна. Манай хоёр гишүүн бас сумуудаар явах ёстой.

Тэгээд дээрээс нь зөвхөн хоёр асуудлаар биш урьд нь Үндсэн хуулийг өргөн барих явцад ямар ямар саналуудыг гаргаж байсан. Тэр нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр больсон тэр асуудлуудаар бас тодорхой мэдээллүүдийг бид нар ард иргэдэд өгөх ёстой. Ийм ийм ажлуудыг хийх хүрээнд зохион байгуулалтын хувьд нэлээн өргөн далайцтай арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Ингээд энэ талаар бас тодорхой санаачилгатай ажиллаарай гэж Их Хурлын удирдлага болон Засгийн газрын удирдлагаас хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн маш чухал асуудал хөндлөө.

Тэгэхээр гишүүд анхааралтай байж байгаарай. Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах тухай Улсын Их Хурлын тогтоол батлах ёстой. Тойрогтоо ажиллахтай холбоотой удирдамж ажлын.

Тэгээд эргэж орж ирээд санал хураалт явна. Тогтоолоо батална. Тэгэхээр тэр тогтоол дээрээ аймаг, нийслэлийн Засаг дарга, Хэрэг эрхлэх газарт чиглэгч гишүүдийн уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, ард иргэдийн оролцоог бүрэн хангах, эрдэмтэн судлаачид, мэргэжил сонирхлын бүлгүүдийн хэсэг бүлгээрээ уулзалт, арга хэмжээнүүдийг яам, Тамгын газар чиглэл чиглэлээрээ зохион байгуулах ийм чиглэл өгье гэсэн зарчмын санал Б.Пүрэвдорж гишүүн гаргаж байна.

Үүнийг Төрийн байгуулалтын байнгын хороо тогтоол дээрээ тусгаад чиглэлийг өгөөд, богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулахаар чиглэл өгөх нь зүйтэй гэж бодож байна. Одоо санал хураалт явуулна.

Тэгэхээр гишүүдэд зарлан мэдээлэх нь. Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад тогтоолын төслөө хэлэлцээд эргэж орж ирээд бид Улсын Их Хурлын тогтоолыг Үндсэн хуулийн өөрчлөлтийг хэлэлцүүлэх тухай, ард иргэдээр хэлэлцүүлэх тухай асуудлаар тогтоолын төслийг батлах ёстой.

Тийм учраас гишүүд тарахгүй энэ тогтоолын төслөө батлаад чиглэлээ авчхаад тарна шүү гэдгийг би анхааруулж байна. Төрийн байгуулалтын байнгын хороо үүний дараа шуурхай хуралдаад тогтоолын төслөө хэлэлцэх ёстой.

Гишүүд үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

59 гишүүн дэмжиж, 96.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

17.28 цаг

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд “Жанжин Д.Сүхбаатарын танхимд одоо цуглана.

Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдах болсон тул хуралдаан 17 цаг 28 минутаас 17 цаг 53 минутад түр завсарлав.

Г.Занданшатар: Хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 5-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаа үргэлжлүүлье. Түр завсарласан.

Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийг өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дугаар хэлэлцүүлэгт бэлтгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

Энэ хооронд баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсгоё. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

5. “Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Пүрэвдорж гишүүнээ хууль тогтоолын энэ эцсийн найруулгуудыг уншсан та саналтай байсан уу, үгүй юу? Хууль тогтоолын эцсийн найруулга дээр бол горимын санал гэж байхгүй л дээ.

Гурав. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнийг индэрт урьж байна. Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна уу.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа, Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд ишлэжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Адъяаа, Батсуурь, Доржханд, Нямбаатар, Сарангэрэл, Тогтохсүрэн, Цогтгэрэл, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулахаар тогтлоо.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх нь хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна, байхгүй байна уу тийм ээ? Байхгүй байна, дахиж лавлалаа. Алга байна.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулна. Сая танилцуулсан тогтоолын агуулга бол ажлын хэсэг байгуулж байгаа.

2 дугаарт иргэд, сонгогчидтой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах чиглэлийг тодорхойлж байгаа ийм агуулгатай тогтоол батлах гэж байна. Ингээд санал хураалт явуулъя. 38 гишүүн дэмжиж, 77.6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Байж байгаарай. Тогтоолыг уншиж танилцуулъя. Тогтоол хэрэгтэй. Дэлгэрсайхан гишүүн сая юу гэсэн бэ? Жаргалмаа гишүүнд сая нэг юм хэллээ. Миний талаар юм ярьсан уу, үгүй юү? Тогтоолын төсөл хаана байна вэ? Адъяасүрэн гишүүн хаана байна вэ, Ганбат гишүүн хоёр? Маргаашаас олдохгүй болчхож магадгүй, Баянхонгор аймагт явах асуудлыг. Ирж л явна. Энэ чинь бас нягталж шалгахгүй бол бас.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсгийг үндэслэж, Улсын Их Хурлаас тогтоох нь, үндэслэн Улсын Их Хурлаас тогтоох нь:

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав

дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, гишүүд Ширнэнбаньдын Адьшаа, Жамбын Батсуурь, Тогмидын Доржханд, Хишгээгийн Нямбаатар, Даваажанцаны Сарангэрэл, Дуламдоржийн Тогтохсүрэн, Одонгийн Цогтгэрэл, Баттөмөрийн Энхбаяр.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр, гурав дахь хэлэлцүүлгийн бэлтгэлийг холбогдох хуульд заасан хугацаанд багтаан хангаж ажиллахыг Ажлын хэсэг Нямаагийн Энхболдод даалгасугай.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэгт болон Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлж ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газар Өлзийсайханд даалгасугай.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, санал бодлыг нь сонсох ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, холбогдох зардлыг гаргахыг засгийн Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэд үүрэг болгосугай.

Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

Зургаа. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй. 5 дугаар заалт. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

П.МЯДАГМАА

Д.ОТГОНДЭЛГЭР

П.ОЮУНГЭРЭЛ

Э.СУВД-ЭРДЭНЭ

Ц.АЛТАН-ОД